

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн
Боловсрол, шинжлэх ухааны салбарын чиглэлээр тусгагдсан зорилт
арга хэмжээний 2021 оны хэрэгжилтийн тайлан.

Д/д	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг)	2021 оны зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хүрсэн түвшин, үр дүн	Хэрэгжилтийн хувь
<i>НЭГ. КОВИД-19 ХАЛДВАРТ ЦАР ТАХЛААС ҮҮДЭЛТЭЙ НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ХҮНДРЭЛИЙГ ДАВАН ТУУЛАХ БОДЛОГО</i>							
1	1.1.11. Төрийн өмчийн дээд боловсролын сургалтын байгууллагад сувиллагч мэргэжлээр суралцагчдад сурлагын амжилттай нь уялдуулан 100 хүртэл хувийн тэтгэлэг олгоно.	1. Төрийн өмчийн дээд боловсролын сургалтын байгууллагад сувиллагч мэргэжлээр суралцагчдад сурлагын амжилттай нь уялдуулан Засгийн газрын тэтгэлэг олгоно.	2020 - 2024	42,702.8	280-350 суралцагчдад сургалтын тэтгэлэг олгосон байна.	Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 1 дүгээр сарын 13-ны өдрийн "Оюутны талаар авах зарим арга хэмжээний тухай" 13 дугаар тогтоолын 2 дугаар заалтаар "Журам шинэчлэн батлах тухай" Засгийн газрын 2014 оны 3 дугаар сарын 7-ны өдрийн 71 дүгээр тогтоолоор баталсан "Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид суралцагчийн тэтгэлэг олгох журам"-ын 4.1.9 дэх заалтын "төрийн өмчийн" гэсний дараа "болон төрийн бус өмчийн" гэж нэмж, энэ хичээлийн жилд өмчийн хэлбэр харгалзахгүй бүх сувиллагч мэргэжлээр суралцагчид тэтгэлэг олгохоор болсон. Түүнээс гадна тус тогтоолын 3 дугаар заалтаар мөн журмын 4.1.9 дэх заалтын элсэлтийн ерөнхий шалгалтын "501"-ээс дээш оноог 2020-2021 оны хичээлийн жилд "450"-аас дээш байхаар тооцож мөрдөхөөр болгосон. Үр дүн: Сувиллагч мэргэжлээр суралцагчдад 2020 онд 625.1 сая төгрөгийг 843 оюутанд олгосон бол 2021 онд 1417 оюутанд 1.8 тэрбум төгрөгийн тэтгэлэг олгосон. Засгийн газрын 2021 оны 13 дугаар тогтоолоор төрийн бус өмчийн их, дээд сургуульд сувиллагч мэргэжлээр суралцагчдад тэтгэлэг олгох болсон тул тэтгэлэгт хамрагдагсдын тоо нэмэгдсэн.	100%
2	1.1.12. Цахим сургалтын платформ бий болгож, цахим агуулга хөгжүүлж, бэлтгэнэ. Зурагт болон интернэтгүй өрх, хүн амыг цахим сургалтад хамрагдах боломжийг бий болгохын тулд тохирсон сургалтын хэлбэр,	1. Сургалтын удирдлагын системийг нэвтрүүлж, цахим хичээлийн сан бүрдүүлэн сонголттой хувилбарыг бий болгоно.	2020 - 2024	улсын төсөв	Сургалтын удирдлагын системийг ЕБ-ын 45 сургуульд туршилтаар нэвтрүүлсэн байна.	Үндэсний хэмжээнд цахим сургалтын нэгдсэн платформыг хөгжүүлэх, түүгээр дамжуулан бүх нийтэд зориулсан цахим контент боловсруулах, сургалтад ашиглах зорилгоор MEDLE.mn платформыг 2021 оны 6 сараас эхлэн хөгжүүлж байна. Одоогийн байдлаар энэ платформд 1-12 дугаар ангийн 419 хичээл байршиж, 1.0 сая иргэн хандсан статистик гарсан байна. Танхимын сургалт зайн, цахим хэлбэрт шилжсэн 2 жилийн хугацаанд боловсрол, сургалтын үйл ажиллагаа тасралтгүй байх зарчим баримтлан 5,756 теле хичээл, 104 интерактив хичээл, 2,775 цахим хичээл, 50 цахим контент, радио болон аудио 30 хичээлийг тус тус бэлтгэн тэгш, хүртээмжтэй байдлыг хангах зорилгоор дохионы хэл, тува, казах хэлний орчуулгатайгаар телевиз, радиоогоор дамжуулан хүргэх ажлыг телевизүүдийн холбоо, хувийн хэвшил болон олон улсын	100%

	хувилбаруудыг судалж, бэлтгэнэ.					<p>байгууллага (Монгол дахь НҮБ-ын Хүүхдийн сан)-тай хамтран зохион байгууллаа. Цар тахлын үед төгсөх ангийн сурагчдад зориулсан онлайн сургалтын талбарыг үүсгэн цахим хичээлийг улсын хэмжээнд X-XII ангид хичээл зааж байгаа шилдэг 602 багш удирдаж, хот, хөдөөгийн сургуулийн ахлах ангийн 30.1 мянган сурагч онлайн хичээлд хамрагдсан.</p> <p>Цахим контент бэлтгэх, цахим хичээлийн санг бүрдүүлэх, баяжуулах, сургалтад мэдээллийн технологийг бүрэн ашиглах, гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлийн үед хичээл, сургалтын бэлэн байдлыг хангах зорилгоор улсын төсвийн 1.2 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар 21 аймаг, нийслэлийн боловсролын газар, ерөнхий боловсролын 45 сургуульд цахим контент бүтээх бичил студи байгуулсан. Сурлагын хоцрогдлыг нөхөх, арилгах хүрээнд хэрэгжүүлэхээр ажиллаж буй дараагийн асуудал бол ахлах ангийн сурагчид аймаг, сум, дүүргийн сургуульд сурч байгаагаас үл хамаарч сонгон судлах хичээлээ сургалтын нэгдсэн платформ ашиглан улсын шилдэг багш нараар заалгах боломжийг бүрдүүлэх ажлыг эхлээд байна. КОВИД-19 цар тахлын улмаас боловсролын салбарт үүссэн хүндрэлийг даван туулах чиглэлээр Азийн хөгжлийн банк, Дэлхийн банк, ЖАЙКА-ийн Монгол дахь төлөөлөгчийн газраас хэрэгжүүлж буй төслийн хүрээнд 22 тэрбум төгрөг, Боловсролын төлөөх дэлхий нийтийн түншлэл (GPE) олон улсын байгууллагаас 14 тэрбум төгрөг, Азийн хөгжлийн банкнаас 3 тэрбум төгрөгийн техникийн туслалцааг 2022-2023 онд үзүүлэхээр төлөвлөөд байна. Эдгээр төсөл, хөтөлбөрийн хүрээнд боловсролын салбарын цахим шилжилтийг дэмжих, сурагчдын сурлагын хоцрогдлыг арилгах, багшийн мэдээлэл технологийн мэдлэг чадварыг дээшлүүлэх, цахим сургуулийн жишиг загвар бий болгох зэрэг үйл ажиллагаа хэрэгжүүлнэ.</p>	
3	1.1.13. Цахим сургалтын тогтолцоог бий болгох хууль, эрх зүйн орчныг бүрдүүлнэ.	1. Боловсролын болон бусад холбогдох хууль тогтоомжид нэмэлт өөрчлөлт оруулах, дүрэм журмыг шинэчлэн боловсруулна.	2020 - 2024	улсын төсөв	Боловсролын багц хуульд цахим сургалтын талаарх заалтыг оруулсан байна.	<p>Боловсролын ерөнхий хуулийн төсөлд боловсрол эзэмших сургалт нь танхимын, танхимын бус, холимог хэлбэртэй байх, танхимын бус сургалтад зайны болон цахим, эчнээ сургалт хамаарах, түүнчлэн холимог сургалт нь танхимын болон танхимын бус сургалтыг хослуулсан байх, боловсролын хөтөлбөр, агуулгыг цахим хэлбэрт шилжүүлж хөгжүүлэх зэрэг боловсролын цахим шилжилттэй холбоотой заалтуудыг тусгасан. Багш нь “сургалтад харилцаа холбоо, мэдээллийн технологийг үр дүнтэй ашиглах арга зүйд суралцах, цахим сургалт, контент бүтээх, сургалтын нээлттэй нөөц материал болон бусад платформыг ашиглах” үүрэг хүлээхээр эрх зүйн зохицуулалт орсон болно. Боловсролын цахим мэдээллийн нэгдсэн сан, түүний мэдээллийн аюулгүй байдалтай холбоотой хуулийн төсөлд шинээр оруулсан бүлэгт Монгол Улс боловсролын цахим мэдээллийн нэгдсэн сантай байх, мэдээллийн нэгдсэн ангилал, кодыг батлах, аюулгүй байдал, нууцлал, хадгалалт, хамгаалалтын найдвартай байдлыг хангах</p>	100%

						<p>үүргийг төрийн цахим мэдээллийн сан хариуцсан байгууллага хариуцах зэрэг эрх зүйн зохицуулалтыг тусгаж Монгол Улсын Их Хуралд өргөн барьсан.</p> <p>Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2021 оны “Ажлын хэсэг байгуулах тухай” А/84 дүгээр тушаалаар Монгол Улсын боловсролын салбар дахь мэдээлэл, харилцаа холбооны технологийн дунд хугацааны төлөвлөгөө боловсруулах үүрэг бүхий ЮНЕСКО-ийн Монголын үндэсний комиссын хамтарсан ажлын хэсэг байгуулагдсан бөгөөд тус ажлын хэсэг КОВИД-19 цар тахлын хүрээнд боловсролын салбарын суурь үйлчилгээг дэмжих Нэгдсэн үндэстний байгууллагын нэгдсэн төслийн хүрээнд ЮНЕСКО-ийн Бээжин дэх төлөөлөгчийн газрын дэмжлэгтэйгээр Боловсролын салбар дахь Мэдээлэл, харилцаа холбооны технологийн бодлогын тойм шинжилгээг хийх ажлыг амжилттай зохион байгуулж, тайланг эцсийн байдлаар боловсруулж, хэвлүүлсэн. Мөн ажлын хэсэг дээрх тойм шинжилгээний зөвлөмжид үндэслэн Монгол Улсын боловсролын салбар дахь мэдээлэл, харилцаа холбооны технологийн дунд хугацааны төлөвлөгөөний төслийг 6 зорилт, 7 бүлэгтэй байхаар боловсруулж БШУЯ-ы харьяа байгууллагууд болон боловсролын бүх шатны байгууллагын төлөөллийг оролцуулсан хэлэлцүүлэг зохион байгуулж, санал авч тусган төлөвлөгөөний эхний төслийг боловсруулав.</p>	
4	1.1.14. Боловсролд зориулсан зардлыг урьдчилан нөөцлөх, орон нутгийн төсвийн орлогыг зарцуулах, боловсролд дутагдаж байгаа зардлыг шийдвэрлэнэ.	1. Боловсролд зориулсан зардлыг нэн тэргүүнд тавьж нөөцлөх, орон нутгийн төсвийн орлогыг дайчлах замаар боловсролд дутагдаж буй зардлыг шийдвэрлэнэ.	2020 - 2024	улсын төсөв	Батлагдсан төсвийн хүрээнд ажиллах сургууль, цэцэрлэгийн үндсэн үйл ажиллагааны орлогыг жил бүр төсөвлөсөн байна.	<p>Монгол Улсад гамшгийн бэлэн байдалд шилжсэн нөхцөлд боловсролын салбарын үйл ажиллагаанд зохицуулалт хийн, сургалтын тасралтгүй байдлыг хангах зорилгоор теле, цахим хэлбэрт шилжүүлж, төсөв санхүүгийн зохистой төлөвлөлт хийн Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангаж шаардлагатай үйл ажиллагааг санхүүжүүлэн ажилласан.</p> <p>Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэн хугацаанд боловсролын салбарт хэмнэлт хийгдсэн цэцэрлэгийн хүүхдийн хоол, ерөнхий боловсролын сургуулийн бага ангийн сурагчдын үдийн цайны болон дотуур байрны хүүхдийн хоолны зардлыг тооцож, эх үүсвэрийг төвлөрүүлэх ажлыг улсын хэмжээнд зохион байгуулсан. Үүнд:</p> <p>- Засгийн газрын 2020 оны 181 дүгээр тогтоол, Боловсрол, шинжлэх ухааны сайдын “Дотуур байрны оюутны хоол хүнс, ариутгал, халдваргүйтлийн санхүүжилтийн тухай” А/153 тоот тушаалаар 764.5 сая төгрөгийн санхүүжилтийг нийт 51 их, дээд сургуульд олгохоор баталж дотуур байранд амьдарч байгаа 10541 оюутны хоол хүнс, байрын ариутгалд зарцуулсан;</p> <p>-Засгийн газрын 2020 оны 188 дугаар тогтоол, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2020 оны “Хүнсний дэмжлэг үзүүлэх тухай” А/162 дугаар тушаал гарган цэцэрлэг, ЕБС-ийн дотуур байрны хүүхдийн хоол хүнс болон бага ангийн суралцагчдын үдийн цайнд зарцуулахаар нөөцөлсөн</p>	100%

						<p>хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг сургууль, цэцэрлэгийн зорилтот бүлгийн нийт 18969 хүүхдэд хүнсний дэмжлэг болгон хүргэснээс орон нутагт 14366, нийслэлд 4603 хүүхэд хамрагдаад байна.</p> <p>- Засгийн газрын 2021 оны 47 дугаар тогтоолоор Засгийн газрын нөөц сангаас 512.2 сая төгрөг гарган төрийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн болон дотуур байрыг ариутгалд зардал батлуулан Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2021 оны А/81 тоот тушаалаар аймаг, нийслэлийн боловсролын газраар дамжуулан хуваарилж ариутгал халдваргүйжүүлэлтийг хийсэн.</p> <p>- Салбарын төсвийн гүйцэтгэлд шинжилгээ хийж боловсролын зээлийн сангаас санхүүжих "Бүтэн өнчин, хөгжлийн бэрхшээлтэй", сувилагч, багш мэргэжлээр суралцахад олгох тэтгэлэг, гадаад суралцагчдад олгох тэтгэлэг санхүүгийн эх үүсвэргүй, 15.9 тэрбум төгрөгийн өр төлбөр үүссэнийг төлж барагдуулаад байна.</p>	
5	1.1.15. Багш, сурагч, сургуулийн ажилтнуудын эрүүл мэндийн эрсдэлийг тодорхойлж, сурагчийн сургууль завсардалтын эрсдэлийг тооцоолно.	1. Эрүүл мэндийн судалгаанд үндэслэн багш, суралцагчийн хичээл сургалтын хэвийн үйл ажиллагааг хангахад чиглэсэн зохицуулалт хийнэ.	2020 - 2024	улсын төсөв	Багш, ажилтан, суралцагчийн өвчлөлийн мэдээлэлд үндэслэн хичээл таслалт, хоцролт, завсардалтын шалтгааныг тодорхойлсон байна.	<ul style="list-style-type: none"> - 2021-2022 оны хичээлийн шинэ жилд “Цэцэрлэг болон ерөнхий боловсролын сургууль, насан туршийн боловсролын төвийн багш, ажилтныг эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд хамруулах ажлыг зохион байгуулах удирдамж”-ийг Эрүүл мэндийн сайд, Боловсрол, шинжлэх ухааны сайд хамтран батлан хэрэгжүүллээ. Удирдамжийн дагуу эрүүл, мэндийн үзлэг, шинжилгээнд цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, насан туршийн боловсролын төвийн багш, ажилтан үнэ төлбөргүй хамрагдаж нөхцөлийг бүрдүүлж, сургуулийн өмнөх боловсролын багш, ажилтан, ерөнхий боловсролын сургуулийн бага ангийн болон дотуур байрын багш нарын 97 хувийг хамрууллаа. - Хичээлийн жилийн эхлэхтэй уялдуулан багш нарыг вакцинжуулах ажлыг үе шаттай зохион байгуулж, багш нар вакцины 2, 3 дахь тунд хамруулсан. 2021 оны 12 дугаар сарын 01-ны өдрийн байдлаар Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багш, ажилчид ковидын эсрэг дархлаажуулалтын 1 дүгээр тунд 95,1 хувь, 2 дугаар тунд 94,7 хувь, 3 дугаар тунд 58,9 хувьтай хамрагдаад байна. - 2021 оны 8 дугаар сард Бага, дунд боловсролын газраас 6/4268 тоот албан бичгийг аймаг, нийслэлийн боловсролын газруудад хүргүүлж, 2021-2022 оны хичээлийн жилээс эхлэн суралцагчдыг анги алгасуулах, улируулан суралцуулахгүй байхаар шийдвэрлэн сурлагын хоцрогдлыг арилгах, нөхөх төлөвлөгөөг хэрэгжүүлэн ажилласнаар сургууль завсардах эрсдэл үүсээгүй. 	90%
ХОЁР. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО							
6	2.2.3. Иргэдэд үйлчлэх спортын зориулалтын стандарт талбайн	8. Захиалгын дагуу барилга байгууламжийн нэг маягийн болон	2021 - 2024	83.7	Зураг төсөл боловсруулах ажлын даалгаврыг	<p>Барилга хөгжлийн төвийн 2021 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн 2/2722 дугаартай албан бичгийн дагуу Монгол Улсын 2020 оны Төсвийн тухай хуулийн XII.4.2-т батлагдсан "Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар дараа онуудад хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний техник эдийн засгийн</p>	100%

	хүртээмжийг нэмэгдүүлж, олон улсын жишигт нийцсэн спортын барилга байгууламжийг барина.	давтан хэрэглэх зураг төсөл боловсруулах ажлыг зохион байгуулна.			боловсруулж батлуулсан байна.	үндэслэл, зураг төсөв /Улсын хэмжээнд/" боловсруулах ажлын хүрээнд Барилга, хот байгуулалтын сайдын 2020 оны 169 дүгээр тушаалаар батлагдсан төсөл, арга хэмжээний жагсаалтад дор дурдсан нэг маягийн иж бүрэн зураг, төсвийн хамт 2021 оны 6 дугаар сард хүлээн авч 2021,2022 онуудын хөрөнгө оруулалтын худалдан авах ажиллагаанд ашиглаж байна. Үүнд: -"Дунд сургуулийн спорт заалны зориулалттай барилгын нэг маягийн зураг төсөл" / 540м2, 720 м2/, -"Ерөнхий боловсролын дунд сургуулийн зориулалттай барилгын нэг маягийн зураг төсөл" /320, 640 суудал/ спорт заалтай, -"Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан цэцэрлэг, сургуулийн зориулалттай барилгын нэг маягийн зураг төсөл" спорт заалтай	
7	2.3.1. Яслийн үндэсний тогтолцоог сэргээж 1-2 нас, хүүхэд харах үйлчилгээнд 2-3 насны хүүхдийг хамруулж, эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлт, нийгмийн оролцоог нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.	1. Яслийн үйлчилгээ нэвтрүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэн, хамран сургалтыг нэмэгдүүлнэ.	2020 - 2024	19,387.2	Яслийн 60 бүлэгт 900 хүүхэд хамруулсан байна.	"Яслийн үйлчилгээг зохион байгуулах зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 223 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд БШУЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2021 оны 02 дугаар сарын 23-ны А/04 дүгээр тушаалаар ажлын хэсэг байгуулагдан Яслийн үйлчилгээг зохион байгуулахад баримтлах журмын төслийг эцэслэн боловсруулж, Яслийн орчинд тавигдах шаардлагын дагуу хүүхэд хүлээн авах анги танхимыг бэлтгэх ажлын тооцоо, санхүүжилт, тендер зарлахад шаардагдах техникийн тодорхойлолт зэргийг боловсруулах ажлыг хийж гүйцэтгэн, улсын төсвөөс 4,8 тэрбум төгрөгийг батлуулан бэлтгэл ажлыг хангасан. Гэсэн хэдий ч Боловсролын багц хууль боловсруулах явцад хийсэн судалгаагаар Сургуулийн өмнөх боловсролд хамрагдах насыг өөрчлөхөөр Засгийн газраас УИХ-д өргөн барьсан хуулийн төсөлд тусгасан, нөгөө талаас Ковид цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалан Засгийн газраас цэцэрлэгийн танхимын сургалт, үйл ажиллагааг үе шаттай эхлүүлэх, 4 болон 5 настай хүүхдийн эхний ээлжид хүлээн авахаар БШУ-ны сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан тушаал батлагдсан зэргээс шалтгаалан 2021-2022 оны хичээлийн жилээс эхлүүлэх боломжгүйд хүрсэн. Дээрх нөхцөл байдал, шалтгааны улмаас боловсруулж батлуулахаар ажиллаж байсан үйл ажиллагааг түр зогсоож, журмыг эцэслэн батлуулаагүй болно. Хууль батлагдах явцтай уялдуулан яслид хамрагдах хүүхдийн насыг эргэж харах шаардлага үүсээд байна.	70%
8		2. Хүүхэд харах үйлчилгээний тухай хуульд өөрчлөлт оруулж, бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих хөтөлбөрийг батлан	2020 - 2024	20,338.0	Хамрагдах хүүхдийн тоог өмнөх оноос 14.7 хувиар нэмэгдүүлсэн байна.	2021 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн УИХ -ын хуралдаанаар "Хүүхэд харах үйлчилгээний тухай хууль"-д нэмэлт өөрчлөлт оруулсан. "Хүүхэд харах үйлчилгээ"-г Боловсрол, шинжлэх ухааны яамны чиг үүргээс Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны чиг үүрэгт шилжүүлэхээр шийдвэрлэсэн. Хүүхэд харах үйлчилгээг Хөдөлмөр нийгмийн хамгааллын яамны чиг үүрэгт шилжүүлж байгаатай холбогдуулан БШУ-ны сайдын 2021 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 1а/6712 тоот албан бичгээр "Хүүхэд харах үйлчилгээ"-тэй холбогдох дүрэм журам, өнөөгийн нөхцөл байдлын талаарх баримт мэдээллийг цаасан болон	90%

		хэрэгжүүлж, хамрагдалтыг нэмэгдүүлнэ.				цахим хэлбэрээр Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдад хүргүүллээ. 2021 оны эхний 5 сард Дэлхий нийтийг хамарсан коронавирус /КОВИД-19/ цар тахлын улмаас Хүүхэд харах үйлчилгээнд хамрагдах 2818 хүүхдэд зайнаас хөгжлийг дэмжих үйлчилгээ үзүүлсэн байна. 2021-2022 оны хичээлийн жилд хүүхэд харах үйлчилгээ эхлээгүй байна. ЗГ үе шаттайгаар "Хүүхэд харах үйлчилгээ эрхлэгчид болон эцэг эх асран хамгаалагчид 0-3 хүртэлх насны хүүхдийн хөгжлийг дэмжихэд зориулсан "Нялх балчир насны хүүхдийн хөгжлийг дэмжих хөтөлбөр"-ийг боловсрууллаа. Тус хөтөлбөр нь нялх нас /1-2 нас/, балчир нас /2-3/-ны хүүхдийн хөгжлийн онцлогт нийцүүлэн тэдний хөдөлгөөн, бие бялдар, танин мэдэхүй, хэл яриа, сэтгэлийн хөдөлгөөний хөгжлийг дэмжих чиглэлээр агуулгын хүрээг тодорхойлж, арга зүйн зөвлөмжийг хамтад нь боловсруулсан. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд хүүхдэд эрүүл мэнд, хоол тэжээл, асаргаа хамгааллын дэмжлэг үзүүлэх үйлчилгээ голлох тул БШУ-ны Сайд, ЭМ-ийн Сайд, ХНХ-ын Сайдын хамтарсан тушаалаар батлуулах бэлтгэлийг хангаад байна.	
9	2.3.2. Сургуулийн өмнөх боловсролд хамрагдах хүүхдийн насыг 3-5 болгож, 5 настай хүүхэд бүрийн сургуульд бэлтгэгдсэн байдлыг хангана.	1. Сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамрагдах насыг 3-5 нас болгон хамран сургалтыг нэмэгдүүлнэ.	2020 - 2024		СӨБ-ын хамран сургалтыг 87.3 хувьд хүргэсэн байна.	Монгол Улсын Засгийн газраас УИХ-д өргөн барьсан Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн 2 дугаар бүлгийн 4 дүгээр зүйлийн 4.2-т "Сургуулийн өмнөх боловсролд 3-5 насны хүүхэд хамрагдана.", 4.3-т "Сургуулийн өмнөх боловсролыг 5 настай хүүхдэд заавал эзэмшүүлэх бөгөөд 200-аас доошгүй цагийн сургалтад хамруулсан байна." гэж насыг өөрчлөн тусгасан. Энэхүү зохицуулалтын үндэслэл нь дэлхийн 225 улсын 156 буюу 69,3 хувь нь хүүхдийг 3-5 насанд сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамруулж байгаа чиг хандлагад нийцүүлж, НҮБ-ын 2030 он хүртэлх Тогтвортой хөгжлийн хөтөлбөрийн Зорилго 4.2-т "Сургуулийн өмнөх чанартай боловсролыг хамгийн багадаа 1-ээс доошгүй жил үнэ төлбөргүй заавал эзэмшүүлж, бага боловсрол эзэмшихэд бэлтгэгдсэн байх" зорилт, НҮБ-аас бага насны хүүхдийн хөгжил боловсролын талаар дэлхийн улс орнуудад өгч буй зөвлөмжид үндэслэсэн. Монгол Улсад 3-5 насны 231,2 мянган хүүхэд байгаа бөгөөд хууль батлагдсанаар эдгээр хүүхдийг 100% цэцэрлэгийн үндсэн сургалтаар сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэх боломж бүрдэх юм. 2021-2022 оны хичээлийн жилд "КОВИД-19" цар тахлын онцгой нөхцөл байдлын улмаас халдварын тархалтаас сэргийлэх дэглэмийг баримтлан 4-5 настай хүүхдийг танхим, 3 настай хүүхдийг зайны сургалтад хамруулсан. Нийт 1453 цэцэрлэгт 182,189(80%) хүүхэд сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамрагдаж байна. Үүнээс 3 настай 47,5519(61.9%), 4 настай 63,623(86.2%), 5 настай 71,015 (91.2%) тус тус хамрагдсан.	90%
10		2. Сургуулийн өмнөх боловсролд	2020 -	200.0	Хамран сургалтыг 93.4	Монгол Улсын хэмжээнд 5 настай 77,815 хүүхэд байгаагийн 71,015 (91,2%) нь сургуулийн өмнөх боловсролд хамрагдаж, өмнөх хичээлийн	100%

		5 настай хүүхдийг бүрэн хамруулж, сургуульд бэлтгэгдсэн байдлын үнэлгээг жил бүр хийнэ.	2024		хувьд хүргэсэн байна.	<p>жилээс 0,6 хувиар буурсан байна. Үүнээс цэцэрлэгийн үндсэн сургалтад 68,174 хувилбарт сургалтад 2841 хүүхэд хамрагдсан байна. Цэцэрлэгийн үндсэн сургалтад хамрагдах 5 настай хүүхдийн тоо буурсан нь коронавируст цар тахлын халдварын эрсдэлээс эцэг эх, асран хамгаалагчид болгоомжлон хүүхдээ танхимын сургалтад явуулахыг хүсэхгүй байгаатай холбоотой байна. Иймээс цэцэрлэгт хамрагдаагүй 5 настай хүүхдийн эцэг эх, асран хамгаалагчид гэр бүлийн орчинд хүүхдийнхээ хөгжлийг дэмжихэд чиглэсэн зөвлөгөөг цэцэрлэгээс үзүүлж байгаа бөгөөд халдварын тархалт буурсан тохиолдолд хүүхдээ цэцэрлэгт хамруулах хүсэлтийг гаргаж байна.</p> <p>Сургуульд бэлтгэгдсэн байдлыг үнэлэх туршилтын судалгааг түүвэрт сонгогдсон 323 сургуулийн нэгдүгээр ангийн 1354 бүлгийн 23,462 сурагчийг хамруулан 2021 оны 09 дүгээр сарын 20-ны өдрөөс 10 дугаар сарын 20-ны өдөр хүртэл зохион байгуулж үр дүнг гаргалаа. Судалгааг 4062 багш зохион байгуулсан. Сургуульд бэлтгэгдсэн байдлыг үнэлэх судалгааны даалгаврын гүйцэтгэлээр авбал зохих дундаж оноо 137 -оос авсан дундаж оноо 83 буюу 60,7 хувийн гүйцэтгэлтэй байна. Үүнээс нийслэлийн сурагчдын дундаж хувь 60,6, орон нутагт 60,9 хувьтай байна. Хөгжлийн чиглэлээр нийгэмшихүйн хөгжил 65,0 хувь, танин мэдэхүй 61,0 хувь, бие бялдрын хөгжил 56,0 хувьтай үнэлэгдсэн байна. Суралцахуйн чиглэл тус бүрээр Байгаль нийгмийн орчин 72,5 хувь, Нийгэмшихүй 65,1 хувь, Хэл ярианы хөгжил 64,7 хувь, Математикийн энгийн төсөөлөл 62,4 хувь, Дүрслэх урлаг 59,6, Хөдөлгөөн эрүүл мэнд 56,2 хувь, Хөгжим 47,9 хувийн гүйцэтгэлтэй байна. Танин мэдэхүйн чадварын түвшний хувьд сэргээн санах 64,2 хувь, ойлгох 59,3 хувь, хэрэглэх 60,5 хувь, задлан шинжлэх 63,5 хувь, үнэлэх 59,4 хувь, бүтээх 55,5 хувийн гүйцэтгэлтэй байна. Сургуульд бэлтгэгдсэн байдлыг үнэлэх судалгаанд хамрагдсан нийт хүүхдийн 97,0 хувь /22,727/ нь, 2020-2021 оны хичээлийн жилд цэцэрлэгийн танхимын болон зайн сургалтад хамрагдсан, 3 хувь /735/ нь хамрагдаагүй байна. Сургуулийн өмнөх боловсролд хамрагдсан хүүхдийн гүйцэтгэлийн дундаж 60,8 хувь байсан бол хамрагдаагүй хүүхдийн хувьд 58,7 хувийн гүйцэтгэлтэй байна.</p>	
11		3. Малчин болон алслагдсан хязгаар бүсэд амьдарч буй өрхийн 3-5 насны хүүхдийг боловсролын үйлчилгээнд хамруулж, хөгжлийг дэмжинэ.	2020 - 2024	52,606.5	Сургалт, гал тогооны зориулалттай 22 гэр бүлэг нийлүүлсэн байна.	<p>Монгол Улсад сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамрагдаж буй нийт хүүхдийн 7.0- 8.0 хувь (11.569 мянган хүүхэд) нь хувилбарт сургалтад хамрагдаж байгаагийн 90.0 гаруй хувь нь малчин болон алслагдсан бүс нутагт оршин амьдарч буй өрхийн хүүхэд байна. Малчдын болон алслагдсан бүсэд амьдарч буй өрхийн хүүхдэд сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэх, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор дараах арга хэмжээг авч хэрэгжүүллээ. Үүнд:</p> <p>1. Хувилбарт сургалт зохион байгуулах журмын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, үйлчилгээний хүртээмж, чанар, орчин нөхцөл, аюулгүй байдал, багшлах хүний нөөц, санхүүжилт, эцэг эх, асран</p>	100%

						<p>хамгаалагчид, орон нутгийн захиргааны байгууллагын оролцоо дэмжлэгийн өнөөгийн нөхцөл байдалд судалгаа хийн, тайлан дүгнэлтийг гаргалаа.</p> <p>2. Дээрх судалгааны тайлан, дүгнэлтэд үндэслэн "Сургуулийн өмнөх боловсролын хувилбарт сургалт зохион байгуулах журам"-ыг шинэчлэн i) сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэх хувилбарт сургалтын төлөвлөлт, зохион байгуулалт, хүүхдийн хөгжлийн үнэлгээ, ii) сургалтын орчин, аюулгүй байдал, iii) багш ажилтны ажиллах нөхцөл, iv) эцэг эх, асран хамгаалагчийн үүрэг оролцоо, хамтын ажиллагаа, v) санхүүжилт, vi) элсэлт бүртгэл зэрэг асуудлын хүрээнд төслийг боловсрууллаа. Төсөлд малчин болон алслагдсан бүсэд амьдарч байгаа хүүхдэд сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээ үзүүлэх хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор хөдөөгийн сум бүрд хувилбарт сургалтын багш ажиллуулахаар заасан.</p> <p>Журмыг Сангийн сайдтай хамтран батлуулах тул тус яамнаас санал авах, хэлэлцүүлэн батлуулах асуудлыг 2022 онд хийхээр төлөвлөсөн.</p> <p>3. Боловсрол, шинжлэх ухааны сайд болон аймаг, нийслэлийн Засаг даргын хооронд 2021 онд Засгийн газрын чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх гэрээнд сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд малчдын хүүхдийн хамрагдалтыг нэмэгдүүлэх талаар тусган гэрээний биелэлтийг дүгнэлээ.</p> <p>4. Нүүдлийн бүлэг ажилуулах 22 гэр цэцэрлэгийг нийлүүллээ.</p>	
12	4. Хамгаалал, дэмжлэг зайлшгүй шаардлагатай зорилтот бүлгийн өрхийн хүүхдийг 24 цагийн цэцэрлэгт үе шаттай хамруулж, тэдэнд боловсрол, эрүүл мэнд, хамгааллын цогц үйлчилгээ үзүүлнэ.	2020 - 2024	19,581.2	10 бүлэг нээж 250 хүүхдийг хамруулсан байна.	БШУ-ны сайд, ЭМ-ийн сайдын 2021 оны А/292, А/525 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан "Коронавируст халдвар /КОВИД-19/-ын үед цэцэрлэгийн сургалт, үйл ажиллагааг зохион байгуулахад мөрдөх түр журам"-д нэг бүлэгт байх хүүхдийн тоо 20-25 байх, 3 настай хүүхдийг зайны сургалтад хамруулах зохицуулалтыг хийж өгсөн. 2021-2022 оны хичээлийн жилд Нийслэлийн 28 дугаар цэцэрлэг 5 бүлэг, 63 дугаар цэцэрлэг 2 бүлэг, шинээр 7 бүлэг нэмж нээсэн ба 5 бүлэг хасагдсан байна. Энэ нь 2 настай хүүхдийн элсэлт зохион байгуулагдаагүй, 3 настай хүүхдийг зайны сургалтад хамруулж байгаа нь 24 цагийн үйл ажиллагаатай бүлэгт хамрагдах хүүхдийн тоонд нөлөөлсөн. 2021-2022 оны хичээлийн жилд 32 цэцэрлэгийн 79 бүлэгт хамгаалал, дэмжлэг зайлшгүй шаардлагатай зорилтот бүлгийн 1496 хүүхэд хамрагдаж байна.	100%	
13	5. Цэцэрлэгийн багшийг тусгай хэрэгцээт боловсролын чиглэлээр мэргэшүүлж, цэцэрлэгт ээлжийн	2020 - 2024	6,200.0	- 230 багшийг мэргэшүүлсэн байна. - 100 ээлжийн багш	ЖАЙКА Олон улсын байгууллагын "Тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхдэд үзүүлэх эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээг сайжруулах төсөл" II шатны Зорилт II-ын хүрээнд Төв аймгийн "Унагалдайн андууд", Нийслэлийн Хан-Уул дүүргийн 12-р цэцэрлэгт "Хөгжлийн бэрхшээлтэй бага насны хүүхдийг сургуулийн өмнөх боловсролд тэгш хамруулах үйлчилгээний загвар", "Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөний загвар"-ыг боловсруулан туршилтаар хэрэгжүүлж байна. Мөн туршилтын цэцэрлэгийн удирдах	100%	

		багш ажиллуулна.				<p>ажилтан, багш, ажилчдыг чадавхжуулах цахим сургалтыг 11 удаа, ердийн цэцэрлэгт тэгш хамран сургаж буй Япон Улсын сайн туршлагыг танилцуулах зорилгоор 11 цуврал хичээлийг цахимаар дамжуулан хүргэж ажиллалаа. Энэхүү төслийг турших, түгээн дэлгэрүүлэх зорилгоор Нийслэлийн 9 дүүргээс 25 цэцэрлэгийг тодорхой шалгуураар сонгон, цаашид ажиллах чиглэлийг танилцуулах цахим уулзалтыг хийж, хамтран ажиллах гэрээ байгуулан ажиллаж байна.</p> <p>Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2021 оны “Цэцэрлэгт ээлжийн багш ажиллуулах тухай” А/214 дүгээр тушаалаар нийслэлийн 6 дүүргийн 25 цэцэрлэгийн 60 бэлтгэл бүлэгт ээлжийн багшийг 2021 оны 9 дүгээр сарын 1-ний өдрөөс туршилтаар ажиллуулж байна. Ээлжийн багш ажилласнаар цэцэрлэгийн багшийн ажлын ачааллыг тэнцвэржүүлэх, сургалт, үйл ажиллагаанд бэлтгэх, өөрийгөө хөгжүүлэх нөхцөл боломжийг бүрдүүлж байна.</p> <p>Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2021 оны “Түр журам батлах тухай” А/331 дүгээр тушаалаар “Цэцэрлэгт ээлжийн багш ажиллуулахад мөрдөх түр журам”-ыг баталлаа. 2021-2022 оны хичээлийн жилд мөрдөх энэхүү түр журмаар цэцэрлэгийн сургалт, үйл ажиллагааны зохион байгуулалт, ээлжийн багшийн чиг үүрэг, ажиллах цаг болон ээлжийн багшид үзүүлэх дэмжлэг, оройн хоолны үйлчилгээ, зардал, багшийн илүү цагийг тооцох харилцааг зохицуулна. Боловсролын хүрээлэнгийн захирлын 2021 оны А/48 дугаар тушаалаар Цэцэрлэгт ээлжийн багш ажиллуулах туршилтын үйл ажиллагааны удирдамж, төлөвлөгөөг батлан хэрэгжүүлж байна. Боловсролын хүрээлэн 2021-2022 оны хичээлийн жилийн туршид судалгаа хийж, ээлжийн багшийн ажиллуулсан туршилтын үр дүн, цаашид авах арга хэмжээний саналыг 2022 оны 5 дугаар сард яаманд хүлээлгэн өгөхөөр зохицуулалт хийн, туршилтыг зохион байгуулж байна.</p>	
14		6. Бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих цогц бодлогыг боловсруулан хэрэгжүүлж, салбар дунд хамтын ажиллагааг бэхжүүлнэ.	2020 - 2024	Улсын төсөв-300.0, НҮБ ХСан-50.0	Бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих цогц бодлогыг баталсан байна.	<p>“Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2020 оны “Ажлын хэсэг байгуулах тухай” А/142 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг “Бага насны хүүхдийн цогц хөгжлийг дэмжих хөтөлбөр”- баримт бичгийн төслийг боловсрууллаа.</p> <p>“Бага насны хүүхдийн цогц хөгжлийг дэмжих хөтөлбөр”-ийн зорилго нь 0-5 насны хүүхдийг эрүүл өсгөн бойжуулах, эрхийг хамгаалах, бие бялдар, танин мэдэхүй, нийгэмшихүйн цогц хөгжлийг дэмжихэд тэдний нас, хөгжлийн онцлог, хэрэгцээнд нийцсэн чанартай үйлчилгээг үзүүлж, хүүхэд аюулгүй, ээлтэй гэр бүл, нийгмийн орчинд өсөж, хөгжих боломжийг бүрдүүлэхэд чиглэж байна.</p> <p>Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ нь i) бага насны хүүхдэд үзүүлэх нийгмийн үйлчилгээний нэгдсэн удирдлага, зохион байгуулалт, салбар дундын үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангах, ii) үйлчилгээний чанарыг үнэлэх тогтолцоо бүрдүүлэн, үр дүнд үндэслэсэн бодлого хэрэгжүүлэх, iii) эцэг эх, асран хамгаалагчид бага насны хүүхдийнхээ</p>	70%

						<p>эрүүл, аюулгүй байдлыг хангах, хөгжлийг дэмжихэд чиглэсэн чадавхыг сайжруулах, iv) гэр бүл, олон нийтэд түшиглэсэн үйлчилгээний хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх, v) хүүхдэд зориулан зарцуулах төсвийн үр ашигтай хуваарилалтын шинэчлэл хийж, эрүүл мэнд, нийгмийн хамгаалал, боловсролын салбарын төсвийн хөрөнгийг хүүхэд, гэр бүл, тэдэнд үйлчилгээ үзүүлэх мэргэжилтэй ажилтны хөгжилд зарцуулах зэрэгт чиглэх юм.</p> <p>Үр дүн: Энэхүү хөтөлбөрийн зорилт, үйл ажиллагаа нь “Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хууль”-ийн шинэчлэн найруулсан төсөлд сургуулийн өмнөх боловсролд хамрагдах насыг 3-5 болгох зохицуулалттай уялдаатай бөгөөд 3-5 настай хүүхэд бүрийг сургуулийн өмнөх боловсролд, 0-3 хүртэл настай хүүхдийг гэр бүлд түшиглэсэн олон хувилбартай үйлчилгээнд хамруулах замаар нийгмийн суурь үйлчилгээг үзүүлж, тэдний цогц хөгжлийг дэмжих боломж бүрдүүлэхэд чиглэж байна.</p> <p>Шинэчлэн боловсруулсан хөтөлбөрийн төслийг Боловсролын багц хуулийн төслийг УИХ-аар хэлэлцүүлэхтэй холбогдуулан хойшлуулсан бөгөөд МУЗГ-ын хуралдаанд оруулж танилцуулах бэлтгэл хангаад байна.</p>	
15	2.3.3. Ерөнхий боловсролын сургалтын чанарыг дэлхийн жишигт нийцүүлэх зорилгоор олон улсын PISA үнэлгээнд хамруулж, үндэсний чанарын үнэлгээний тогтолцоог бэхжүүлнэ.	1. Суралцагчийн сургалтын ахиц, дэвшлийн үнэлгээг тогтмол хийнэ.	2020 - 2024	1,650.0	4-12 дугаар анги тус бүрийн судлагдахуунаар улирал тутам хөндлөнгийн үнэлгээ хийх даалгаврын санг бүрдүүлсэн байна.	<p>1. Улсын Онцгой комиссын зөвшөөрлөөр “Сурлагын амжилтыг үнэлэх олон улсын PISA-2022” туршилтын шалгалт /судалгаа/-ыг 2021 оны 5-р сарын 17-24-ний өдрүүдэд зохион байгуулж ерөнхий боловсролын 19 сургууль /нийслэлийн 10, хөдөөгийн 9/-ийн 15-16 насны 585 суралцагч хамрагдаж, математик, унших, байгалийн ухааны хичээлээр эзэмшсэн мэдлэгээ амьдрал ахуйдаа ашиглах болон бүтээлч сэтгэлгээний чадварыг үнэлэх даалгаврыг тус тус гүйцэтгэсэн. Мөн 19 сургуулийн захирал асуулга судалгаанд хамрагдсан.</p> <p>2. Коронавирусийн халдварын тохиолдол нэмэгдсэнтэй холбогдуулан БШУ-ны Сайдын 2021 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн “Хичээл, сургалтын үйл ажиллагаанд зохицуулалт хийх тухай” А/165 дугаар тушаалын 2.1 дэх заалтад үндэслэн бага, суурь, бүрэн дунд боловсролын төгсөх ангийн суралцагчдын анги дэвших болон улсын шалгалтыг цуцалж, БҮТ-ийн захирлын 2021 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн А/35 дугаар тушаалаар анги дэвших болон улсын шалгалтын үнэлгээг тооцох аргачлалыг баталж ЕБ-ын сургуулиудад хүргүүлсэн.</p>	90%
16		2. Бага, дунд боловсролын чанарыг үнэлэх судалгааг жил бүр зохион байгуулж, хариу арга хэмжээ	2020 - 2024	2,700.0	Чанарын үнэлгээний дундаж 40 хувьд хүрсэн байна.	<p>“COVID-19” цар тахлын нөхцөл байдалтай уялдуулан боловсролын чанарын үнэлгээг суралцагчдын хоцрогдлыг тодорхойлох зорилго бүхий “оношлох болон сургуульд суурилсан үнэлгээ” хэлбэрээр зохион байгуулсан. Оношлох үнэлгээний хүрээнд 10 судлагдахууны давхардсан тоогоор 73 ангийн, сургуульд суурилсан үнэлгээний 135 ангийн ерөнхий болон дэлгэрэнгүй бюллетинийг боловсруулж 219</p>	100%

		авна.				даалгавар зохиогч, эксперт нарт даалгавар зохиох арга зүйн сургалт зохион байгуулсан. Оношлох үнэлгээнд давхардсан тоогоор 1-12-р ангийн 66 судлагдахуунаар 221 багш 2 хувилбараар нийт 2065 даалгавар боловсруулсан. Сургуульд суурилсан үнэлгээнд давхардсан тоогоор 135 судлагдахуунаар 1-12-р ангийн агуулгаар сэдэв даалгаврыг хариултын тайлбар, зөв хариу, засаж үнэлэх аргачлалын хамт 1 хувилбартайгаар 230 багш боловсруулж, 112 багш хянаж, сайжруулсан. Бага ангийн сэдэв даалгаврыг казак хэл рүү хөрвүүлэх, хөрвүүлгийг хянахаар 12 багш ажилласан. Оношлох үнэлгээнд нийт 646 сургуулийн 201750 суралцагч (давхардсан тоогоор) хамрагдсан байна. Сургуульд суурилсан үнэлгээнд 856 сургуулийн 2-12-р ангийн 640794 буюу бүх суралцагч хамрагдсан бөгөөд бага ангийн математик, монгол хэлний хичээлийн материалыг 48 багш, казак хэлний 3 багш гараар засаж, 10 багш өгөгдлийн санд үр дүнг шивсэн. Хариултын хуудсаар ирсэн 48 хичээлийн 2 хувилбар бүхий материалыг 30 багш засагч машинаар уншуулж, өгөгдлийн сан үүсгэсэн. Үр дүнгийн тайланг 10 судлагдахууны 1-12 ангийн 64 өгөгдлийн санд SPSS, Testan, MS Excel программ ашиглан боловсруулалт хийж, асуулга судалгаатай холбон шинээр 128 өгөгдлийн сан үүсгэсэн. Судлагдахуун, анги тус бүрээр 50-55 багц мэдээлэл бүхий 64 тайланг бичиж мэргэжлийн байгууллагуудад хүргүүлсэн. Мөн үр дүнг stat.eec.mn статистик тайлангийн системд орон нутгийн боловсролын газар, ЕБС, багш нар хэрэглэх боломжтойгоор байршуулсан.	
17		3. Сурлагын амжилтыг үнэлэх олон улсын (PISA) үнэлгээнд хамрагдана.	2020 - 2024	5,415.0	ОУ-ын үнэлгээ PISA-д оролцох бэлтгэлийг хангаж, турших судалгаанд хамрагдсан байна.	Дэлхий нийтийг хамарсан цар тахлын энэ цаг үед манай улс PISA олон улсын үнэлгээний туршилтын шалгалтыг Улсын Онцгой Комиссын зөвшөөрлийн үндсэн дээр халдвар хамгааллын дэглэм баримтлан 2021 оны 05 дугаар сарын 17-22-ны өдрүүдэд компьютерт суурилсан хэлбэрээр зохион байгуулсан бөгөөд Улаантар хотын хотын 10, хөдөө орон нутгийн 9, нийт 19 сургуулийн 585 суралцагчийг эцэг эхийн зөвшөөрөлд үндэслэн асуулга, бичгийн шалгалтад хамруулсан. Мөн 19 сургуулийн захирал асуулга судалгаанд хамрагдсан. Турших шалгалтад давхардсан тоогоор 23 зохион байгуулагч, 22 мэдээллийн технологи, 70 хянагч багш, нийт 115 хүн ажилласан. Турших шалгалтын задгай даалгаврыг кодлох ажлыг 2021 оны 06 дугаар сарын 07-18-ны өдрүүдэд хийж төв серверт датаг шилжүүлж, үйл явцын тайланг судлагдахуун тус бүрээр боловсруулж илгээсэн. Турших судалгааг зохион байгуулахтай холбоотой 8 удаагийн гадаад, дотоодын сургалтад давхардсан тоогоор 253 хүн хамрагдаж ОУ-ын үнэлгээний шалгалт, судалгааны стандарттай танилцах, үнэлгээний даалгаврыг орчуулах, хянаж сайжруулах, зохион байгуулалтыг хянах, суралцагчдын хариултыг кодлох талаарх арга зүй, аргачлалд суралцсан.	100%
18		4. Их, дээд сургуульд элсэх	2020 -		Элсэлтийн ерөнхий	Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2021 оны “Үлгэрчилсэн журам батлах тухай” А/348 дугаар тушаалаар Монгол улсын нутаг дэвсгэр дээр	100%

		шалгалтыг сургалтын хөтөлбөрт суурилан зохион байгуулж, ахлах ангийн сургалтын зарим агуулгыг их, дээд сургуулийн багц цаг (кредит)-д тооцуулах зохицуулалтыг бий болгоно.	2024		шалгалтыг жилд 2 удаа зохион байгуулсан байна.	үйл ажиллагаа явуулж байгаа төрийн болон төрийн бус өмчийн дээд боловсролын сургалтын байгууллагын дээд боловсролын зэрэг олгох сургалтад багц цагийг хэрэглэх, багш, суралцагчийн ачааллыг тооцох, гадаад, дотоодын их, дээд сургууль, коллежид амжилттай судалсан хичээлийг шууд тооцох, дүйцүүлэх, суралцагчдын мэдлэг, чадвар, хандлагыг үнэлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахаар тусган, 2021-2022 оны хичээлийн жилээс хэрэгжүүлэн ажиллаж байна. Журмаар ерөнхий боловсролын ахлах ангийн сургалтын тухайлбал Кембриджийн болон олон улсын хөтөлбөрийн математик, физик, хими, биологи, эдийн засаг зэрэг 7 хичээлийн дүнг бакалаврын хөтөлбөрийн багц цагтай дүйцүүлэн тооцох зохицуулалтыг бий болгосон.	
19		5. Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн олимпиадаас медаль хүртсэн ерөнхий боловсролын сургуулийн суралцагч, бэлтгэсэн багшийг урамшуулах эрх зүйн орчин бүрдүүлж, хэрэгжүүлнэ.	2020 - 2024	2,980.0	Эрх зүйн орчныг бий болгож, урамшууллын зардлыг төсөвт тусгасан байна. /Эхний 3 байр/	Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 275 дугаар тогтоолоор баталсан "Монгол Улсын Ерөнхийлөгчийн нэрэмжит сургалтын тэтгэлэг олгох журам"-д дараах тэтгэлэг олгохоор тусгалаа: Үүнд: 1. Холбогдох төрийн захиргааны төв байгууллагын хүлээн зөвшөөрсөн олон улсын олимпиадад медальт байрт шалгарсан иргэнийг олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн байгууллагын тогтоосон эрэмбээр дэлхийн шилдэг 100-д багтсан их, дээд сургуулийн бакалаврын үндсэн хөтөлбөрт суралцуулах сургалтын тэтгэлэг. 2. Холбогдох төрийн захиргааны төв байгууллагын хүлээн зөвшөөрсөн олон улсын олимпиадад медальт байрт шалгарч, дэлхийн шилдэг их, дээд сургуулиудын зэрэглэл тогтоосон эрэмбээр их, дээд сургуулийн бакалаврын үндсэн хөтөлбөрт суралцах албан ёсны урилга хүлээн авсан иргэнд тэтгэлэг. Засгийн газрын 2021 оны 172 дугаар тогтоолоор баталсан "Хүүхдийн төлөө сангийн хөрөнгийг зарцуулах, түүнд хяналт тавих журам"-д ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дунд олон улс (математик, биологи, газар зүй, физик, мэдээлэл зүй, хими, Менделеевийн олон улсын химийн олимпиад)-ын болон тивийн (Азийн физикийн олимпиад, Ази, Номхон далайн орнуудын мэдээлэл зүйн олимпиад) хэмжээнд зохион байгуулагддаг олимпиадад оролцож амжилт гаргасан хүүхдийг шагнаж урамшуулахаар тусгасан. 2021 онд олон улсад зохион байгуулагдсан математик, хими, биологи, физик, мэдээлэл зүйн олимпиадад оролцож амжилт үзүүлсэн 15 хүүхдэд энэхүү сангаас 25.0 сая төгрөгний урамшуулал олгосон. Мөн ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дунд жил бүр зохион байгуулагддаг олон улсын олимпиад (математик, физик, хими, биологи, мэдээлэл зүй)-д 2021 онд амжилттай оролцож, медаль хүртсэн 18 хүүхдэд Монгол Улсын Ерөнхийлөгчийн нэрэмжит тэтгэлэг, зарим олимпиадын хороог урамшуулахад шаардагдах 100.2 сая төгрөгийн зардлыг Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2021 оны А/350 дугаар тушаалаар баталж, ёслолын арга хэмжээг Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газартай хамтран зохион байгууллаа.	90%

						Боловсролын ерөнхий хууль, сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн олимпиадаас медаль хүртсэн ерөнхий боловсролын сургуулийн суралцагч, бэлтгэсэн багшийг урамшуулах агуулгыг тусган ЗГ-ын хуралдаанаар 2021 оны 6 дугаар сард хэлэлцүүлэн, УИХ-д өргөн бариад байна.	
20		6. Ерөнхий боловсрол дахь эцэг эхийн үүрэг, оролцоог сайжруулна.	2020 - 2024	30.0	Олон нийтийн оролцоот загвар 4 сургуулийг дэмжин ажилласан байна.	Эцэг эх, асран хамгаалагчдын эзэмшсэн мэдлэг мэргэжил, эрхэлж буй ажил, ойлголтын зөрүү, амьдралын ялгаатай байдлаас хамаарч сургууль, багш нартай хамтран ажиллах байдал харилцан адилгүй байдаг тул анги удирдсан багшаар дамжуулан эцэг эх, асран хамгаалагч хүүхдээ илүү ойлгож хөгжил, төлөвшлийг нь дэмжих, сургууль, багштай хамтран ажиллах боломжийг нэмэгдүүлэх зорилгоор “Анги удирдсан багшаар дамжуулан эцэг эхийн боловсролыг дэмжих арга зүйн зөвлөмж” гарын авлагыг боловсруулж, хэвлүүлжээ. Уг гарын авлагыг (i) анги удирдсан багш, эцэг эхтэй хамтран ажиллах арга зүй (ii) хүүхдийн хөгжлийг дэмжихэд эцэг эхийн оролцоо (iii) хүүхэд хамгаалал-эцэг эхийн хамтын ажиллагаа (iv) хүүхдийн нас, сэтгэцийн онцлог, хүүхдээ ойлгохуй зэрэг агуулгын хүрээнд боловсруулав. Энэхүү гарын авлага нь анги удирдсан багш эцэг эхэд зориулсан төрөл бүрийн сургалт, уулзалт, лекц зохион байгуулахад чиглүүлэг арга зүйн санаа авах төдийгүй сургууль, багш, эцэг эхийн хамтын ажиллагааг бэхжүүлэхэд дэмжлэг болох юм. Мөн гарын авлагын хүрээнд сургалтын модуль боловсруулан, сургууль-эцэг эхийн хамтын ажиллагааг бэхжүүлэх, сургуулийн зүгээс эцэг эхийн боловсролыг дэмжих үйл ажиллагааг үндэсний хэмжээнд цувралаар зохион байгууллаа. Сургалтаар 21 аймаг, 9 дүүргийн боловсролын газар/хэлтсийн мэргэжилтэн, нийгмийн ажилтан 60, Багшийн мэргэжил дээшлүүлэх институтын 27 арга зүйчийг сургагч багшаар бэлтгэв.	100%
21	2.3.4. Монголын түүх, хэл, соёл, зан заншил, эх оронч сэтгэлгээ, үндэсний өв уламжлал, шударга ёсны үзэл, хандлага болон олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн агуулгаар баяжуулсан монгол хүний хүмүүжлийг дээдэлсэн, монгол хүний онцлогт тохирсон зан чанар,	1. Боловсролын сургалтын хөтөлбөрт дүн шинжилгээ хийж, үзэл баримтлал боловсруулан түүнийг сургалтын хөтөлбөрт тусгана.	2020 - 2024		Сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлалыг боловсруулж, багш бэлтгэх сургалтын хөтөлбөрийг магадлан итгэмжлэлд хамруулах эрх зүйн орчин бүрдүүлсэн байна.	1.Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын сургалтын хөтөлбөрт Монголын түүх, хэл, соёл, зан заншил, эх оронч сэтгэлгээ, үндэсний өв уламжлал, шударга ёсны үзэл, хандлагыг төлөвшүүлэх агуулгыг тусган баяжилт хийх, сайжруулах, хэрэгжилтийг хангах төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна. Тус төлөвлөгөө нь 2021 оны 4 дүгээр улирлаас 2024 оны 2 дугаар улирал хүртэл 3 уе шаттай хэрэгжинэ. Үүнд: -1 дүгээр үе шатанд хөтөлбөрийн үзэл баримтлалыг тодорхойлоход шаардлагатай судалгаа зохион байгуулах, арга зүй боловсруулан турших, -2 дугаар үе шатанд хөтөлбөрийн агуулгын хүрээ тогтоож, сайжруулалт хийж батлуулах, -3 дугаар үе шатанд хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга зүйг түгээн	100%

	хүмүүжил, сургалтын хөтөлбөрийг өмчийн хэлбэр харгалзахгүйгээр цэцэрлэг, сургуульд хэрэгжүүлнэ.				<p>дэлгэрүүлэхээр тус тус төлөвлөсөн.</p> <p>2. “Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын хөтөлбөрийг боловсронгуй болгох аргачлал”-ын дагуу сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийн судалгааг зохион байгууллаа. Энэ хүрээнд Монголын түүх, монгол хэл, уран зохиол, иргэний ёс зүйн боловсрол, хүн орчин хичээлийн сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд тулгарч буй бэрхшээлийг илрүүлэх, сургалтын хөтөлбөрийн шинэчлэлийн үзэл баримтлалд тусгах асуудлыг тодорхойлов. Судалгаагаар сургалтын хөтөлбөр болон зарим сурах бичгийн агуулга хооронд арга зүйн зөрүүтэй байдал үүссэн, хүүхдийн нас сэтгэхүйн онцлогт тохироогүй, уялдаа сул, агуулга, арга зүйн амьдралд нийцтэй байдал учир дутагдалтай, агуулга зарим ангид хүндэдсэн гэсэн дүгнэлт гарсан.</p> <p>3.Их, дээд их сургуулийн бакалаврын хөтөлбөрийн бүх оюутнууд ерөнхий суурь хичээлд (1) Монголын түүх, соёл, ёс заншил 3 кредит, (2) монгол хэл бичиг, найруулга зүй 3 кредит, (3) хүний хөгжил, харилцааны ёс зүй, эрх зүй 3 кредит, (4) сэтгэлгээний түүх, соёл 3 кредит - нийт 4 хичээл буюу 12 кредитийг заавал судалж байна. /ЗГ-ын 2014 оны 06 дугаар сарын А/285 дугаар БШУ-ны сайдын тушаал/</p>	
22	2. Сурах бичиг, сургалтын хэрэглэгдэхүүнд тавигдах шаардлагыг шинэчилж, сургалтад ашиглах нээлттэй нөөц материал, цахим агуулгыг бий болгоно.	2020 - 2024	3,300.0	I-XII ангийн сурах бичигт сайжруулалт хийж, хэвлэгдсэн байна.	<p>Бага, суурь, бүрэн дунд боловсролын сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэхэд шаардлагатай сургалтын хэрэглэгдэхүүн, тэдгээрт тавих шаардлагыг боловсруулах багийн бүрэлдэхүүнийг мэргэжил, арга зүйн удирдлагаар ханган ажиллаж, сургалтын хэрэглэгдэхүүнд тавих ерөнхий болон тусгай шаардлага, сургалтын хэрэглэгдэхүүний жагсаалт (24 хичээл/судлагдахуун)-ын төслийг тус тус боловсруулж, холбогдох талуудаар хэлэлцүүлсэн. Сургалтын хэрэглэгдэхүүнд тавих ерөнхий шаардлага 7 багцад хамаарах 21 шалгууртай байхаар тооцсон бөгөөд тусгай шаардлагад тухайн судлагдахууны онцлогийг авч үзсэн. Сургалтын хэрэглэгдэхүүн нь (i) биет үзүүлэн, (ii) хэвлэмэл материал, (iii) дижитал үзүүлэн, (iv) зурагт үзүүлэн, (v) туршилт, дадлагын тоног төхөөрөмж, (vi) туршилт, дадлагын багаж хэрэгсэл, (vii) үзүүлэх техник хэрэгсэл гэсэн ангилалтай байх ба эдгээр нь боловсролын түвшин, хичээл бүрээр байх юм. Тухайлбал, давхардсан тоогоор 400 орчим багаж хэрэгсэл, 190 орчим тоног төхөөрөмж, 50 орчим биет үзүүлэн, 100 орчим хэвлэмэл материал, зурагт үзүүлэн (агуулгыг тодорхойлсон), 60 орчим дижитал материал (аудио, видео материал) болон судлагдахууны онцлогтой хэрэглэх бодис урвалж, байгалийн ухааны болон биеийн тамирын хичээлийн аюулгүй ажиллагааны хэрэгсэл, гадна талбайн тоног төхөөрөмжийн нэр, тухайн танхимд байх тоо хэмжээ, шаардлага зэргийг тус тус жагсаалтад багтаасан. Проектор, ухаалаг самбар, дэлгэц гэх мэт үзүүлэх техник хэрэгсэл, багш хичээлд бэлтгэхэд хэрэглэх компьютер, хэвлэгч зэрэг тоног төхөөрөмж сургуулийн хэмжээнд нийтлэг байхаар тооцож, боломжит үзүүлэлтүүдийг тусгасан.</p>	100%

					Шаардлагын төслийг хэлэлцүүлэх ажил 2022 оны 1 сард хийгдэнэ. Үндэсний хэмжээнд бүх нийтэд зориулсан цахим контент боловсруулах, сургалтад ашиглах зорилгоор MEDLE.mn платформыг 2021 оны 6 дугаар сараас хөгжүүлж, энэхүү палтформд ерөнхий боловсролын сургуулийн 1-12 дугаар ангийн 419 хичээл, 104 интерактив хичээлийг тус тус байршуулаад байна. Ингэснээр суралцагчид теле болон цахим хичээл, цахим контентыг анги танхимын болон танхимын бус сургалтын үед нээлттэй ашиглах боломж бүрдсэн.	
23	3. Үндэстний цөөнхийн хүүхдүүд, лам хүүхдүүд болон гадаадад гацсан хүүхдүүдэд таатай орчин бүрдүүлж, шаардлагатай сурах материалаар хангана.	2021 - 2024	200.0	Гадаадад байгаа хүүхдүүд болон лам хүүхдүүдэд зориулсан сургалтын модулийг боловсруулсан байна.	<p>2021 оны байдлаар Англи, АНУ, Бельги, Ирланд, Канад зэрэг 20 оронд 60 гаруй монгол хэл, соёлын сургалтын төв ажиллаж байна. Сургалтын төвүүдэд 1800 гаруй хүүхэд 7 хоногийн Бямба, Ням гарагт ойролцоогоор 4-8 цаг хичээллэж монгол хэл соёлоо суралцаж байна. Сургалтын төвүүдэд нийт 188 багш ажиллаж байгаагаас 107 нь буюу 60,0 хувь нь монгол хэлний багш мэргэжилтэй байна. Хилийн чанадад үйл ажиллагаа эрхэлж байгаа сургалтын төвүүд Боловсрол, шинжлэх ухааны яамнаас шаардлагатай сурах бичгийг нийлүүлж байна.</p> <p>Үндэсний цөөнхийн хүүхдийн сурч боловсрох эрхийг хангах чиглэлээр дараах арга хэмжээг хэрэгжүүллээ: (i) Бага ангийн тува, казах хэлний дасгал ажлын дэвтрийг боловсруулж, Боловсролын хүрээлэнгийн цахим хуудаснаа байршууллаа (тус бүр нь 49 хэвлэлийн хуудас). Дасгал ажлын дэвтэр нь хүүхэд өөрөө бие даан гүйцэтгэж агуулгын хоцрогдлоо арилгах, даалгаврууд нь хөнгөнөөс хүнд чиглэсэн, хүүхдэд хүндрэлгүй, сонирхолтой байдлаар боловсруулагдсан. (ii) “Монгол Контент” ХХК-тай хамтран сургалтын 128 жишиг контентийг тува, казах хэл рүү хөрвүүлж, Боловсрол, шинжлэх ухааны яамны цахим хуудсанд байршуулсан. (iii) Хос хэлний боловсролыг дэмжих ажлын хүрээнд БШУ-ны сайдын 2021 оны А/94 дүгээр тушаалаар "Сургалтын толь бичиг (математик, биологи, байгалийн шинжлэл, дүрслэх урлаг, биеийн тамирын хичээлийн сургалтын монгол-казах, казах-монгол, монгол-тува, тува-монгол хэл дээр)" боловсруулан хэвлэж, туршиж байна. Сургалтын толь бичигт монгол-казах хэл дээр нийт 5600 үг (5 хичээл тус бүр дээр 680-1800 үгийн хооронд, хамгийн их биологийн хичээл), монгол-тува хэлний сургалтын толь бичигт нийт 3400 гаруй үг (4 хичээл) орсон байна.</p>	100%
24	4. Сургалтын хөтөлбөрт нийцүүлэн сурах бичгийг зохиох, сургалтын хэрэглэгдэхүүний хүртээмжийг нэмэгдүүлнэ.	2020 - 2024	Улсын төсөв (300.0), Гадаад зээл, тусламж /НҮБ-ын Хүүхдийн Сан (50.0)/		<p>Ерөнхий боловсролын сургуульд 2021-2022 оны хичээлийн жилд ашиглах I-VII ангийн 61 нэрийн сурах бичиг болон багшийн журнал, анги удирдсан багшийн дэвтэр, тусгай хэрэгцээт боловсролын 11 нэрийн сурах бичгийг нөхөн хангалтаар хэвлэн нийлүүлэх зардлыг Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2021 оны А/61 дүгээр тушаалаар баталж, худалдан авах ажиллагааг ерөнхий гэрээгээр зохион байгуулах эрхийг Төрийн худалдан авах ажиллагааны газарт шилжүүлсэн. Ерөнхий гэрээний журмаар 2021 оны 5 дугаар сард 147 нэрийн сурах бичиг болон багшийн журнал, анги удирдсан багшийн дэвтэр, тусгай хэрэгцээт</p>	90%

						боловсролын 11 нэрийн сурах бичгийг тус тус хэвлэн нийт сургуулиудад нийлүүлсэн. Мөн бага ангийн 76 нэрийн 2.8 тэрбум төгрөгийн өртөг бүхий сурах бичгийг улсын төсвийн хөрөнгөөр хэвлэн түгээж сурах бичгийн хүртээмжийг нэмэгдүүллээ.	
25	5. Эх хэлний сургалтын чанарыг дээшлүүлж, монгол бичгийн сургалт, судалгаа, хэрэглээний орчныг сайжруулна.	2020 - 2024		Монгол хэл, бичгийн сургалтын хөтөлбөрт дүн шинжилгээ хийсэн байна. Иргэдэд зориулсан монгол бичгийн хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлсэн байна.	Ерөнхий боловсролын сургуулийн монгол хэл, бичиг, уран зохиолын хичээлийн багш нарын цахим хурлыг 2021 оны 1 дүгээр сард зохион байгууллаа. Цахим хурлаар хүчин төгөлдөр мөрдөж буй монгол хэл, бичиг, уран зохиолын сургалтын хөтөлбөрт хийсэн шинжилгээний ажлын явцын үр дүнг урьдчилсан байдлаар танилцуулж, цаашид сургалтын хөтөлбөрийг сайжруулах үзэл баримтлалд тусгах саналын талаар хэлэлцэж, “Оюун билгийн соёрхол” цахим сургалтыг зохион байгуулав. Сургалтад нийслэлийн ерөнхий боловсролын сургуулийн 1000 багш хамрагдав. Хэлний бодлогын үндэсний зөвлөлийн 21 аймаг дахь хэлний салбар зөвлөл аймаг, орон нутгийнхаа төрийн албан хаагчдын монгол хэл, бичгийн мэдлэг чадварыг нь дээшлүүлэх чиглэлд тогтмол сургалт зохион байгуулж, 2021 оны 10 сарын байдлаар нийт 50000 орчим төрийн албан хаагчийг монгол бичгийн анхан болон дунд шатны сургалтад хамруулан сургаад байна. Орон нутагт салбар зөвлөлийн үйл ажиллагаа нь монгол хэл бичгийн багш нарын санаачлага, идэвх зүтгэл дээр явагдаж байна. Түүнчлэн 2021 онд Азийн хөгжлийн банкны “Эдийн засгийн хүндрэлийн үед боловсролын чанар хүртээмжийг сайжруулах” төслийн санхүүжилтээр Монгол хэл бичгийн сургалтын хөтөлбөрт шинжилгээ хийгдсэн.	90%	
26	6. Хүүхдийн хөгжлийн бэрхшээлийн онцлог, суралцах чадамжид суурилан сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө, үнэлгээний арга зүйг боловсронгуй болгоно.	2020 - 2024	240.0	Сургалтын хөтөлбөрийг сайжруулж, багш бэлтгэх, чадавхжуулах, мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлсэн байна.	Харааны бэрхшээлтэй хүүхдэд ахуйн баримжаа олгох сургалтын жишиг хөтөлбөр”, “Харааны бэрхшээлтэй хүүхдэд хөдөлгөөн орон зайн баримжаа олгох хичээлийн сургалтын жишиг хөтөлбөр”-ийг тус тус боловсруулж, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2021 оны “Сургалтын хөтөлбөр батлах тухай” А/309 дүгээр тушаалаар баталсан. Эдгээр хөтөлбөр нь үндэсний хэмжээнд анх удаа батлагдаж байгаа бөгөөд ерөнхий боловсролын сургуульд суралцаж буй харааны бэрхшээлтэй хүүхдэд ахуйн баримжаа болон хөдөлгөөн орон зайн баримжаа олгох сургалтыг ганцаарчилсан хэлбэрээр зохион байгуулах багшид дэмжлэг болох юм. Мөн хөтөлбөрийг хэрэгжүүлэх суралцахуйн удирдамжийг боловсруулж, сургуулийн удирдлага, багш нарт хүргэсэн. Мөн “Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөгөөр хичээллэж буй суралцагчийг үнэлэхэд баримтлах чиглэл”-ийг боловсруулж, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2021 оны А/325 дугаар тушаалаар баталсан. Энэхүү чиглэл нь Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2018 оны А/425 дугаар тушаалаар батлагдсан “Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчийн болон сургалтын чанарын үнэлгээний журам”-тай харилцан уялдаатай хэрэгжинэ. Чиглэл нь ерөнхий боловсролын сургуульд сурч байгаа хөгжлийн бэрхшээлтэй 6,208 хүүхдийн ахиц,	90%	

					амжилтыг бодитой үнэлэхэд дэмжлэг болно.	
27	7. Үндэстний цөөнх монгол хэл болон эх хэл дээр боловсрол эзэмших, соёл, зан заншлаа өвлөх боломжийг бүрдүүлнэ.	2020 - 2024		Монгол хэл, эх хэлний сургалтын хөтөлбөр, Хос хэлний боловсролын багш бэлтгэх, чадавхжуулах, мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлсэн байна.	Үндэстний цөөнх иргэн түүх, ёс заншил, өв соёлыг хадгалж үлдэх, эх хэлээрээ суралцах эрхийг хангах зорилгоор Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2021 оны А/339 дүгээр тушаалаар Хөвсгөл аймгийн Тува иргэдийн хүүхдэд зориулсан “ Тува хэлний сургалтын жишиг хөтөлбөр”-ийг баталлаа. Мөн бага боловсролыг эх хэлээр эзэмшиж байгаа Баян-Өлгий аймгийн ерөнхий боловсролын сургуулийн 2-5 дугаар ангийн сурагчдад зориулсан "Монгол хэлний хичээлийн сургалтын жишиг хөтөлбөр"-ийг Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2021 оны А/338 дугаар тушаалаар батлан 2021-2022 оны хичээлийн жилээс эхлэн хэрэгжүүлж байна. Үндэстний цөөнх хүүхдүүдийн (казах, тува) сургалтын чанарыг дээшлүүлэх, тэдний төрийн (монгол) хэл болон эх хэлний үгийн нөөцийг нэмэгдүүлэх, хос хэлээр суралцахад сургалтын хэрэглэгдэхүүн болгон ашиглах монгол-казах, казах-монгол, монгол-тува, тува-монгол хэл дээр сургалтын толь бичиг боловсруулах зорилгоор БШУ-ны сайдын 2021 оны А/94 дүгээр тушаалаар "Сургалтын толь бичиг " боловсруулах зардлыг баталж, толь бичиг (математик, биологи, байгалийн шинжлэл, дүрслэх урлаг, биеийн тамирын хичээлийн)-ийг зохиож, хэвлэн туршиж байна. Сургалтын толь бичигт монгол-казах хэл дээр нийт 5600 үг (5 хичээл тус бүр дээр 680-1800 үгийн хооронд, хамгийн их биологийн хичээл), монгол-тува хэлний сургалтын толь бичигт нийт 3400 гаруй үг (4 хичээл) орсон байна. Цаатан иргэдийн боловсролыг дэмжих зорилгоор их, дээд сургуулийн бакалаврын хөтөлбөр элсэгчдэд Засгийн газрын 2021 оны 264 дүгээр тогтоолоор төрөөс санхүүгийн дэмжлэг үзүүлж байна. Энэ хүрээнд Хөвсгөл аймгийн Цагааннуур сумын ерөнхий боловсролын сургуулийг төгссөн бакалаврын хөтөлбөрт сурч байгаа цаатан иргэдийн 13 суралцагчдад 17.0 сая төгрөгийн сургалтын төлбөрийн буцалтгүй тусламж олгосон байна.	100%
28	8. Гадаад улсад монгол сургууль, насан туршийн сургалтын төвийн үйл ажиллагаа эрхлэх эрх зүйн орчныг бий болгож, дэмжлэг үзүүлнэ.	2020 - 2024	160.0	Гадаад улсад сургууль, насан туршийн боловсролын төв байгуулах зохицуулалтыг бий болгож, Боловсролын салбарын мэдээллийн системд оруулсан байна.	“Насан туршдаа суралцахуйн бодлого, төлөвлөлтийг боловсронгуй болгох судалгаа, шинжилгээ хийж, санал боловсруулах ажлын хэсгийг БШУ-ны сайдын 2021 оны А/245 дугаар тушаалаар байгуулан ажиллуулж байна. Ажлын хэсгээс гадаад улсад насан туршийн боловсролын төв байгуулах, төв байгуулахад тавих нийтлэг шаардлага, тусгай зөвшөөрөл хэрхэн олгох зэрэг чиглэлээр Хилийн чанад дахь Монголчуудын холбоо ТББ-аар уламжлан санал авч байна. Мөн Боловсрол, шинжлэх ухааны сайд, Гадаад харилцааны сайд, Соёлын сайдын 2021 оны А/304,47, 173 дугаар хамтарсан тушаалаар “Гадаад улсад амьдарч байгаа Монгол Улсын харьяат иргэдийн хүүхдэд монгол хэл, түүх, соёл, ёс заншлын боловсрол олгох ажлыг бодлого, зохицуулалтаар хангах байнгын ажиллагаатай салбар дундын комисс” байгуулагдан ажиллаж байна.	70%

29		9. Өсвөр насны бүх хүүхдэд нийгэм-сэтгэл хөдлөлийн ур чадварт суралцахад туслах хичээлээс гадуурх чанартай үйл ажиллагаанд хамрагдах хүртээмжийг нэмэгдүүлнэ.	2020 - 2024	700.0	ЕБС-ийн суралцагчдын 30 хувийг хичээлээс гадуурх үйл ажиллагаанд хамруулсан байна.	Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2020 оны А/199 дүгээр тушаалаар “Хичээлээс гадуурх сургалтын ажлын үлгэрчилсэн хөтөлбөр”-ийг баталсан. Мөн “Ковид-19” халдварт цар тахлын үед ЕБС-ийн 12 дугаар ангийн суралцагчдад шалгалтын өмнөх стресс менежмент, сэтгэл зүйн бэлтгэлд дэмжлэг үзүүлэх, зөвлөгөө өгөх “Чатбокс” үйлчилгээг 2021 оны 5-6 сард зохион байгууллаа. Энэхүү үйлчилгээнд давхардсан тоогоор нийт 248 хүн холбогдсоны 96.3 хувь нь төгсөх ангийн хүүхэд бүрдүүлсэн. Чатбоксоор сэтгэл зүйн зөвлөгөө авсан 173 үйлчлүүлэгчийн 67 хувь нь шалгалтын айдас, түгшүүрийн улмаас зөвлөгөө авчээ. Хүүхдийг ивээх сангаас хэрэгжүүлж “Хувь хүний интерпрениешипд суурилсан хувь хүний ур чадвар олгох” төслийн санхүүжилтээр зохион байгуулсан “Хүүхдийн нийгэм сэтгэл хөдлөлийн ур чадвар олгох” сургалтад төслийн 5 аймгийн 25 сумын 14-25 насны 2097 хүүхэд залуучууд хамрагдсан байна. Үүний 836 хүүхэд залуучууд сургалтаа төгссөн. Үлдсэн сурагчид үргэлжлүүлэн суралцаж байна. Сургалтын хүрээнд тэтгэлэгт хөтөлбөр зарлагдсан. Тэтгэлэгт хөтөлбөрт 32 багийн 151 хүүхэд оролцсоноос 5 баг шалгарсан, 4 баг нь ерөнхий боовсролын сургуулийн сурагчдаас бүрдсэн баг байна. Мөн Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн төсөлд "Ерөнхий боловсролын сургуульд сэтгэл зүйч ажиллах бөгөөд сэтгэл зүйч нь суралцагчийн сэтгэл зүйн тулгамдсан асуудлыг илрүүлэх, ганцаарчилсан болон бүлгээр сэтгэл зүйн дэмжлэг, үйлчилгээ үзүүлнэ" гэж тусгаад байна. Ерөнхий боловсролын сургуульд 2021-2022 оны хичээлийн жилээс эхлэн сэтгэл зүйчийг ажиллуулж эхэллээ. Энэ хүрээнд "сэтгэл зүйч" мэргэжлээр бакалаврын зэрэгтэй төгссөн 62 иргэнийг 12 багц цагийн мэргэшүүлэх сургалтад хамруулж, сургуулийн сэтгэл зүйчээр давтан бэлтгэсэн бөгөөд 2021 оны жилийн эцэст 121 сургууль (төрийн өмчийн 99 сургууль)-д нийт 124 (төрийн өмчийн сургуульд 102) сэтгэл зүйч ажиллаж байна.	90%
30	2.3.5. Мэргэжилтэн бэлтгэх тогтолцоог төгсөгчдийн мэргэжлээрээ хөдөлмөр эрхлэлттэй уялдуулан судалгаа боловсруулалтын ажлын үр дүнд суурилсан өрсөлдөөнт санхүүжилтийн тогтолцоог бий	1. Судалгаанд суурилсан үндэсний их сургуулийн эрх зүйн орчныг бий болгож, судалгааны их сургуулийг хөгжүүлж эхэлнэ.	2020 - 2024	85,500.0	Зээлийн гэрээ байгуулж, төслийг эхлүүлсэн байдал	1. Судалгааны их сургуулийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийг УИХ-д өргөн мэдүүлсэн. 2. Азийн хөгжлийн банкны 30 сая ам.долларын зээлээр 2022 оноос хэрэгжих Судалгааны их сургууль хөгжүүлэх төслийн дизайн батлагдсан. (2021 оны 08 дугаар сарын 27-ны өдөр байгуулсан Зээлийн баримт мэдээлэл цуглуулах ажлын үр дүнг баталгаажуулах Санамж бичиг). 3. Уг төслийг 2022 онд эхлүүлэхээр төлөвлөж байгаа бөгөөд Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр батлагдаж байж АХБ-тай зээлийн гэрээ байгуулах эрх зүйн үндэслэл бүрдэнэ. Одоогийн байдлаар Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн төсөл нь Засгийн газрын хуралдаанаар 2021.12.08-нд хэлэлцүүлж, УИХ-аар хэлэлцүүлэхээр	70%

	болгож, судалгаанд суурилсан үндэсний их сургуулийг хөгжүүлнэ.				ЗГХЭГ-аас 2021.12.24-нд өргөн мэдүүлсэн байна.	
31	2. Салбар тус бүрийн хүний нөөцийн бодлого, төлөвлөлт, тэргүүлэх чиглэл, нэн хэрэгцээтэй хүний нөөцийн эрэлт, хэрэгцээний судалгаа, мэдээлэлд үндэслэн дээд боловсролтой мэргэжилтэн бэлтгэнэ.	2020 - 2024		Хүний нөөцийн эрэлт, хэрэгцээний судалгааг нэгтгэн, тэргүүлэх чиглэлийг жил бүр тогтоосон байдал	Монгол Улсын хөгжлийн бодлогын баримт бичиг, үзэл баримтлал, үйл ажиллагааны төлөвлөгөө, хөтөлбөрийн зорилго, зорилтод нийцүүлэн, дэлхийн хэмжээнд 2030 он хүртэл хамгийн их эрэлттэй байх, ирээдүйд хэрэгцээтэй гэж төсөөлөгдөж байгаа мэргэжлүүдийн судалгаанд тулгуурлан нэн шаардлагатай тэргүүлэх чиглэлийн мэргэжлийн жагсаалтыг Засгийн газрын 2020 оны 70 дугаар тогтоолоор батлуулсан. Дотоодын их, дээд сургууль, коллежид мэргэжилтэн бэлтгэх тогтолцоог төгсөгчдийн мэргэжлээрээ хөдөлмөр эрхлэлттэй уялдуулах салбарт нэн шаардлагатай байгаа хүний нөөц, төгсөөд ажлын байраар хангагдах нөхцөл боломжид тулгуурлан шинэчлэхээр төлөвлөн ажиллаж байна. Мөн дотоодын их, дээд сургууль, коллежийн мэргэжлийн хөтөлбөрийн үнэлгээний чанарыг сайжруулж, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн хөтөлбөрийн тоог нэмэгдүүлэх зорилтын хүрээнд сургалтын хөтөлбөрт хөндлөнгийн үнэлгээ хийж, хөтөлбөрийн давхардлыг арилгах ажлын хүрээнд Боловсрол, шинжлэх ухааны сайдын А/242 дугаар тушаалаар ажлын хэсэг байгуулагдаж дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд: 1. "Дээд боловсролын сургалтын байгууллагад мөрдөж байгаа бакалавр, магистр, докторын мэргэжлийн чиглэл /хөтөлбөр/, индексийг сайжруулах" санал боловсруулсан. 2. "Дээд боловсролын сургалтын байгууллагын хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалтын аргачлал боловсруулах зөвлөмж боловсруулсан. 3. Боловсрол, шинжлэх ухааны сайдын А/174 тоот тушаал "Дээд боловсролын бакалаврын хөтөлбөрт тавигдах нийтлэг шаардлага"-д нэмэлт өөрчлөлт оруулах санал боловсруулагдаж дууссан.	100%
32	3. Их, дээд сургуулийн мэргэжлийн хөтөлбөрийн чанарын үнэлгээг сайжруулана.	2020 - 2024	900.8	Их, дээд сургуулиудын бакалавр, магистр, докторын хөтөлбөрийг мэргэжлийн чиглэлээр ангилж, чанарын үнэлгээг хийсэн байдал	Их, дээд сургуулийн хөтөлбөрийн чанарыг сайжруулахаар дараах ажлууд хийгдэж байна. Үүнд: 1. Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлтэй гэрээ байгуулан ажиллаж байгаа 16 дээд боловсролын сургалтын байгууллагаас магадлан итгэмжлэгдсэн 6 сургууль, шинжээч ажилласан 2, өөрийн үнэлгээний тайлан бичиж байгаа 8 сургууль байна. Нийт 23 дээд боловсролын сургалтын байгууллагын 89 сургалтын хөтөлбөр тус тус магадлан итгэмжлэгдсэн байна. Нийт магадлан итгэмжлэгдсэн 89 хөтөлбөрөөс 70 бакалаврын, 16 магистрын, 2 докторын, 1 дипломын хөтөлбөр байна. Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөл ХБНГУ-ын магадлан итгэмжлэлийн АСQUIN байгууллагатай хамтарсан магадлан итгэмжлэлийг МУБИС-ийн Нийгэм, хүмүүнлэгийн ухааны сургуулийн "Багш, гадаад хэлний боловсрол" /Англи хэл/, "Багш гадаад хэлний боловсрол /Герман хэл/" хөтөлбөрүүд дээр Монгол, Германы хамтарсан шинжээчийн баг ажилласан. 2. Багш мэргэжлийн хөтөлбөрийн чанарыг сайжруулах зорилгоор БШУСайдын 2021 оны А/133 дугаар тушаалаар ажлын хэсэг байгуулагдаж дараах ажлуудыг хийсэн. Үүнд:	100%

						<p>Багш бэлтгэх хөтөлбөрт тавих нийтлэг шаардлага, багшлах дадлагын шаардлага, шинэ зууны Монгол багшийн загварын төслийг боловсруулсан.</p> <p>Гадаад болон дотоодод магадлан итгэмжлэгдсэн багш мэргэжлийн хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн судалгааг хийсэн.</p> <p>Сургалтын хөтөлбөр судлалаар эрдэм шинжилгээний хурал зохион байгуулж, хэлэлцүүлэг өрнүүлсэн.</p> <p>3. Нягтлан бодох бүртгэлийн мэргэжилтнүүдийн чадавхыг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зөвлөх үйлчилгээний зөвлөмж, судалгааны 2021 оны “Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн мэргэжилтний чадавхын өнөөгийн байдалд хийсэн дүн шинжилгээний тайлан”-г БШУЯ болон Сангийн яамны хамтран гаргалаа. Судалгааны тайлан, дүгнэлтэд үндэслэн сургалтын хөтөлбөр, сургалтын арга зүй, суралцах орчин, багш болон элсэгчдэд тавигдах шаардлага, төгсөгчдийн эзэмших ур чадвар, суралцагчийн үнэлгээ, чанарын баталгаажуулалт зэрэг тус бүрд дүгнэлт, зөвлөмж боловсруулж, дээд боловсролын сургалтын байгууллагуудад танилцуулж, зөвлөмжийг хүргүүлсэн.</p> <p>4. Дээд боловсролын чанарын тогтолцоог сайжруулах хөтөлбөрийг хэрэгжүүлж байна. Энэ хөтөлбөрийн хүрээнд сургалтын хөтөлбөрийн дотоод чанарын баталгаажуулалтын тогтолцоог бүрдүүлэх, сайжруулах тухай сургалтыг Темасек сангийн дэмжлэгтэйгээр Сингапурын мэргэшсэн багш нартай хамтран зохион байгуулсан. Энэ ажлын хүрээнд дээд боловсролын чанарын баталгаажуулалтын гарын авлага хийх ажлын хэсгийг Боловсрол, шинжлэх ухааны сайдын А/448 дугаар тушаалыг батлуулсан.</p>	
33	4. Судалгаа, шинжилгээний ажлын санхүүжилтийг нэмэгдүүлж, орлогын олон талт (эндоумент, венч сан) эх үүсвэрийг бий болгоно.	2020 - 2024	3,000.0	Эндоумент, Венч сан байгуулах дүрэм журам боловсруулагдаж, эрх зүйн орчинг бүрдүүлсэн байдал	Судалгааны их сургуулийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийг Монгол Улсын Засгийн газраас 2021 оны 06 сарын 24-ны өдөр Улсын Их Хуралд өргөн барьсан. 2021 оны 06 дугаар сарын 29-нд Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороо, Улсын Их Хурлын нэгдсэн чуулганаар дэмжигдэн 2021 оны намрын чуулганаар хэлэлцэж эхэлсэн. Уг хуулийн төсөлд Эндоумент, Венч сан байгуулах журмыг батлуулах, судалгаа, шинжилгээний ажлын санхүүжилтийг нэмэгдүүлэх, орлогын олон талт эх үүсвэрийг бий болгох талаар бүлэг заалтыг /10 дугаар зүйл, 30 дугаар зүйл/ тусгаж өгсөн.	70%	
34	5. Судалгааны ажлын явц, үр дүнг хянах, хүлээж авах, үнэлэх механизмыг боловсронгуй болгож, үр дүнг шинээр төсөл	2020 - 2024		Судалгааны ажлын явц, үр дүнг хянах, хүлээж авах, үнэлэх үйл ажиллагааны эрх зүйн орчинг боловсронгуй	“Шинжлэх ухаан, технологийн төсөл хэрэгжүүлэх журам”-ын дагуу шинжлэх ухаан, технологийн судалгаа хөгжүүлэлтийн ажлын хэрэгжилтийн явц, гүйцэтгэлд хяналт, мониторинг хийж, гарсан үнэлгээ дүгнэлтийг үндэслэн 2021 оны байдлаар суурь судалгааны үргэлжлэн хэрэгжиж буй 115 төслийн 1 тэрбум 870 сая төгрөг, шинээр хэрэгжиж буй 64 төслийн 811 сая, суурь хавсарга судалгааны 18 грант төсөлд 113 сая төгрөг, гадаадтай хамтарсан 32 төслийн 285.1 сая төгрөг, үргэлжлэн хэрэгжиж буй улсын захиалгат 54 төслийн 1 тэрбум 314 сая төгрөг,	70%	

		хэрэгжүүлэх, санхүүжүүлэх үйл ажиллагааны гол шалгуур болгох замаар төслийн санхүүжилтийн уян хатан, өрсөлдөөнт тогтолцоог бий болгоно.			болгосон байдал	шинээр хэрэгжиж буй 28 төслийн 687 сая төгрөг, инновацийн 16 төслийн 331.2 сая төгрөг, технологийн туршилт зүгшрүүлэлтийн 14 төслийн 231.6 сая төгрөг, докторын дараах инновацийн 20 төслийн 145 сая төгрөгийн санхүүжилтийг тус тус олгох шийдвэрийг гаргаж, шинжлэх ухаан, технологийн төслийг санхүүжүүллээ. Үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоог шинжлэх ухаан, техонлоги, инновацийн салбарт нэвтрүүлэх, санхүүжилтийн шинэчлэлийг хэрэгжүүлэх зорилгоор "Төрийн өмчит эрдэм шинжилгээний байгууллагын судалгааны үндсэн чиглэлийг санхүүжүүлэх журам", "Шинжлэх ухаан, техонлогийн сангаас тэтгэлэг олгох, сангийн хөрөнгийг захиран зарцуулахад хяналт тавих журам"-ын төслийг тус тус боловсруулсан. Ингэснээр үр дүнд суурилсан санхүүжилт болох тогтмол, өрсөлдөөнт санхүүжилтийн хэлбэрээр судалгааны ажлыг санхүүжүүлэх боломж бүрдэж, улмаар эрдэм шинжилгээний хүрээлэн төв, салбарын өрсөлдөх чадвар бэхжиж, судалгаа хөгжүүлэлтийн ажлын чанар, хүртээмж нэмэгдэх бүрэн боломж бүрдэж байна.	
35		6. Судалгааны үр дүнд бий болсон олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн эрдэм шинжилгээний өгүүлэл, бүтээл, патент бүрийг урамшуулах тогтолцоог бий болгож, шинэ мэдлэг, патентыг үйлдвэрлэлд нэвтрүүлэн эдийн засгийн эргэлтэд оруулна.	2020 - 2024	1,400.0	Олон улсад өндөр чансаатай мэргэжлийн сэтгүүлд өгүүлэл хэвлүүлсэн шилдэг судлаачдыг урамшуулсан байдал	Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2021 оны А/141 дүгээр тушаалаар "Эрдэм шинжилгээний шилдэг бүтээл сонгон шалгаруулж, урамшуулах журам"-ыг шинэчлэн батлуулсан. Журмын дагуу эрдэм шинжилгээний шилдэг бүтээлийн шагналыг "ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ШИЛДЭГ ӨГҮҮЛЭЛ", "ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ШИЛДЭГ НОМ" гэсэн 2 төрөлд тодорхой стандарт, шалгуур, шаардлагыг баримтлан шалгаруулж, тус бүр 10 сая төгрөгийн мөнгөн урамшууллаар шагнадаг. 2021 ОНД Монгол Улсын боловсролын их сургуулийн багш, эрдэмтэн Б.Хоролдагвын "Графын ирмэг-оройн зэрэг ба орой-ирмэгийн зэрэг", Шинжлэх ухааны академийн Хими, химийн технологийн хүрээлэнгийн эрдэмтэн Т.Азаяагийн "Баруун өмнөд Германы хаягдал ус боловсруулах үйлдвэрүүдээс ялгарч буй метан (CH4) ба азотлог хий (N2O)-н судалгаа", Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн багш, эрдэмтэн Г.Хулангийн "Монгол Улсын 3-р шатлалын эмнэлгийн сувилахуйн тусламж үйлчилгээний чанарт нөлөөлөх хүчин зүйлсийг урьдчилан таамаглах нь", Хөдөө аж ахуйн их сургуулийн багш, эрдэмтэн Б.Мөнгөн-Очирын "Адууны нийлүүлгийн өвчний үед захын мэдрэлийн ёзоорын үрэвсэл, эмгэгт өөрчлөлтийг илрүүлсэн дүн", Монгол Улсын их сургуулийн багш, эрдэмтэн Б.Эрдэнэбатын "Богино хугацаат хүүний хувь, инфляц, эдийн засгийн өсөлтийн хоорондын хамааралд гарч буй өөрчлөлтүүд", Монгол Улсын их сургуулийн багш, эрдэмтэн Д.Баярсайханы "Монголчуудад баригдаж хоригдсон Киракос" бүтээлүүд "ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ШИЛДЭГ ӨГҮҮЛЭЛ" төрөлд, Шинжлэх ухааны академийн Ботаникийн цэцэрлэгт хүрээлэнгийн эрдэмтэн И.Түвшинтогтох нарын "Их нартын байгалийн нөөц газрын ургамлын аймаг, ургамалжил", Монгол Улсын их сургуулийн багш, эрдэмтэн	100%

						Ч.Сономдагвын “Монгол орны хотуудын хүрээлэн буй орчин”, Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн багш, эрдэмтэн Д.Бадарчийн “Дээд боловсролын онол, арга зүй” бүтээлүүд “ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ШИЛДЭГ БҮТЭЭЛ”-ийн төрөлд тус тус шалгарч, нийт 90 сая төгрөгийн мөнгөн шагналаар шагнагдлаа.	
36	2.3.6. Хөгжлийн тэргүүлэх чиглэлээр суралцаж байгаа болон сургалт, судалгааны ажлын амжилтаар тэргүүлэгч оюутнуудад 100 хувь	1. "Боловсролын зээлийн сан"-г орлогын олон талт эх үүсвэр бүхий "Боловсролын хөгжлийн сан" болгож оюутныг дэмжсэн үндэсний тэтгэлэгт хөтөлбөр хэрэгжүүлнэ.	2020 - 2024	142,015.1	"Боловсролын хөгжлийн сан" - ийн чиг үүрэг, бүтцийг шинэчлэн тогтоосон байдал	Засгийн газрын 2021 оны 08 дугаар сарын 275 дугаар тогтоолоор Ерөнхийлөгчийн болон Ерөнхий сайдын нэрэмжит сургалтын тэтгэлэг олгох журмууд баталагдсан. Ерөнхийлөгчийн тэтгэлэгт хамрагдах иргэдийн сонгон шалгаруулалтыг журмын дагуу 2021 оны 10-11 дүгээр сард зохион байгуулж, 428 суралцагч сонгогдсон. Ерөнхий сайдын сайдын тэтгэлэг зарлагдаагүй байна. Мөн Засгийн газрын 347 дугаар тогтоолоор "Боловсролын зээлийн сангийн хөрөнгийг зарцуулах, түүнд хяналт тавих журам" батлагдсан. Засгийн газрын 2021 оны "Боловсролын зээлийн сангийн талаар авах арга хэмжээний тухай" 264 дүгээр тогтоолоор Боловсролын зээлийн сангийн Ажлын албаны орон тооны хязгаарыг тогтоож, Боловсролын зээлийн сангийн Ажлын албаны зохион байгуулалтын бүтцийг баталж мөрдүүлэхийг үүрэг болгосон. Үүний дагуу Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2021 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн "Боловсролын зээлийн сангийн бүтэц шинэчлэн батлах тухай" А/353 дугаар тушаалаар Боловсролын зээлийн сангийн бүтцийг 5 хэлтэс, 32 ажилтан, албан хаагчтай байхаар батлан үйл ажиллагаа зохион байгуулан ажиллаж байна.	90%
37	хүртэл сургалтын төлбөрийн тэтгэлэг олгох "Ерөнхий сайдын нэрэмжит тэтгэлэгт хөтөлбөр" хэрэгжүүлнэ.	2. Засгийн газрын тэтгэлэг, зээлээр гадаадад дээд боловсрол эзэмшигчдийг мэргэжлээр нь хөдөлмөрийн зах зээлтэй уялдуулан томилон ажиллуулах зохицуулалт хийнэ.	2020 - 2024	26,993.4	Элсэгчидтэй эзэмшсэн мэргэжлээр нь томилон ажиллуулах гэрээг байгуулж, суралцагчдад тэтгэлэг олгосон байна. /200-250 оюутан/	Хөгжлийн тэргүүлэх чиглэлээр гадаадын их, дээд сургуульд Засгийн газрын гэрээ хэлэлцээрийн хүрээнд суралцаж байгаа 97 оюутанд 4,6 тэрбум төгрөгийн амьжиргааны тэтгэлэг, бакалаврын зэргийн сургалтад суралцаж байгаа 111 оюутанд 12,8 тэрбум, магистр болон докторын сургалтад суралцаж байгаа 37 оюутанд 3,5 тэрбум төгрөгийн сургалтын төлбөрийн зээл олгосон байна. Засгийн газрын 2021 оны 275 дугаар тогтоолоор Ерөнхийлөгчийн нэрэмжит сургалтын тэтгэлэг олгох журмыг батлуулж, журмын 7.3-т заалтад “төгсөөд гэрээний дагуу засаг, захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид 5 ба түүнээс дээш жил ажиллах”, Ерөнхий сайдын нэрэмжит сургалтын тэтгэлэг олгох журмын 6.1.-д тэтгэлгээр суралцах иргэдтэй гэрээ байгуулах үүргийг Боловсролын зээлийн санд хариуцуулах зохицуулалтыг оруулсан.	70%
38		3. Хөгжлийн тэргүүлэх болон эрэлттэй мэргэжлийн чиглэлээр амжилттай	2020 - 2024	200.0	"Ерөнхий сайдын нэрэмжит тэтгэлэгт хөтөлбөр" батлагдаж, 25-30 оюутанд	Засгийн газрын 2021 оны “Журам батлах тухай” 275 дугаар тогтоолоор Ерөнхий сайдын нэрэмжит сургалтын тэтгэлэг олгох журмыг батлуулсан. Журмын 4.1.1-т дотоодын их, дээд сургуулийн 50 хүртэлх суралцагчид 3 сая төгрөг, 4.1.2-т 50 хүртэлх суралцагчийг дэлхийн шилдэг их, дээд сургуульд эсхүл олон улсын гэрээ, хэлэлцээрийн хүрээнд суралцуулах тухай эрх зүйн зохицуулалтыг оруулж өгсөн.	50%

		суралцагчдыг дэмжих "Ерөнхий сайдын нэрэмжит тэтгэлэгт хөтөлбөр" хэрэгжүүлнэ.			тэтгэлгийг олгож эхэлсэн байдал	Ерөнхийлөгчийн нэрэмжит сургалтын тэтгэлгийн эхний шалгаруулалтад тэнцсэн 428 хүүхдийг МУИС, ШУТИС-ийг түшиглэн "Бэлтгэл хөтөлбөрт хамруулахаар шийдвэрлэсэн бөгөөд 2021 оны "Боловсролын зээлийн сан"-д үйл ажиллагааны зардалд 1,4 тэрбум төгрөгийн санхүүжилт туссан байна.	
39	2.3.7. Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд нийцүүлэн орон нутаг дахь их сургуулиудыг хотхон хэлбэрт үе шаттайгаар шилжүүлнэ.	1. Бүсийн төв, орон нутаг дахь их сургуулийн хотхоны бүтээн байгуулалтын ажлыг үе шаттай хийнэ. (Дархан, Сэлэнгэ, Орхон, Багануур, Дорнод, Ховд, Завхан)	2020 - 2024	11,489.2	Хотхоны ТЭЗҮ, ерөнхий төлөвлөгөө боловсруулагдаж, байгаль орчны нарийвчилсан үнэлгээ, инженерийн дэд бүтэц хийгдэж эхэлсэн байна.	Засгийн газрын 2021 оны Их, дээд сургуулийг "Сургалт-эрдэм шинжилгээ-үйлдвэрлэлийн цогцолбор" болгон орон нутагт хөгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай" 321 дүгээр тогтоолоор Дархан-Уул аймаг дахь Хөдөө аж ахуйн их сургуулийн харьяа Ургамал газар тариалангийн хүрээлэнгийн Агро-Экологи, бизнесийн сургуулийг хөдөө аж ахуй, газар тариалангийн чиглэлээр төрөлжүүлэх; Өмнөговь аймагт эрчим хүч, геологи, уул уурхай, барилга, мэдээллийн технологийн чиглэлээр Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн харьяа сургуулийг шинээр байгуулах; Орхон аймаг дахь Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн харьяа "Эрдэнэт цогцолбор" дээд сургуулийг уул уурхай, технологийн чиглэлээр тус тус төрөлжүүлэн хөгжүүлэхэд шаардагдах санхүүжилтийг жил бүрийн улс, орон нутгийн төсвийн төсөлд тусгах ажлууд хийгдэж байна. Дээрх ажлын хүрээнд Дорнод аймаг дахь "Зүүн бүсийн сургалт, эрдэм шинжилгээ, үйлдвэрлэл, бизнесийн төв"-ийн Ерөнхий төлөвлөгөө, ТЭЗҮ, эхний ээлжийн барилгажилтын зургийг хийж гүйцэтгэсэн ба Дархан-Уул, Орхон, Өмнөговь аймгууд дахь "Сургалт, эрдэм шинжилгээ, үйлдвэрлэлийн цогцолбор"-ын Ерөнхий төлөвлөгөөний загвар, ТЭЗҮ-ний ажлын даалгавруудын төслийг хийж гүйцэтгэлээ.	90%
40	2.3.8. "Чадварлаг багш" арга хэмжээг хэрэгжүүлж, мэргэжлийн стандартыг нэвтрүүлэн, үнэлэмжийг хөдөлмөрийн бүтээмж, гүйцэтгэлд суурилсан тогтолцоонд шилжүүлнэ.	1. Багш мэргэжлийн стандартыг батлуулж, "Чадварлаг багш" арга хэмжээг хэрэгжүүлнэ.	2020 - 2024	450.0	Багш мэргэжлийн стандартыг боловсруулан батлуулсан байна.	Засгийн газрын 2021 оны 1 дүгээр сарын 6-ны өдрийн хуралдаанаар "Чадварлаг багш" арга хэмжээг хэрэгжүүлэх хөтөлбөрийг хэлэлцүүлж, улмаар мөн өдрийн хуралдааны 2 дугаар тэмдэглэлээр уг арга хэмжээний хөтөлбөрийг батлах эрхийг Боловсрол, шинжлэх ухааны сайдад даалгасан. Засгийн газрын тэмдэглэлийг хэрэгжүүлэх зорилгоор "Чадварлаг багш" арга хэмжээг хэрэгжүүлэх хөтөлбөр, төлөвлөгөөг Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2021 оны А/07 тушаалаар баталж, хэрэгжүүлж байна. Аймаг, нийслэлийн БСУГ, Засаг даргын тамгын газрын нийгмийн хөгжлийн хэлтэстэй хамтран орон нутгийн хөгжлийн хөтөлбөрт "Чадварлаг багш" хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг тусган төлөвлөгөөг хэрэгжүүлж байна. Хөтөлбөрийн хүрээнд Английн Засгийн газрын дэмжлэгтэйгээр Глобал Греүф институттэй хамтран нийт төрийн өмчийн 669 ерөнхий боловсролын сургуулийн захирал, менежер болох 1000 сургалтын байгууллагын удирдах ажилтан, багшийг "Дэлхийн түвшний менежер" хөтөлбөрт 2021 оны 3 дугаар сарын 23-аас 4 дүгээр сарын 27-ны хугацаанд 12 багц сэдвээр сургалтаар зохион байгуулж 860 захирал сертификат авсан. "Чадварлаг багш" арга хэмжээний хүрээнд "Багш мэргэжлийн стандарт"-ыг Боловсролын хүрээлэн, их дээд сургуулийн эрдэмтэн судлаачидтай хамтран боловсруулж байна. УИХ-д өргөн барьсан Боловсролын	90%

					ерөнхий хуулийн төсөлд багш, ажилтны нийгмийн баталгаа, мэргэжлийн тасралтгүй хөгжил, төрийн албанд тогтвортой шат ахин ажиллах талаар тодорхой заалтуудыг тусгасан. Тухайлбал: Хуулийн төслийн 13 дугаар бүлэгт багшийн эрх, үүрэг, нийгмийн баталгаатай холбоотой 35 заалт тусгагдсан. Мөн Сургуулийн өмнөх, ерөнхий боловсролын тухай хуулийн төслийн 16 дугаар бүлэгт Багшийн мэргэжлийн тасралтгүй хөгжлийн чиглэлээр 8 заалтыг тусгаад байна.	
41	2. Багш мэргэжлээр их, дээд сургуульд суралцагчдад дэмжлэг үзүүлнэ.	2020 - 2024	10,633.7	Элсэгчдийн хүйсийн тэнцвэрт байдлыг хангах чиглэлээр дэмжлэг үзүүлэх, сургалтын төлбөрт дэмжлэг үзүүлэх зохицуулалтыг бий болгосон байна.	Засгийн газрын 2021 оны “Боловсролын зээлийн сангийн талаар авах арга хэмжээний тухай” 264 дүгээр тогтоолын “Дээд боловсролын сургалтын байгууллагын суралцагчид төрөөс санхүүгийн дэмжлэг үзүүлэх журам”-ын 3.2.3, 4.2.4-д заасны дагуу багш мэргэжлээр суралцагчдад төрөөс дэмжлэг үзүүлж байна. 2021 онд төрийн өмчийн дээд боловсролын 6 сургалтын байгууллагад багш мэргэжлээр суралцаж байгаа 1443 оюутанд 1,2 тэрбум төгрөг тэтгэлэг олгосон байна. Үүнд: багш мэргэжлээр элсэгч нь элсэлтийн ерөнхий шалгалтад 650-750 оноо авсан бол сургалтын төлбөрийг 70 хувь олгодог бөгөөд 1229 оюутанд 981,7 сая төгрөг, элсэгч нь элсэлтийн ерөнхий шалгалтад 751-ээс дээш оноо авсан бол сургалтын төлбөрийг 100 хувь, хичээлийн жилийн эхний улиралд суралцагч 2.8-3.0 болон түүнээс дээш голч дүнтэй суралцсан тохиолдолд сургалтын төлбөрийг 100 хувь олгодог бөгөөд 204 оюутанд 223,0 сая төгрөгийн тэтгэлэг тус тус олгосон байна. Монгол Улсын Боловсролын их сургуульд багш мэргэжлээр элсэж буй эрэгтэй элсэгч нь элсэлтийн ерөнхий шалгалтын оноо 500-аас дээш бол сургалтын төлбөрийн эхний жилд 50 хувь хөнгөлж байна.	70%
42	3. Багшийн ажлын гүйцэтгэлд суурилсан ур чадвар, улирлын үр дүнгийн урамшууллыг бий болгоно.	2020 - 2024	146,088.0	Багшийн хөдөлмөрийн үнэлэмжийг бодитой тооцох суурь судалгаа хийсэн байна.	БШУ-ны сайдын 2021 оны 5 дугаар сарын 21 өдрийн “Ажлын хэсэг байгуулах тухай” А/198 дугаар “Салбарын цалин хөлсний асуудал хариуцсан хороо байгуулах тухай” тушаалаар Салбарын цалин хөлсний хороог төрийн болон төрийн бус байгууллага, үйлдвэрчний эвлэлийн байгууллагуудын төлөөлөл оролцсон 16 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулсан. “Монгол Улсын эрүүл мэнд, боловсролын салбарт гүйцэтгэлд суурилсан цалин хөлсний тогтолцооны загвар боловсруулах” чиглэлээр Олон Улсын Хөдөлмөрийн байгууллага болон Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамтай хамтарсан сургалт хэлэлцүүлгийг 6, 7, 11 сард онлайнаар /30 хүн/ 3 удаа, 2021 оны 12 дугаар сарын 03-ны өдөр танхимаар зохион байгуулж /25 хүн/ ажиллалаа. Мөн гүйцэтгэлд суурилсан цалин хөлстэй холбоотойгоор ОУХБ-аас зохион байгуулсан судалгаанд салбарын цалин хөлсний асуудал хариуцсан хорооны гишүүд болон салбарын ажиллагсад нийт 461 хүнийг хамрууллаа. Боловсролын салбарын хүний нөөцийн өнөөгийн байдал, түүнд шинжилгээ хийх, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлох зорилгоор Сургуулийн өмнөх боловсролын болон Ерөнхий боловсролын сургуулийн багш, удирдах ажилтнуудаас ажлын байрны болон амьдрах орчин нөхцлийн судалгааг БУМС-ээр дамжуулан 42830 багшаас санал	90%

					авч нэгтгэсэн. Түүнчлэн багшийн ур чадвар, гүйцэтгэлд суурилсан ухамшууллыг олгох ажлын хэсгийг байгуулж, холбогдох судалгааг эхлүүлээ.	
43	4. Багш мэргэжлийн ур чадвараа тасралтгүй дээшлүүлэх нөхцөлийг сайжруулна.	2020 - 2024	1,496.2	Багш өөрөө мэргэжлийн ур чадвараа тасралтгүй дээшлүүлэх, түүнийг ажлын үнэлгээнд тооцох хөгжих чиг хандлага (approach)"-ыг нэвтрүүлэх зорилгоор багш нарыг зохицуулалт хийсэн байна.	Багшийн мэргэжил дээшлүүлэх үндсэн сургалтыг зайн сургалтын хэлбэрээр зохион байгуулж байна. Боловсролын сургалтын байгууллагад 1, 5, 10 дахь жилдээ ажиллаж буй багш, удирдах болон бусад ажилтны мэргэжил дээшлүүлэх үндсэн сургалтын оролцогчдыг 141 төрлийн онлайн курсэд хамруулсан. Дэлхийн олон оронд туршлага болж байгаа "Багш ажлын байрандаа, мэргэжлийн хамт олонтойгоо хөгжих чиг хандлага (approach)"-ыг нэвтрүүлэх зорилгоор багш нарыг мэргэжлийн бүлгийн зохион байгуулалтад шилжүүлэн ажиллах үйл ажиллагааны чиглэлийг боловсруулж, хэрэгжилтийг хангаж ажиллааа. Энэхүү чиглэлийн дагуу мэргэжлийн бүлгийн үйл ажиллагаа/уулзалт, хэлэлцүүлэг, харилцан туршлага солилцох/-г технологи ашиглан цахимаар зохион байгуулсан бөгөөд Боловсролын газар, сургуулийн 350 мэргэжилтэн, багш нараас бүрдсэн баг мэргэжлийн чиглэлээр 13 бүлэг үүсгэн багш нар хамтран ажилласан. Азийн хөгжлийн банкны "Эдийн засгийн хүндрэлийн үед боловсролын чанар, хүртээмжийг сайжруулах төсөл"-тэй хамтран цахим сургалтын платформыг өргөжүүлэн хөгжүүлэх, сургалт зохион байгуулах ажлын хүрээнд 2021 оны 10-11 дүгээр сард СӨБ, ЕБС-ийн 110 багшид "Онлайн хурал, хэлэлцүүлэг зохион байгуулах арга зүй" сэдэвт сургалтыг зохион байгуулсан. БМДИ-ийн захирлын 2021 оны 02 сарын 10-ны өдрийн А/04 дугаар тушаалаар "Дээд боловсролын багшийн тасралтгүй хөгжлийг дэмжих журам"-ыг боловсруулан батлуулсан. УИХ-д өргөн барьсан Боловсролын ерөнхий хуулийн төсөлд багш, ажилтны нийгмийн баталгаа, мэргэжлийн тасралтгүй хөгжил, төрийн албанд тогтвортой шат ахин ажиллах талаар тодорхой заалтуудыг тусгасан. Мөн Сургуулийн өмнөх, ерөнхий боловсролын тухай хуулийн төслийн 16 дугаар бүлэгт Багшийн мэргэжлийн тасралтгүй хөгжлийн чиглэлээр 8 заалтыг тусган, хэлэлцүүлэх шатандаа байна. Хуулийн төслийн 13 дугаар бүлэгт багшийн эрх, үүрэг, нийгмийн баталгаатай холбоотой 35 заалт тусгагдсан. Мөн 2022 онд боловсролын салбарт хэрэгжүүлэх төсвийн шинэчлэлтэй уялдуулан багшийг ажлын байранд нь тасралтгүй хөгжүүлэх зардлыг 2022 оны улсын төсөвт 7 тэрбум төгрөгийн хөрөнгийг шийдвэрлэсэн. Холбогдох дүрэм журмыг боловсруулж байна	90%
44	5. Ерөнхий боловсролын сургуулийн багшийг тусгай хэрэгцээт боловсролын чиглэлээр	2020 - 2024	80.0	165 багшийг мэргэшүүлсэн байна.	Тайлангийн хугацаанд тусгай хэрэгцээт боловсролын чиглэлээр багш нарын мэдлэг ойлголт, арга зүйг дээшлүүлэх чиглэлээр дараах сургалтыг зохион байгууллаа: - "Тусгай хэрэгцээт боловсролын асуудал, шийдэл" сургалт (хамрагдсан багш 140) - Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллаж буй ерөнхий боловсролын сургуулийн бага ангийн багш нарын 2 удаагийн онлайн	100%

		мэргэшүүлнэ.				<p>сургалт (2021 оны 4 дүгээр сар, хамрагдсан 400 багш)</p> <p>- Сургуулийн “Дэмжлэгийн баг”-ийн гишүүдийг чадавхжуулах сургалт (2021 оны 1 дүгээр сар, хамрагдсан 180 багш)</p> <p>- Дохионы хэлний анхан шатны мэдлэг олгох сургалт (2021 оны 4 дүгээр сар, хамрагдсан 400 багш)</p> <p>- “Жайка” Олон улсын байгууллагатай хамтран “Тэгш хамран сургах боловсролын багшийн арга зүй” сэдэвт сургалт (2021 оны 9 сард хамрагдсан 180 багш, ажилтан)</p> <p>- “Койка” Олон улсын байгууллагатай хамтран “Тэгш хамран сургах боловсрол-сургалтын орчин ” сэдэвт сургалт (2021 оны 10 сард хамрагдсан 186 багш)</p> <p>Дээрх сургалтаар хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ганцаарчлан ажиллах арга зүй, хүртээмжтэй орчин бүрдүүлэх, тохирох хэрэглэгдэхүүн бэлтгэх талаар мэдлэг ойлголт өгсөн. Дээр дурдсан сургалтад 1186 багш хамрагдсан байна.</p>	
45		6. Сургуулиудын эрүүл мэндийн боловсролын хичээлд суурилан амьдралын ур чадварыг сайжруулна. (багш нарт зориулсан сургалт, сургалтын материал боловсруулалт)	2020 - 2024	100.0	Эрүүл мэндийн боловсролын багш нарын 60 хувийг чадавхжуулсан байна.	<p>НҮБ-ын Хүн амын сангийн санхүүжилтээр 2020 онд Эрүүл мэндийн лаборатори кабинетыг Багшийн хөгжлийн ордонд 2020 онд байгууллаа. Энэхүү кабинетээр дамжуулан эрүүл мэндийн багшийн хөгжлийг дэмжих "Эрүүл мэндийн багш нарт зориулсан зайн сургалтын модуль" боловсруулж, ерөнхий боловсролын сургуульд эрүүл мэндийн хичээл зааж буй багш нарыг чадавхжуулах сургалтыг зохион байгууллаа. Мөн бага, суурь, бүрэн дунд боловсролын "Эрүүл мэндийн сургалтын хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх арга зүйн зөвлөмжийг аймаг орон нутагт хүргүүллээ.</p> <p>КОВИД-19 цар тахлын тархалтын улмаас 2021-2022 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын сургуулийн хичээл, сургалтын үйл ажиллагааг танхимын болон цахим хосолсон хэлбэрээр зохион байгуулахад эрүүл мэндийн хичээлийг танхимд зохион байгуулах зохицуулалт хийсэн нь сурагчдад эрүүл мэндээ хамгаалах, эрүүл мэндийн зөв дадал хэвшилтэй болоход дэмжлэг болсон. Гарын ариун цэврийг сахих, маск зүүх, хүн хоорондын зай барих зэргээр халдвар хамгааллын дэглэм барих агуулга бүхий зурагт хуудас, теле шторк зэргийг боловсруулан олон нийтийн телевизээр явуулахын зэрэгцээ аймгийн Боловсролын газраар дамжуулан орон нутгийн телевизээр олон нийтэд хүргэсэн нь хүүхэд, эцэг эхчүүдэд эрүүл амьдралын зөв дадал хэвшил бий болгоход нөлөөлөх арга хэмжээ болсон.</p>	90%
46		7. Багшийн хөдөлмөрийн онцлог, нөхцөлд үнэлгээ хийж, тэтгэвэр тогтоох насанд өөрчлөлт оруулах	2020 - 2024		Багшийн хөдөлмөрийн онцлог, нөхцөлд үнэлгээ, судалгааг хийж, санал боловсруулсан	<p>Монгол Улсын Хөдөлмөрийн сайдын 2015 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн А/223 тоот тушаалаар “Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийх журам” батлагдсан. Энэхүү журмаар “Хөдөлмөрийн аюулгүй байдал , эрүүл ахуйн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэгт заасны дагуу ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээг стандартын асуудал эрхэлсэн байгууллагын итгэмжлэлтэй, Хөдөлмөрийн эрүүл мэндийн төвд бүртгүүлсэн, төрийн</p>	100%

		боломжийг судлана.			байна.	болон хувийн хэвшлийн мэргэжлийн байгууллага хийх” зохицуулалттай байна. Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл мэндийн төвөөс “Цэцэрлэг, сургуулийн багш нарын хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээг “Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийх журам” болон Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үндэсний хорооны 2016 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор батлагдсан “Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийх аргачилсан зөвлөмж”-ийг мөрдлөг болгон 2019 онд хийж гүйцэтгэсэн байна. Үр дүн: Үнэлгээний үр дүнгээр багш нарын хөдөлмөр “Хөдөлмөрийн хэвийн нөхцөл”-өөр үнэлэгдсэн тул тэтгэвэр тогтоолгох насыг өөрчлөлт орохгүй болно.	
47	2.3.9. Суралцагчдад ээлтэй сургалтын орчныг бүрдүүлж, хүртээмжийг нэмэгдүүлэх, тусгай хэрэгцээт хүүхдийг ердийн сургууль, цэцэрлэгт сурах, хөгжих боломжийг нэмэгдүүлэх зорилгоор дараах бүтээн байгуулалтыг хийнэ. Үүнд: - 273 цэцэрлэг ашиглалтад оруулах, - 200 шинэ сургууль ашиглалтад оруулах, - Тусгай хэрэгцээт сургууль, цэцэрлэгийн барилгыг шинэчилж, өргөтгөх, - Жил бүр нүхэн жорлонтой 100-аас доошгүй цэцэрлэг, сургууль, дотуур байрыг орчин үеийн ариун цэврийн байгууламжтай болгох.	1. Газар зүйн мэдээллийн системд суурилж боловсрол, шинжлэх ухаан, технологи, инновацийн салбарын бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалтыг төлөвлөдөг болно.	2020 - 2024	800.0	Газарзүйн мэдээллийн систем ашиглан боловсролын салбарын хөрөнгө оруулалтын төлөвлөгөө болон явцын хяналтыг хийдэг болсон байна.	Азийн хөгжлийн банкны “Эдийн засгийн хүндрэлийн үед боловсролын чанар хүртээмжийг нэмэгдүүлэх төсөл”-ийн хүрээнд газар зүйн мэдээллийн системийн суурь платформ худалдан авах үйл ажиллагааг зохион байгуулж, гүйцэтгэгчээр Ай-Си-Ти групп шалгаран гэрээ байгуулж, суурь платформыг хүлээн авсан. Тус платформ дээр боловсролын салбарын тоон мэдээллийг бүрэн оруулж, иргэд олон нийтэд www.gis.edu.mn/v2 хаягаар орж үзэх боломжийг бүрдүүлээд байна. Системийн ашиглалт үйлчилгээг Боловсролын мэдээллийн технологийн төв хариуцан ажиллах тул тус систем, БСМС хооронд бодит тоон мэдээлэл солилцох, шаардлагатай нэмэлт хөгжүүлэлтийг хийлгэх, ашиглалт үйлчилгээг хүлээн авах чиглэлээр гүйцэтгэгчтэй хамтарсан ажлын төлөвлөгөө гарган, төлөвлөгөөний дагуу ажлыг зохион байгуулж байна. Цаашид тус газар зүйн мэдээллийн системийг ашиглан бодит тоон мэдээлэлд тулгуурлан салбарын хөрөнгө оруулалт, төлөвлөлтийн тооцооллыг хийдэг болгож хөгжүүлэх зөвлөх баг сонгон шалгаруулах худалдан авах ажиллагааг зохион байгуулж байна.	50%
48	орлуулах, - 200 шинэ сургууль ашиглалтад оруулах, - Тусгай хэрэгцээт сургууль, цэцэрлэгийн барилгыг шинэчилж, өргөтгөх, - Жил бүр нүхэн жорлонтой 100-аас доошгүй цэцэрлэг, сургууль, дотуур байрыг орчин үеийн ариун цэврийн байгууламжтай болгох.	2. Цэцэрлэг, сургуулийн хүчин чадал, бүтэц, барилгын насжилт, байршлыг оновчтой тогтоож, хүн амын өсөлтийн хэтийн төлөвтэй уялдуулан хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт болон төсөв, гадаадын зээл тусламжаар 200 сургууль, 273 цэцэрлэгийн барилгыг ашиглалтад оруулсан байна.	2020 - 2024	1,459,900.0	Ерөнхий боловсролын 78 сургууль, 77 цэцэрлэг ашиглалтад оруулсан байна.	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж байгаа барилга угсралтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт 2020-2021 онд нийт төсөвт өртөг 204.8 тэрбум төгрөгийн 156.4 тэрбум төгрөгөөр санхүүжиж 56 төсөл арга хэмжээ ашиглалтад орсон байна. Үүнд: Ерөнхий боловсролын 16 сургууль хүчин чадал 5160 суудал, сургуулийн өмнөх боловсролын 27 байгууллага хүчин чадал 4735 ор, дотуур байр 9 хүчин чадал 715 ор, ерөнхий боловсролын спорт заал 3, боловсролын байгууллага 3 байна. Мөн АНУ-ын буцалтгүй тусламжаар Цэцэрлэгийн барилга /Сүхбаатар аймаг, Эрдэнэцагаан сум/ 50 ор, Цэцэрлэгийн барилга /Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум/ 50 ор, Цэцэрлэгийн барилга /Увс аймаг, Баруунтуруун сум/ 50 ор, БНХАУ-ын буцалтгүй тусламжаар Сургуулийн барилга /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 26 дугаар хороо/ 920 хүүхдийн суудал, Сургуулийн барилга /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 19 дүгээр хороо/ 640 хүүхдийн суудал, Сургуулийн барилга /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 6 дугаар хороо/ 640 хүүхдийн суудал, Сургуулийн барилга /Хан-Уул дүүрэг, 15 дугаар хороо/ 920 хүүхдийн суудал, Япон улсын буцалтгүй тусламжаар Сургуулийн	90%

		оруулна.				барилга /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг, 2 дугаар хороо, 75 дугаар сургууль/ 960 хүүхдийн суудал, Азийн хөгжлийн банкны зээлээр Сургуулийн барилга /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 122 дугаар сургууль/ 640 хүүхдийн суудал, Цэцэрлэгийн барилга /Улаанбаатар, Баянгол дүүрэг, 164 дүгээр цэцэрлэг/ 150 ор, Цэцэрлэгийн барилга /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг, 65 дугаар цэцэрлэг/ 120 ор, Цэцэрлэгийн барилга /Говьсүмбэр аймаг Сүмбэр сум, 5 дугаар цэцэрлэг/ 150 ор, нийт ерөнхий боловсролын 6 сургууль 4720 хүүхдийн, сургуулийн өмнөх боловсролын 6 байгууллага 570 орны хүчин чадалтайгаар ашиглалтад хүлээн авсан байна.	
49		3. Төр, хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлан хөдөөгийн цэцэрлэг, сургууль, дотуур байрыг шаардлага хангасан ариун цэврийн байгууламжтай болгох арга хэмжээ авна.	2020 - 2024	100,000.0	113 цэцэрлэг, 175 сургууль, 121 дотуур байрыг төвлөрсөн болон бие даасан ариун цэврийн байгууламжтай болгосон байна.	Сургууль, цэцэрлэг, дотуур байрны нүхэн жорлонг орчин үеийн дэвшилтэд технологи бүхий ариун цэврийн байгууламжаар солих ажлын худалдан авах ажиллагаа зохион байгуулах Засгийн газрын тогтоолын төсөл, танилцуулгыг 2021 оны 5 дугаар сарын 05-ны өдөр Засгийн газрын хурлаар оруулж, “Боловсролын салбарт хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын зарим арга хэмжээний тухай” ЗГ-ын 127 дугаар тогтоолыг батлууллаа. Тогтоолоор худалдан авах ажиллагааны сонгон шалгаруулалтыг холбогдох хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулах арга хэмжээ авахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгаланд даалгасан байна. Үр дүн: Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 127 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах зорилгоор Боловсрол, шинжлэх ухааны сайд “Жагсаалт батлах тухай” А/188 дугаар тушаалыг батлан гаргалаа. Тус тушаалаар төрийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, дотуур байрны нүхэн жорлонг орчин үеийн стандарт шаардлагад нийцсэн ариун цэврийн байгууламжаар солих төсөл, арга хэмжээний жагсаалт, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг хавсралтаар баталсан бөгөөд 1, 2 дугаар ээлжид 16 аймгийн 103 суманд төсөл, арга хэмжээг хэрэгжүүлж эхлэхээр гүйцэтгэгч байгууллагуудтай гэрээ байгуулсан байна. Гүйцэтгэгч компаниуд зураг төсөл, төсвийн ажил болон барилга угсралтын ажлыг гүйцэтгэж эхэлсэн байна.	90%
50		4. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд оршин суугаа газартаа цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуульд тэгш хамрагдах орчин нөхцөлийг бүрдүүлнэ.	2020 - 2024	7,900.0	Сургалтын тусгай хэрэглэгдэхүүн, туслах нэмэлт хэрэгслээр 80 цэцэрлэг, 80 сургуулийг хангасан байна. 4 сургуульд хүүхэд хөгжлийн танхимыг байгуулж, багш,	БШУ-ны сайдын 2021 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамруулах журам” А/177 дугаар тушаалаар батлагдаж, 2021 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжиж байна. 2021-2022 оны хичээлийн жилээс цэцэрлэгийн насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд тэгш хамруулах эрх зүйн орчин бүрдэж, хүүхэд оршин байгаа газартаа сургуулийн өмнөх боловсролд хамрагдах, бусдын адил тэгш, хүртээмжтэй оролцох, хөгжих, сурч боловсрох боломжтой болсон. БШУ-ны сайдын 2020 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн А/184 дүгээр тушаалаар батлагдсан “Бүх шатны боловсролын байгууллагад хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн онцлогт тохирох хэрэглэгдэхүүн, сургалтын орчныг бүрдүүлэх журам”	100%

					удирдлагын чадавхийг дээшлүүлнэ.	2021 оны 1 дүгээр сарын 02-ны өдрөөс эхлэн хэрэгжсэн. Энэхүү журам хэрэгжсэнээр хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хэрэгцээнд нийцсэн тохирох хэрэглэгдэхүүн бүхий сургалтын орчин бүрдүүлэх ажлыг зохион байгуулах харилцааг зохицуулсан. 2021-2022 оны хичээлийн жилд ердийн цэцэрлэгт 560, тусгай цэцэрлэгийн 42 бүлэгт 463, нийт 1023 (3-5нас) хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамрагдаж байна. 2021-2022 оны хичээлийн жилд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сургуулийн өмнөх боловсролын хамрагдалт 63 хувьтай байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хамрагдалт өмнөх хичээлийн жилээс 3 хувиар буюу 133 хүүхдээр нэмэгдсэн байна. Азийн хөгжлийн банк, Ядуурлыг Бууруулах Японы Сангаас хамтран хэрэгжүүлж байгаа "Тэгш хамруулах боловсролыг дэмжих төсөл" /G9208/ -ийн хүрээнд нийслэлд 1, орон нутгаас 3 цэцэрлэг сонгон, Хөгжлийн бэрхшээлтэй бага насны хүүхдийг сургуулийн өмнөх боловсролд хамруулах сургалтын орчны загвар бий болгох, цэцэрлэгийн удирдах ажилтан, багш нарыг чадваржуулах модуль сургалтуудыг зохион байгуулж байна	
51	5. Тусгай цэцэрлэг, сургуулийн барилгыг өргөтгөх, шинэчлэх, тавилга хэрэгсэл, техник, тоног төхөөрөмжөөр хангана.	2020 - 2024	40,000.0	Сонгинохайрхан дүүрэгт сувиллын цэцэрлэг, сургуулийн цогцолборын барилгын ажлыг эхлүүлсэн байна.	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд оршин суугаа газартаа цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуульд тэгш хамрагдах орчин нөхцөлийг бүрдүүлэх зорилтын хүрээнд Тусгай хэрэгцээт сургууль, цэцэрлэгийн зураг төслийг улсын төсвийн хөрөнгөөр Барилга, хот байгуулалтын яаманд захиалга өгч, зураг төслийг хүлээн авлаа. Үр дүн: 2021 оны улсын төсвийн хуульд 2021-2022 онд хэрэгжихээр "Тусгай хэрэгцээт хүүхдүүдийн сургуулийн барилга, 320 суудал /Улаанбаатар/" төсөвт өртөг 4 тэрбум төгрөг, санхүүжих дүн 2 тэрбум төгрөг, "Тусгай хэрэгцээт хүүхдийн цэцэрлэгийн барилга /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг/" төсөвт өртөг 4 тэрбум төгрөг, санхүүжих дүн 2 тэрбум төгрөгөөр батлагдсан. Барилга усралтын гүйцэтгэгч сонгон шалгаруулах худалдан авах ажиллагааны эрхийг нийслэлийн Засаг даргад шилжүүлсэн. Гүйцэтгэгчээр "Хүрэл-Ордон" ХХК шалгарч. Барилгын зургийн ажил хийгдэн магадлалд оруулсан байна. 2021 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Боловсрол, шинжлэх ухааны сайдын багцад батлагдсан тоног төхөөрөмжийн төсвөөс "Тусгай хэрэгцээт ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгт тавилга, тоног төхөөрөмж худалдан авах /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг/" төсөл, арга хэмжээнд 100.0 сая төгрөг баталсан. Уг төсөл арга хэмжээний гүйцэтгэгчээр "Сүвэн-Уул" ХХК шалгарч бараа нийлүүлэх гэрээ байгуулсан байна. Цар тахалын улмаас тоног төхөөрөмжийн тээвэрлэлт хил дээр удааширсан тул санхүүжилтийг барьцаа хөрөнгөд авч үлдэхээр албан бичгийг Сангийн яаманд хүргүүлээд байна. .	100%	
52	6. Ажил мэргэжлийн чиг	2020 -	91.2	30 төвийн үйл ажиллагааг	БШУ-ны сайдын 2020 оны А/200 дугаар тушаалаар "Ерөнхий боловсролын сургуулийн дунд, ахлах ангийн суралцагчдад ажил	100%	

		баримжаа олгох, зөвлөгөө мэдээллийн төв байгуулна.	2024		тогтвортой явуулж, хариуцсан багш нарыг чадавхжуулсан байна.	мэргэжлийн чиг баримжаа олгох үйл ажиллагааны чиглэл, “Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох мэдээллийн танхимд тавигдах шаардлага”-ыг тус тус баталж, аймаг бүрд насан туршийн боловсролын төвийг түшиглэн ажил мэргэжилийн чиг баримжаа олгох танхимыг байгууллаа. Суралцагч, эцэг эх, асран хамгаалагчдад зориулж өөрийн сонирхол, давуу талаа таньж мэдэх, чадвар, үнэт зүйлээ тодорхойлох, ахлах ангид судлах хичээл, хөтөлбөрөө сонгох, 12 дугаар анги төгссөний дараа суралцах их, дээд сургууль, мэргэжлийн хөтөлбөрөө сонгох, хөдөлмөрийн зах зээлд ажил хөдөлмөр эрхлэхтэй холбоотой ухаалаг, бодитой шийдвэр гаргахад дэмжлэг үзүүлэх зорилгоор ажил мэргэжлийн чиг баримжаа олгох портал сайтыг Боловсролын үнэлгээний төвийг түшиглэн ажиллуулж байна. Суралцагчдад зориулж цаасан хэлбэрээс www.myfuture.mn цахим хэлбэрт шилжүүлэн ажил мэргэжлийн чиг баримжаа олгож байна. Хэрэглэгч www.myfuture.mn веб сайтаас ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйл ажиллагаа, түүний талаарх мэдээ мэдээлэл авахдаа ESIS системийн бүртгэлээр, сургууль болон багш өөрийн эрхээр нэвтрэн орох боломжтой. АХБ-ны санхүүжилтээр аймаг, дүүргийн 30 насан туршийн боловсролын төвд "Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох танхим"-ийг 574.2 сая төгрөгөөр, Боловсрол, соёл урлагийн газар, хэлтсүүдэд 175.8 сая төгрөгөөр, БМДИ-д 50.3 сая төгрөгөөр буюу нийт 800.4 сая төгрөгийн тоног төхөөрөмж нийлүүлэх ажлыг зохион байгуулж ажилласан байна.	
53		7. Барилга байгууламжийн нэг маягийн болон давтан хэрэглэх зураг төсөл боловсруулах ажлыг зохион байгуулна.	2021 - 2024	1,478.6	Захиалгын дагуу нэг маягийн зураг, давтан хэрэглэх зураг төслийг боловсруулах ажлыг зохион байгуулна.	Боловсрол, шинжлэх ухааны яам сургууль, цэцэрлэг, дотуур байр, тусгай хэрэгцээт сургууль, цэцэрлэг, спорт заалны барилга байгууламжийн нэг маягийн болон давтан хэрэглэх зураг төслийг улсын төсвийн хөрөнгөөр хийлгэх захиалгын Барилга, хот байгуулалтын яаманд өгсөн. Тус захиалгын дагуу барилга байгууламжийн зураг төслийн зөвлөх үйлчилгээний тендерийг зарлаж, хийж гүйцэтгэн 2021 оны 3 дугаар улиралд Барилга, хот байгуулалтын яамнаас цэцэрлэг /150,200,250 ор/, сургууль /320,640/ суудал, бага сургууль, цэцэрлэгийн цогцолбор /150/, дотуур байр /100,160/ ор, спорт заалны 2 зураг төслийг хүлээн авсан.	100%
54	2.3.10. Цэцэрлэг, дотуур байр, ерөнхий боловсролын сургуулийн хүүхдийн хоолны зардлыг инфляц, үнийн өсөлттэй уялдуулан 2-оос доошгүй дахин нэмэгдүүлж, ерөнхий боловсролын	1. Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газрын стандартыг баталж, мөрдүүлэнэ.	2020 - 2024		Ерөнхий боловсролын сургууль, дотуур байрын хоолны газрын 20 хувийг стандартын шаардлагад нийцүүлж, өдрийн хоолны үйлчилгээ үзүүлж эхэлсэн	Боловсрол, шинжлэх ухааны сайдын “Ажлын хэсэг байгуулах тухай” 2021 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн А/75 дугаар тушаалаар “Сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний үндэсний стандартын төсөл боловсруулах” чиг үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг баталсан. Стандартын технологийн тооцоо, зураг боловсруулах ажил бүрэн дууссан бөгөөд мэргэжлийн хүмүүсийн төлөөлөл оролцсон 2 удаагийн хэлэлцүүлэг зохион байгуулж, сайжруулалт хийгдэж байна. Мөн стандартын төсөлд тусгагдсан хоолны газрын зохион байгуулалт, бүтэцтэй холбоотой тооцоог “Монгол Улсын барилгын норм ба дүрэм. Ерөнхий боловсролын сургууль, сургуулийн өмнөх боловсролын байгууллагын барилга, байгууламж”-д тусгуулах саналыг боловсруулж,	90%

	сургуулийн "Үдийн цай" арга хэмжээг "Үдийн хоол" болгоно. Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдыг шүүлтүүртэй ундны цэвэр усаар хангана.			байна.	Барилга, хот байгуулалтын яаманд 2/3643 тоот албан бичгээр хүргүүлсэн. 2021 онд ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний орчныг сайжруулах чиглэлээр улсын төсөв болон орон нутгийн төсөв, гадаадын буцалтгүй зээл тусламжаар 35 сургуулийн хоолны газрыг засварлан, зориулалтын болгож, 168 сургуульд хоол үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж нийлүүлсэн. 2022-2024 онд хэрэгжих олон улсын байгууллагын төслийн хүрээнд 55 сургуулийг хоол үйлдвэрлэл, үйлчилгээний иж бүрэн тоног төхөөрөмжөөр хангах юм. Мөн 2022 оны улсын төсөвт СХД-ийн 15 сургуульд хоол үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж нийлүүлэх төсөл арга хэмжээ тусгагдсан бөгөөд хоолны газаргүй 6 сургуульд хоолны газрын өргөтгөлийн барилга барих ажлыг эхлүүлэхээр төлөвлөөд байна.	
55	2. Ерөнхий боловсролын сургуулийн "Үдийн цай" арга хэмжээг "Үдийн хоол" болгоно.	2020 - 2024	612,741.7	350,352 (бага ангийн сурагч)	Засгийн газрын "Үдийн хоолны норматив тогтоох тухай" 2021 оны 237 дугаар тогтоолоор ерөнхий боловсролын сургуулийн бага ангийн нэг сурагчид ногдох үдийн хоолны зардлын нормативыг хүн амын зохистой хооллолтын талаарх зөвлөмжид заасан хэмжээ, инфляцын түвшинтэй уялдуулан 1500 төгрөг байхаар тогтоож, 2021-2022 оны хичээлийн жилээс эхлэн хэрэгжүүлээд байна. 2021-2022 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын сургуулийн бага ангийн 371 480 сурагчид үдийн цайны үйлчилгээнээс үдийн хоолны үйлчилгээнд шилжээд байна.	100%
56	3. Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад сургууль дээр стандартын шаардлага хангасан ундны цэвэр ус уух боломжийг бүрдүүлнэ.	2020 - 2022		155 сургуулийг цэвэршүүлэгчтэй төхөөрөмжөөр хангасан байна.	Ерөнхий боловсролын сургуульд ашиглагдаж буй ус цэвэршүүлэгч төхөөрөмжийн хэрэгцээ шаардлагыг тодорхойллоо. Ерөнхий боловсролын нийт сургуулийн 67% нь ус цэвэршүүлэгч төхөөрөмж ашиглаж байгаа бол MNS6782:2019 стандартад заасан 75 хүүхдийн дунд нэг ус цэвэршүүлэгч байхаар тооцвол төрийн өмчийн 569 сургуульд 5393 ус цэвэршүүлэгч төхөөрөмж шаардлагатай байна. 2021 онд улсын төсвөөс 159,898,230 төгрөгөөр 412 ширхэг ус цэвэршүүлэгч төхөөрөмж худалдан авах гэрээ байгуулаад байна. Ус цэвэршүүлэгч төхөөрөмж хил хаалттайн улмаас нийлүүлэх хугацааг түр хойшлуулсан, хүлээж авсан тохиолдолд 155 сургуульд нийлүүлнэ.	90%
57	4. Цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардлыг 2 дахин нэмэгдүүлж, төр, эцэг эх, асран хамгаалагч хамтран хариуцах зарчмаар	2020 - 2024	515,573.4	Эцэг эх, асран хамгаалагч нь хүүхдийн хоолны зардлын тодорхой хувийг хариуцах эрхзүйн зохицуулалтыг хийсэн байна.	Засгийн газрын "Хоолны зардлын норматив тогтоох тухай" 2019 оны 450 дугаар тогтоолоор өдрийн цэцэрлэгийн нэг хүүхдэд ногдох өдрийн хоолны зардлыг 2475 төгрөг, 24 цаг болон тусгай, сувиллын цэцэрлэгийн нэг хүүхдэд ногдох өдрийн хоолны зардлыг 3600 төгрөг байхаар тогтоосон. Цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардлын нормативыг шинэчлэн тогтоосон тохиолдолд тодорхой хувь хэмжээг эцэг эх, асран хамгаалагчаас гаргуулах талаар судалгаа тооцоог хийлээ. Цэцэрлэгийн хоол хүнснээс авбал зохих илчлэгт хүрсэн байхаар хоолны зардлыг тооцвол 48 хувиар буюу ердийн цэцэрлэгийн хоолны зардал 4740	70%

		хэрэгжүүлнэ.				төгрөг, сувилал, тусгай, 24 цагийн цэцэрлэгийн хоолны зардалд 6315 төгрөг байх тооцоо гарч, Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулаад байна.	
58		5. Боловсролын байгууллагын тавилга, тоног төхөөрөмж, техник хэрэгсэл, лабораторийн хүртээмжийг нэмэгдүүлнэ.	2020 - 2024	188816	Шинэ сургууль, цэцэрлэг, насан туршийн боловсролын төвийг тавилга, тоног төхөөрөмжөөр хангасан байна.	Улсын төсвийн 2021 оны “Боловсрол, шинжлэх ухааны салбарын тоног төхөөрөмж” багцаас Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2021 оны А/03 дугаар тушаалаар Боловсролын байгууллагын тавилга, тоног төхөөрөмж, техник хэрэгсэл, лабораторийн хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор төсөвт өртөг 9.8 тэрбум төгрөгийн 11 төсөл, арга хэмжээг баталсан. Тус төсөл, арга хэмжээнүүдийн худалдан авах ажиллагааг зохион байгуулж гүйцэтгэгч компаниудтай гэрээ байгуулан, төлөвлөгөөт хугацаанд сургууль, цэцэрлэг, дотуур байр, насан туршийн боловсролын байгууллагуудад шаардлагатай тоног төхөөрөмжийг олгохоор барааг хүлээн авсан байна. “Боловсролын чанарын шинэчлэл” төслийн хүрээнд Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг ерөнхий боловсролын сургуульд тэгш хамран сургах зорилгоор Архангай, Булган, Дорноговь, Өмнөговь, Сүхбаатар, Завхан, Төв, Хэнтий аймгуудын төвийн сургуульд “Хүүхдийн хөгжлийг дэмжих танхим” байгуулан нийт 265,2 сая төгрөгийн өртөг бүхий ном, тавилга, тоног төхөөрөмж, тоглоом, туслах хэрэгсэл нийлүүлэх арга хэмжээ авч ажиллалаа. 2020-2021 оны хичээлийн жилд Японы “Хүүхдийг ивээх сан”-гийн “Хүүхэд бүрийг тэгш хамран сургах нь” төслөөс 16 сургууль 5 НТБТ-д 41 сая төгрөгийн өртөг бүхий сургалтын тохирох хэрэглэгдэхүүн нийлүүлсэн байна. Үр дүн: Улсын төсвийн 2021 оны “Боловсрол, шинжлэх ухааны салбарын тоног төхөөрөмж” багцаас Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2021 оны А/03 дугаар тушаалаар Боловсролын байгууллагын тавилга, тоног төхөөрөмж, техник хэрэгсэл, лабораторийн хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор төсөвт өртөг 9.8 тэрбум төгрөгийн 11 төсөл, арга хэмжээг баталсан. Тус төсөл, арга хэмжээнүүдийн худалдан авах ажиллагааг зохион байгуулж гүйцэтгэгч компаниудтай гэрээ байгуулан, төлөвлөгөөт хугацаанд сургууль, цэцэрлэг, дотуур байр, насан туршийн боловсролын байгууллагуудад шаардлагатай тоног төхөөрөмжийг олгож ажилласан.	100%
59	2.3.11. Сургуулийн өмнөх боловсрол, ерөнхий боловсролын сургуулийн урлаг, биеийн тамирын хичээлийн агуулга, хөтөлбөрийг сайжруулж, шаардлагатай тоног	1. Урлаг, биеийн тамирын хичээлийн сургалтын хэрэглэгдэхүүн, тоног төхөөрөмж, хөгжмийн зэмсгээр сургууль, цэцэрлэгийг	2020 - 2024	200.0	Сургалтын хэрэглэгдэхүүний стандартыг батлуулсан байна.	Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2021 оны А/193 дугаар тушаалаар “Цахим сурах бичиг, ерөнхий боловсролын сургалтад ашиглах сургалтын нээлттэй материалд тавих шаардлага”-ыг батлан хэрэгжүүлж байна. “Боловсролын чанарын шинэчлэл” төслийн хүрээнд Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг ерөнхий боловсролын сургуульд тэгш хамран сургах зорилгоор Архангай, Булган, Дорноговь, Өмнөговь, Сүхбаатар, Завхан, Төв, Хэнтий аймгуудын төвийн сургуульд “Хүүхдийн хөгжлийг дэмжих танхим” байгуулан нийт 265,2 сая төгрөгийн өртөг бүхий ном, тавилга, тоног төхөөрөмж, тоглоом, туслах хэрэгсэл нийлүүлэх арга хэмжээ авч ажиллалаа. 2020-2021 оны хичээлийн жилд	100%

	төхөөрөмжөөр бүрэн хангана.	хангана.				Японы “Хүүхдийг ивээх сан”-гийн “Хүүхэд бүрийг тэгш хамран сургах нь” төслөөс 16 сургууль 5 НТБТ-д 41 сая төгрөгийн өртөг бүхий сургалтын тохирох хэрэглэгдэхүүн нийлүүлсэн байна.	
60	2.3.12. Цахим сургалтын платформыг хөгжүүлж, цахим сургалтын хөтөлбөрийг боловсруулан, цахим агуулга, цахим хичээл боловсруулан бүх насны иргэдэд насан туршдаа суралцахуйг дэмжих боломжийг бүрдүүлнэ.	1. Бүх насны иргэд насан туршдаа суралцах боломжийг дэмжих, тэдний бие даан олж авсан мэдлэг, ур чадварыг хүлээн зөвшөөрөх, баталгаажуулах чиглэлээр насан туршийн боловсролын эрх зүйн орчинг боловсронгуй болгож өргөжүүлнэ.	2020 - 2024	2,000.0	Насан туршийн боловсролын байгууллагын санхүүжилтийн тогтолцоо, бүтэц, орон тоог шинэчилж зохион байгуулсан байна.	БШУ-ны сайдын 2021 оны А/245 дугаар тушаалаар “Насан туршдаа суралцахуйн бодлого, төлөвлөлтийг боловсронгуй болгох судалгаа, шинжилгээ хийж, санал боловсруулах ажлын хэсэг” ажиллалаа. Ажлын хэсгээс насан туршийн суралцахуй хэрхэн хэрэгжиж байгаа өнөөгийн байдлын судалгааг боловсролын бүх салбарыг хамруулан нэгтгэн зураглаж, насан туршдаа суралцахуйг албан, албан бус, амьдрах явцад суралцахуй гэсэн гурван хэлбэрээр хөгжүүлэх нь зүйтэй гэж үзсэн. Ажлын хэсгийн санал, дүгнэлтэд үндэслэн УИХ-д өргөн барьсан “Боловсролын ерөнхий хуулийн төсөл”-д “Насан туршийн суралцахуй” гэсэн бие даасан зүйлийг оруулж, дараах заалтыг тусгаад байна: Үүнд: “Насан туршийн суралцахуй” гэж бүх насны иргэн албан боловсролоос гадна хэрэгцээ, сонирхолдоо нийцүүлэн орон зай, цаг хугацаанаас үл хамааран мэргэжил, боловсрол, мэдлэг, чадвараа албан бус сургалтаар болон амьдралын орчинд суралцах замаар тасралтгүй хөгжүүлэх, дээшлүүлэх үйл ажиллагааг; Хуульд өөрөөр заагаагүй бол иргэн, хуулийн этгээд нь боловсролын чиглэлээр тусгай зөвшөөрөл шаардахаас бусад сургалтын үйл ажиллагаа эрхэлж, иргэн насан туршдаа суралцаж, мэдлэг, чадвараа тасралтгүй хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааг явуулж болно; Насан туршийн суралцахуйн бодлого, үйл ажиллагаа, удирдлага, зохион байгуулалтыг хариуцах салбар дундын зөвлөл байна. Зөвлөлийн ажиллах журам, бүрэлдэхүүнийг Боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн болон Хөдөлмөрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална; Иргэний албан бус боловсрол болон амьдралын орчинд суралцан эзэмшсэн мэдлэг, чадварыг албан боловсролын тогтолцоонд хүлээн зөвшөөрөх, баталгаажуулах журмыг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй хамтран батална. Боловсролын ерөнхий газрын бүтцэд насан туршийн боловсролын хэрэгжилт хариуцсан нэгж ажиллахаар бүтэц орон тоо батлагдаад байна. Мөн эрх зүйн орчныг бий болгохтой холбогдуулан иргэдийн суралцахуйн хэрэгцээний судалгааг хийж, үр дүнг нэгтгэн бэлэн болголоо.	70%
61		2. Цахим сургалтын нэгдсэн платформ бий болгож, цахим хичээлийн сан бүрдүүлнэ.	2020 - 2025	17,550.0	Цахим сургалтын нэгдсэн платформ хөгжүүлж, цахим хичээлийн агуулгыг боловсруулан нийтийн хүртээл	КОВИД-19 цар тахлын хүрээнд боловсролын салбарын суурь үйлчилгээг дэмжих Нэгдсэн үндэстний байгууллагын нэгдсэн төслийн хүрээнд econtent.edu.mn системийг шинэчлэн цахим сургалтын нэгдсэн платформ болгон хөгжүүлж 2.0 хувилбарыг гаргасан бөгөөд тус платформ дээр тулгуурлан үндэстний сургалтын удирдлагын MEDLE.mn платформ боловсруулсан. Тус платформ нь Монгол Улсын өнцөг булан бүрд ажиллаж, амьдарч байгаа шилдэг багшийн бэлтгэсэн цахим хичээлийг суралцагч орон зай, цаг хугацаанаас үл хамааран насан туршдаа суралцах, багш, сурагч хоорондын уялдаа холбоог хангах,	100%

					болгосон байна.	<p>харилцан бие биеэсээ суралцах боломжийг бүрдүүлэх, цахим контентын нэгдсэн сан бүрдүүлэх зорилго бүхий сургалтын хоцрогдлыг нөхөх, боловсролыг тэгш хүртээмжтэй болгох илүү хурдацтай, чанартай байх шийдлүүдийг нэг дор агуулж байгаа цахим сургалтын цогц систем юм.</p> <p>Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2021 оны “Ээлжит хичээлийн цахим контентын сан бүрдүүлэх тухай” А/237 дугаар тушаалаар ээлжит хичээлийн цахим контент, сан бүрдүүлэх ажлын удирдамж, ерөнхий боловсролын сургуулийн 16,411 ээлжит хичээлийн цахим контент сонгон шалгаруулах үнэлгээний аргачлалыг баталсан бөгөөд энэхүү удирдамж, аргачлал батлагдсанаар бүх багш, сурагчдад ерөнхий боловсролын сургуулиудад мөрдөгдөж буй хөтөлбөрийн дагуу нэгж хичээл бүрээр контент бүтээж сонгон шалгаруулалтад оролцох боломжийг бүрдүүлсэн.</p> <p>Жилийн эцсийн байдлаар ээлжит хичээлийн цахим контент бүрдүүлэх ажлын явц:</p> <ul style="list-style-type: none"> - Бэлэн болж MEDLE.mn платформ дээр байршсан 145, - Боловсруулагдаж байгаа 742, - Сонгон шалгаруулалтад оролцуулах санал ирүүлсэн 1,464, - Нийт хандалт 1,308,986 байна. <p>БШУ-ны сайдын 2021 оны “Цахим контентын сан бүрдүүлэх талаар арга хэмжээний тухай” А/397 дугаар тушаал батлагдаж 21 аймгийн Боловсролын газар, ерөнхий боловсролын 45 лаборатори сургуульд “Контент боловсруулах лаборатори” байгуулах зардлыг шийдвэрлэсэн бөгөөд байгууллагуудад контент боловсруулах лаборатори олгогдсоноор цахим ээлжит хичээлийн сан бүрдүүлэхэд байгууллага болон багшид контентоо боловсруулахад дэмжлэг үзүүлэх юм.</p>	
62	3. Багшийн мэргэжил дээшлүүлэх үндсэн сургалтыг цахим хэлбэрт шилжүүлж, багшийг мэдээлэл, харилцаа холбооны технологид суурилсан сургалт явуулах арга зүйд сургах ажлыг үе шаттай зохион байгуулна.	2020 - 2024	2,000.0	Багшийг мэдээлэл, харилцаа холбооны технологид суурилсан сургалт явуулах арга зүйд сургах, үндсэн сургалтыг цахим хэлбэрт шилжүүлсэн байна.	<p>Багшийн мэргэжил дээшлүүлэх институт нь 2019-2020, 2020-2021 оны хичээлийн жилд эхний болон 5, 10 дахь жилдээ ажиллаж буй багш, ажилтны мэргэжил дээшлүүлэх үндсэн сургалтыг 100% онлайн зайны хэлбэрээр http://esurgalt.itpd.mn онлайн сургалтын платформ дээр зохион байгууллаа. Энэхүү сургалтад 2020 онд ЕБС, НТБТ-ийн багш, удирдах болон бусад ажилтан, МБС-ийн ерөнхий эрдмийн багш, нийт 6384, 2021 онд 7134 хүн хамрагдсан байна. Мэргэжил дээшлүүлэх сургалт нь "Боловсролын бодлого чиглэл", "Мэдээлэл, харилцаа холбооны технологи", "Хувь хүний хөгжил", "Мэргэжлийн онол арга зүй" гэсэн 4 ерөнхий агуулгын хүрээнд нийт 96 цагийн цахим болон бие даалт, вебинар хэлэлцүүлэг гэсэн хосолсон арга хэлбэрээр зохион байгуулагдаж, оролцогчид нь 8 багц цагийн агуулгыг онлайнар судалсан. Үүнд:</p> <p>Боловсролын бодлого, чиглэл (12 цаг), Мэдээлэл харилцааны технологи (12 цаг), Хувь хүний хөгжил (12 цаг), Мэргэжлийн онол (36 цаг) зэрэг нийт 72 цагийн агуулгуудыг http://esurgalt.itpd.mn/ вэб-д суурилсан цахим хэлбэрээр, тухайн мэргэжлийн арга зүйн агуулга</p>	100%	

						<p>(дадлага, хэлэлцүүлэг, туршлага солилцох үйл ажиллагаа)-ыг 2 удаа 8 цагийн вебинар болон 12 цагийн бие даалт хэлбэрээр зохион байгуулсан.</p> <p>Багшийн мэргэжил дээшлүүлэх институтийн онлайн сургалтын талбар болох MOODLE системд суурилсан "Багшийн цахим кампус"-т эхний болон 5, 10 дахь жилдээ ажиллаж буй багш ажилтны мэргэжил дээшлүүлэх үндсэн сургалтын 181 онлайн курсээс гадна, STEM боловсролын сургалтын 4, "Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох" сургалтын 18, "Анги удирдсан багшаар дамжуулж, эцэг эхийн боловсролыг дэмжих нь" арга зүйн зөвлөмжийн 4, "24 цагийн үйл ажиллагаатай цэцэрлэгийн бүлгийн багшийг чадавхжуулах" сургалтын 5, "Цахим ба танхим хосолсон сургалтын арга зүйд дэмжлэг үзүүлэх сургалт"-ын Google Classroom дээрх 21-н курс нийт 322 онлайн курс үүсгэж, зорилтот бүлэг тус бүрд онлайн сургалтыг зохион байгуулсан.</p>	
63	4. Боловсролын салбарт мэдээллийн системийн инновацийг нэвтрүүлж, нэгдсэн сүлжээг өргөтгөх замаар мэдээлэл солилцох боломжийг бүрдүүлнэ.	2020 - 2024	34,448.5	Боловсролын салбарын мэдээллийн системийг бусад системтэй холбогдох боломжийг бүрдүүлсэн байна. Сүлжээний дэд бүтэц, тоног төхөөрөмж сайжруулах ажлыг эхлүүлсэн байна.	<p>Боловсролын салбарын мэдээллийн системийн удирдлагын хэсэгт сурах бичиг оруулах, сургалтын хөтөлбөр төлөвлөгөө, ээлжит хичээлийн жагсаалт үүсгэх, суралцахуйн зорилт, теле хичээл, интерактив хичээл холбох хэсгүүдийг хэрэглээнд нэвтрүүлсэн. Мөн нэгж байгууллагаас төсвийн төсөл хүлээн авах модулийг боловсруулж 2022 оны төсвийн БСМС-ээр дамжуулан төслийг цахим хэлбэрээр хүлээн авах ажлыг зохион байгуулсан бөгөөд үдийн хоол, боловсролын баримт бичгийн нөхөн олголт зэрэг үйл ажиллагааны модулиудын хөгжүүлэлтийн ажлыг эхлүүлээд байна.</p> <p>Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2021 оны "Мэдээлэл солилцох арга хэмжээний тухай" А/403 дугаар тушаалаар боловсролын салбарын мэдээллийн системийн мэдээллийн бодит байдлыг хангах, нэгж байгууллагын ажлын ачааллыг бууруулах зорилгоор боловсрол, сургалтын байгууллагын өөрийн болон бусад аж ахуйн нэгж байгууллагын хөгжүүлсэн сургуулийн удирдлагын систем, сургалтын удирдлагын системийг Боловсролын салбарын мэдээллийн системтэй сервисээр холбох боломжийг бүрдүүлсэн бөгөөд БСМС-ийн мэдээллийг харьяа байгууллага болон бусад боловсрол сургалтын байгууллага, аж ахуйн нэгж байгууллагатай мэдээлэл солилцох боломжийг бүрдүүлж СӨБ-ийн түвшинд -1, ЕБС-ийн түвшинд -15, Дээд боловсролын түвшинд -26, Орон зайн мэдээллийн системийн түвшинд -2, Боловсролын үнэлгээний төвд зориулж -5 сервисийг бэлтгэн холбогдох баримт бичгийн дагуу боловсруулан developer.esis.edu.mn системд байршуулж ДБУМС-ийн сургалтын байгууллага, сургалтын хөтөлбөр, хичээлийн жил, улирал, суралцагч, сургалтын агуулга, багш, улирлын дүн, хөтөлбөрийн дүн, санхүүгийн дэмжлэг, суралцагчийн санхүү, эрдэм шинжилгээ, төсөл хөтөлбөр модулийн сервисээр мэдээлэл солилцох туршилтын ажлыг МУИС, АШУУИС-тай хамтран зохион байгуулсан. Их, дээд сургууль төгссөн эсэх тухай лавлагааны сангийн</p>	100%	

					баяжуулалтыг хийж, Үндэсний дата төвд байрлах сервисээр дамжуулан Төрийн үйлчилгээний нэгдсэн систем E-Mongolia цахим системээр дамжуулан лавлагааг цахим хэлбэрээр олгож эхэлсэн. Мөн боловсролын сургалтын байгууллагад суралцаж буй тухай тодорхойлолтын сервисээр Гааль, татвар, санхүүгийн мэдээллийн системтэй холбогдож Их, дээд сургууль, коллежид суралцаж байгаа оюутан, суралцагчийн мэдээллийг солилцож, цахим хэлбэрээр тодорхойлолт олгож эхэлснээр татварыг буцаан олголтод сургалтын байгууллагаас тодорхойлолт шаардахгүй болсон.	
64	5. Шинжлэх ухаан, технологи, инновацийн салбарт мэдээллийн системийн инновацийг нэвтрүүлнэ.	2020 - 2024	2,000.0	Шинжлэх ухаан, технологи, инновацийн мэдээллийн нэгдсэн систем боловсруулж эхэлсэн байна.	<p>Шинжлэх ухаан, инновацийн салбарын мэдээллийн нэгдсэн системийн бизнес шинжилгээ, систем архитектурыг боловсруулах чиг үүрэг бүхий хувь зөвлөх сонгон шалгаруулах худалдан авах ажиллагааг зохион байгуулж шалгарсан хувь зөвлөхтэй 6 сарын хугацаатай гэрээг 05 дугаар сард байгуулсан. Тус зөвлөхүүд нь холбогдох байгууллагуудтай уулзалт зохион байгуулж, системийн бизнесийн шинжилгээг хийж, системийн бүтцийн зургийг боловсруулж, эцсийн тайланг хүлээлгэж өгсөн.</p> <p>Шинжлэх ухааны салбарын албан ёсны статистикийн мэдээг онлайн хэлбэрээр цуглуулж, нэгтгэн, цахим порталд байршуулах зорилго бүхий туршилтын системийг боловсруулахаар Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2021 оны “Зардал батлах тухай” А/289 дүгээр тушаалаар зардлыг шийдвэрлэн, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, гүйцэтгэгч “Инфокон” ХХК-тай ЦБСХ-2021/466 тоот ажил гүйцэтгэх гэрээг байгуулж, хамтран ажиллаж хөгжүүлсэн. Шинжлэх ухааны салбарын 2020 оны жилийн эцсийн албан ёсны статистик мэдээллийг Шинжлэх ухааны газартай хамтран, тус системээр хүлээн авч нэгтгэн боловсруулсан.</p> <p>АХБ-ны санхүүжилтээр хэрэгжүүлж буй нээлттэй шинжлэх ухааны цахим порталыг хөгжүүлэх MON TA-9375 төслийг Инфокон ХХК хэрэгжүүлж байна. Дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна: Судалгааны төслийн модуль, төслийн уралдаан сонгон шалгаруулалт зарлах модуль, төслийн санал илгээх модуль, ЭШ, Судалгааны грант зарлал, ЭШ, Судалгааны байгууллагуудын жагсаалт, Нийтлэл хуваалцах систем, Бүтээлийн хуулбар илрүүлэгч, Ишлэлийн бүртгэл, Бодлогын баримт бичигт санал авах модуль, ШУ хурлын систем, ШУ сургалтын эх үүсвэрийн бүртгэл. Цаг үеийн шаардлагад нийцүүлэн дараах ажлуудыг нэмэлтээр хийж гүйцэтгэсэн: цахим хурлын систем: https://meeting.opensciene.mn, онлайн судалгааны систем: https://survey.openscience.mn, статистик мэдээлэл цуглуулах онлайн систем: https://stat.openscience.mn</p>	90%
65	6. Салбарын үйлчилгээг цахимжуулан иргэд,	2020 - 2024	600.0	Тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагаа, боловсролын	<p>1. Тусгай зөвшөөрөл: Боловсролын салбарын үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг цахим хэлбэрт шилжүүлэх ажлыг гүйцэтгэж, Сургуулийн өмнөх боловсрол болон ерөнхий боловсролын сургуулийн сургалтын тусгай зөвшөөрөл</p>	90%

		байгууллагад хүртээмжтэй, түргэн шуурхай, ил тод хүргэнэ.			баримт бичгийг цахим хэлбэрт шилжүүлж, 2018 оноос өмнөх баримт бичгийн мэдээллийг санд оруулж эхэлсэн байна.	олгох, сунгах хүсэлтийг журмын дагуу иргэн, аж ахуйн нэгжээс 2021 оны 2 дугаар сарын 15-наас 3 дугаар сарын 12-ны хооронд Боловсролын мэдээллийн технологийн төвийн www.license.edu.mn системээр дамжуулан цахимаар хүлээн авсан. Мөн төрийн үйлчилгээний нэгдсэн портал e-mongolia.mn системд тусгай зөвшөөрлийн системийн тухай мэдээллийг байршуулж иргэн, аж ахуйн нэгжүүд цахим үйлчилгээ авах боломжийг нэмэгдүүлэв.	
66		7. Олон улсын жишигт нийцсэн мэдээллийн технологийн боловсрол, Аутсорсингийн төвийг байгуулж, чадавхыг бэхжүүлнэ.	2020 - 2024	35,000.0	Мэдээллийн технологийн боловсрол, аутсорсингийн төвийн барилга угсралтын ажлыг эхлүүлсэн байна.	2. Цахим үйлчилгээ: - Боловсролын салбарт суурь, бүрэн дунд боловсролын гэрчилгээ, дээд боловсролын сургалтын байгууллага төгссөн тухай дипломын лавлагаа болон ерөнхий боловсролын сургуулийн Улсын шалгалтын нэгдсэн дүнгийн хуулбар гэсэн 4 төрлийн лавлагааг ТҮЦ машин болон Төрийн үйлчилгээний нэгдсэн системт буюу E-Mongolia цахим системээр дамжуулан олгож байна. Ерөнхий боловсролын элсэлт, төгсөлт, журнал хөтлөлт, боловсролын баримт бичиг олголт, элсэлтийн ерөнхий шалгалтын материал түгээлт, засалт, түүний чанарын үнэлгээний судалгаа, багшийн эрхийн бүртгэл, салбарын шагнал урамшууллын хүсэлт, үнэмлэх тэмдгийн нөхөн олголтын хүсэлт зэрэг үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлээд байна. Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2021 оны “Журам, заавар батлах тухай” А/09 дүгээр тушаалаар Боловсролын сургалтын байгууллагад суралцаж байгаа эсэх тухай тодорхойлолтыг дээрх системээр дамжуулан цахимаар олгох журам, загвар батлагдсан бөгөөд Үндэсний дата төвтэй гэрээ байгуулан, систем хооронд мэдээлэл солилцох сервис хөгжүүлэлтийг хийж, тодорхойлолтыг сервисээр аж ахуйн нэгж байгууллагад, иргэнд ТҮЦ машин болон Төрийн үйлчилгээний нэгдсэн системт буюу E-Mongolia цахим системээр дамжуулан олгож байна.	70%

					<p>нэгдсэн төв байгуулагдана. Өнгөрсөн хугацаанд төслийн зөвлөх үйлчилгээний компани сонгон шалгаруулах худалдан авах ажиллагааг 2014 онд зохион байгуулж 2015 оны 03 дугаар сарын 10-ний өдөр WAPCOS Limited компанитай 1,468,400 ам.долларын үнийн дүнтэй зөвлөх үйлчилгээний CONS-2014-11 тоот гэрээ байгуулсан. Мөн БШУЯ-аас 2016-2020 онд төслийн барилга угсралтын ажил /Багц-1/, сургалтын зохион байгуулах, тоног төхөөрөмж нийлүүлэх ажил /Багц-2/-ын үндсэн гүйцэтгэгч сонгон шалгаруулах худалдан авах ажиллагааг зохион байгуулж 2-р багц дээр Lovely International Trust компанитай 2019 оны 08 дугаар сарын 05-ны өдөр 7,989,525 ам.долларын, 1-р багц дээр 2020 оны 03 дугаар сарын 16-ны өдөр P.K. Saxena Contractor компанитай 10,159,015 ам.долларын үнийн дүн бүхий гэрээ байгуулсан.</p> <p>Төслийн явц: Багц-1. Үндсэн гүйцэтгэгч P.K Saxena Contractor компани Шинжлэх ухаан технологийн сургуулийн Мэдээлэл холбооны технологийн сургуулийн хашаанд баригдах 10 давхар барилгын зураг төсвийг боловсруулан Нийслэлийн ерөнхий архитектор, хот байгуулалт, хөгжлийн газраар батлуулж, холбогдох журмын дагуу Нийслэлийн мэргэжлийн хяналтын газар, Онцгой байдлын ерөнхий газар, Барилга хөгжлийн төвөөр хянуулж, холбогдох зөвшөөрлийг авсан. Мөн ус суваг, дулаан, холбооны тусгай зөвшөөрлийг сунгуулж, эрчим хүчний техникийн нөхцөлийг шинээр гаргуулж барилга угсралтын ажил эхлүүлэх бэлтгэл ажлыг хангаж, суурийн нүхийг ухсан, суурийн улыг цутгасан байдалтай байна. Багц-2. Төслийн 2-р багц дээр шалгарсан Lovely International Trust компанитай байгуулсан гэрээний үнийн дүнгийн 5,677,400 ам.доллар нь сургалтын зардал бөгөөд Монгол Улсад зохион байгуулах сургалтын үнийн дүн 204,000 ам.доллар. Гэрээнд тусгагдсан сургалтын хөтөлбөрийн хувьд тендерийн баримт бичиг боловсруулж байх үеийн буюу 2016 онд боловсруулж байсан хөтөлбөр тул шинэчлэх шаардлагатай болсон. Хөтөлбөр шинэчлэх асуудлыг БШУЯ-аас гүйцэтгэгч компанид тавьсны үндсэн дээр гүйцэтгэгч компани, ШУТИС-ын МХТС-ын мэргэжлийн багш нар, Боловсролын мэдээллийн технологийн төвтэй хамтран 2020 оны 12 дугаар сард сургалтын жагсаалтыг МУ-ын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөртэй уялдуулан шинэчилж ирүүлсэн. Тус сургалтын хөтөлбөрийн жагсаалтыг төслийн удирдах хороогоор 2021 оны 03 дугаар сарын 01 өдөр хэлэлцүүлсэн бөгөөд нэмэлт тайлбар бэлтгэж 03 дугаар сарын 05-ны өдөр танилцуулж, батлуулсан.</p>	
67	8. Хиймэл оюун ухаан, их өгөгдөл, өгөгдлийн	2020 - 2024		Тэргүүлэх болон эрэлттэй мэргэжлийн	Монгол Улсын Засгийн газрын 2020 оны “Боловсролын зээлийн сангийн талаар авах арга хэмжээний тухай” 70 дугаар тогтоолоор “Монгол улсад шаардлагатай тэргүүлэх чиглэлийн мэргэжлийн	100%

		шинжлэх ухаан, мэдээллийн аюулгүй байдлын чиглэлээр хүний нөөц бэлтгэнэ.			жагсаалтад мэдээллийн технологийн мэргэжлийг нэмэгдүүлсэн байна.	<p>жагсаалт"-ыг баталсан бөгөөд түүнд Мэдээлэл, харилцаа холбооны технологийн чиглэлээр "Утасгүй холбоо", "Өгөгдлийн ухаан", "Системийн аюулгүй байдал" "Хиймэл оюун ухаан" гэсэн 4 мэргэжлээр бакалаврын болон магистрын сургалтад суралцагчдад тэтгэлэг олгохоор болсон.</p> <p>Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2020 оны "Тушаалд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" А/308 тушаалаар Дээд боловсролын сургалтын байгууллагад мөрдөх бакалаврын мэргэжлийн чиглэл /хөтөлбөр/ индексд нэмэлтээр өгөгдлийн сан, сүлжээний загварчлал ба удирдлага гэсэн чиглэл мультимедиа технологи, хиймэл оюун ухаан гэсэн хөтөлбөрүүдийг оруулсан. Мөн сайдын 2021 оны "Шинэ мэргэжил /хөтөлбөр/-ээр сургалт эрхлэх тусгай зөвшөөрөл олгох тухай" А/174 дүгээр тушаалаар Шинжлэх ухаан технологийн их сургуульд мэдээллийн технологийн чиглэлээр Мультимедиа технологи, өгөгдлийн сан, хиймэл оюун ухаан, IoT технологи, робот ба хиймэл оюун ухаан, Ухаалаг сүлжээ гэсэн мэргэжил шинээр нээж 2021-2022 хичээлийн жилд элсэлт авч, дээрх чиглэлээр нарийн мэргэжлийн мэргэжилтэн бэлтгэж эхэлсэн. Дээд боловсролын салбарын 2021-2022 хичээлийн статистик мэдээллээр ШУТИС-д хиймэл оюун ухаан, робот ба хиймэл оюун ухаан, өгөгдлийн ухаан мэргэжлээр 156, МУИС-д өгөгдлийн сангийн загварчлал, удирдлага мэргэжлээр 11, ДХИС-д мэдээллийн аюулгүй байдал мэргэжлээр 8 нийт 175 оюутан бакалавр, магистрийн зэргээр суралцаж байна.</p> <p>БНЭУ-ын хөнгөлөлттэй зээлийн хүрээнд хэрээнд олон улсын түвшинд хүрэхүйц мэргэжлийн өндөр ур чадвартай хүний нөөцийг нэмэгдүүлэх, мэдээллийн технологийн гадаад аутсорсингийг хөгжүүлэх зорилготой "Мэдээллийн технологийн боловсрол, аутсорсингийн төсөл"-ийн хүрээнд хэрэгжих сургалтын хөтөлбөрийг ЗГҮАХ-тэй уялдуулан шинэчлэн боловсруулж хиймэл оюун ухаан, машин сургалт, өгөгдлийн шинжилгээ, бизнесийн шинжилгээ, мобайл хөгжүүлэлт, програм хангамжийн менежмент зэрэг 16 мэргэжлээр сургалт явуулахаар шийдвэрлэсэн.</p>	
68		9. Цахим бичвэр, цахим хэл шинжлэлийг хөгжүүлэх ажлыг үе шаттай зохион байгуулна.	2020 - 2024	200.0	Монгол бичгийн цахим фонтыг Олон Улсын байгууллагын Unicode стандартад нийцүүлэн баталгаажуулсан байна.	<p>Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2020 оны А/110 дугаар тушаалаар "Цахим сурах бичиг, сургалтын нээлттэй материалд тавигдах шаардлага" боловсруулах ажлын хэсэг байгуулагдан ажилласан. Цаашид ерөнхий боловсролын сургуулийн сурах бичгийг цахим хэлбэрт бүрэн шилжүүлэх, цөм хөлтөлбөрийн дагуу цахим контент бэлтгэж нийтийн хүртээл болгох ажлыг үе шаттай хийхээр төлөвлөн ажиллаж байна.</p> <p>Коронавирус (Ковид-19) цар тахлын үед НҮБ-ийн хамтарсан төслийн хүрээнд боловсролын салбарын суурь үйлчилгээг дэмжих зорилгоор нийт 104 интерактив, цахим контент бэлтгэн Казак, Тува, Дохионы хэлтэй хувилбартай хийхээр ажиллаж байгаа бөгөөд одоогийн байдлаар 26 цахим контент бэлтгэн www.econtent.edu.mn хуудсанд байршуулаад</p>	70%

						байна. Засгийн газрын 2020 оны 96 дугаар тогтоолоор баталсан Монгол бичгийн үндэсний хөтөлбөр-III-д цахимд монгол бичгээр бичих стандарт кодчиллын асуудлыг ХХМТГ, СХЗГ эрхлэн хэрэгжүүлэхээр тусгагдсан. Үр дүн: Хэл шинжлэлийн цахим хөмрөг (corpus) байгуулах талаар мэргэжлийн байгууллага, хувийн хэвшлийнхэнтэй хамтран ажиллах төлөвлөлт хийгдэж, энэ чиглэлээр шаардлагатай мэдээ, мэдээлэл цуглуулах, суурь судалгааны ажлын даалгавар боловсруулах ажлуудыг эхлүүлсэн.	
69		10. Цахим агуулга, цахим хичээл боловсруулан насан туршийн боловсролыг бүх хэлбэрээр дэмжинэ.	2020 - 2024	3,685.0	9-12-р ангийн суралцагчдад ажил мэргэжлийн чиг баримжаа олгох цахим агуулгыг боловсруулсан байна.	<p>1. Азийн хөгжлийн банкны Эдийн засгийн хүндрэлийн үед боловсролын чанар хүртээмжийг сайжруулах төслийн дэмжлэгтэйгээр 1-5 дугаар сард ажиллаж ерөнхий боловсролын сургуулийн сургалтад ашиглах цахим сурах бичигт тавих шаардлага, сургалтын нээлттэй материал, сургалтын интерактив контент, ээлжит хичээлийн цахим контентод тавих шаардлагыг тус тус боловсруулан яамны удирдлагуудад танилцуулж, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2021 оны “Цахим сурах бичиг, ерөнхий боловсролын сургалтад ашиглах сургалтын нээлттэй материалд тавих шаардлага батлах тухай” А/193 дугаар тушаалаар батлуулсан.</p> <p>2. Суралцагчид болон эцэг эх, асран хамгаалагчдад зориулж өөрийн сонирхол, давуу талаа таньж мэдэх, чадвар, үнэт зүйлээ тодорхойлох, ахлах ангид судлах хичээл, хөтөлбөрөө сонгох, 12 дугаар анги төгссөний дараа суралцах их, дээд сургууль, мэргэжлийн хөтөлбөрөө сонгох, хөдөлмөрийн зах зээлд ажил хөдөлмөр эрхлэхтэй холбоотой ухаалаг, бодитой шийдвэр гаргахад дэмжлэг үзүүлэх зорилгоор ажил мэргэжлийн чиг баримжаа олгох портал сайтыг ажиллуулж байна. “Мэргэжил сонголт ба ирээдүй” сэдэвт цахим зөвлөгөө, мэдээллийн нэг сарын аяныг 2021 оны 3 дугаар сарын 30-наас 5 дугаар сарын 27-ны хооронд ерөнхий боловсролын сургуулийн суралцагч, төгсөгчдөд мэргэжлийн чиг баримжаа олгох, мэргэжлээ сонгоход нь дэмжлэг үзүүлэх, зөвлөгөө өгөх зорилгоор амжилттай зохион байгууллаа. Уг аяныг зохион байгуулах /4 долоо хоног/ хугацаанд сургуульд суурилсан ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйл ажиллагааны оролцогч талууд болох сургуулийн удирдлага, 8-12 дугаар анги даасан багш нар, суралцагчид болон тэдний эцэг эх, асран хамгаалагчдад КОВИД-19 цар тахлын нөхцөл байдалд хэрхэн зохицож ажиллах, мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх, шийдвэр гаргах чиглэлээр цахим-лайв мэдээлэл, зөвлөгөө өгөх, сонирхсон асуултад хариулах ажлыг сэдэв тус бүрээр 2 удаа зохион байгуулсан. Нийт 8 удаагийн цахим-лайв хөтөлбөрийг давхардсан тоогоор 641 хүн 57,500 удаа үзэж 1,432 удаа хуваалцсан байна. БҮТ-д 8-12 дугаар суралцагчдад анги мэргэжлийн чиг баримжаа олгох myfuture.mn вэбсайтыг боловсруулж, эцэг эх багш нар ашиглаж байна.</p>	70%

70		11. Багш бүрийг компьютержуулж, "Ухаалаг сургууль", "Ухаалаг анги" төсөл хэрэгжүүлнэ.	2020 - 2024	59,400.0	Багш бүрт компьютер, сургууль бүрийг цахимжуулж, цахим ангийг бий болгох ажлыг эхлүүлсэн байна.	УИХ-н Инноваци, цахим бодлогын байнгын хорооны 2020 оны "Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай" 01 дүгээр тогтоолоор Бүх шатны боловсролын байгууллагад цахим сургалтын эрх зүйн орчин бүрдүүлэх, боловсролын салбарын цахим шилжилтийг эрчимжүүлэх чиглэл өгөгдсөн бөгөөд тус тогтоолын хэрэгжилтийг 2021 оны 3 дугаар сарын 31-нд Монгол Улсын Засгийн газарт, УИХ-ын БСШУС-ын Байнгын хороонд 2021.05.25-нд, УИХ-ын ИЦБ-ын Байнгын хороонд 2021.06.15-ны өдөр тус тус танилцуулсан. Монгол Улсын Засгийн газрын 2021.03.31 өдрийн хуралдааны тэмдэглэлд сургалтын байгууллагын мэдээлэл, харилцаа холбооны гадаад, дотоод сүлжээний дэд бүтэц, цахим сургууль, ухаалаг анги, танхим байгуулахад болон багш, суралцагчийн зөөврийн компьютер төхөөрөмжөөр хангахад шаардлагатай хөрөнгө оруулалтыг улсын төсөв, төр, хувийн хэвшлийн түншлэл, гадаад улсын болон олон улсын байгууллагын буцалтгүй тусламж, хөнгөлөлттэй зээл, төсөл хөтөлбөрийн хүрээнд судлан шийдвэрлэх арга хэмжээ авч ажиллахыг БШУ-ны сайд, Сангийн сайд нарт даалгасан. Боловсролын салбарын үйл ажиллагаанд цахим шилжилтийг эрчимжүүлэх, үйлчилгээний чанар, хүртээмжийг мэдээллийн технологийн тусламжтайгаар нэмэгдүүлэх ажлын хүрээнд Монгол Улсын төрийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн цахим орчныг бүрдүүлэх, тоног төхөөрөмжөөр хангах, багшийн үндсэн үйл ажиллагааг дэмжих, ажлын байрандаа суралцах, зайн сургалтын өгөөжийг нэмэгдүүлэх зорилгоор дараах ажлууд хийгдсэн. Үүнд: - Ерөнхий боловсролын сургуулийн интернэтийн гадаад, дотоод сүлжээний орчин бүрдүүлэх 10 сая долларын өртөг бүхий төслийг боловсруулан Засгийн газрын хуралдаанд танилцуулж, БНХАУ-н буцалтгүй тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлэх асуудал дэмжигдсэн. - "Боловсролын цахим шилжилтийг дэмжих" 100 сая ам долларын төсөвт өртөг бүхий Онлайн шалгалтын танхим, Хичээлийн цахим контентын студи, Боловсролын дата төвийн тоног төхөөрөмж, Багш нарын зөөврийн компьютер, Цэцэрлэгийн интернэтийн сүлжээ гэсэн 5 дэд хэсгээс бүрдсэн төслийг 2021 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр Боловсрол, шинжлэх ухааны сайд донор байгууллагуудтай зохион байгуулсан уулзалтын үеэр танилцуулсан.	90%
71	2.3.13. Боловсролын хүрээлэнгийн бүтэц, зохион байгуулалтыг өөрчилж, чадавхыг дээшлүүлнэ.	1. Боловсролын судалгаа, шинжилгээ, сургалт, үнэлгээний байгууллагын чиг үүргийг оновчтой болгож, Багшийн хөгжлийн институт,	2020 - 2024		Боловсрол, шинжлэх ухааны судалгаа, шинжилгээ, сургалт, үнэлгээ, насан туршийн боловсролын байгууллагын чиг үүрэг, бүтцийг	- Боловсролын ерөнхий хуулийн төсөл, түүнийг дагалдан гарах хуулийн төслүүдийг Монгол Улсын Засгийн газраас 2021 оны 06 сарын 24-ны өдөр Улсын Их Хуралд өргөн барьсан. 2021 оны 06 дугаар сарын 29-нд Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороо, Улсын Их Хурлын нэгдсэн чуулганаар дэмжигдэн 2021 оны намрын чуулганаар хэлэлцэж эхэлсэн. Боловсролын ерөнхий хуулийн төслийн 19 дүгээр зүйлд Боловсролын эрдэм шинжилгээ, арга зүйн байгууллагын хэрэгжүүлэх суурь болон хавсарга судалгаа, шинжилгээ, арга зүй, сургалтын ажлын чиглэлийг тодорхой зааж өгсөн. - Монгол Улсын Засгийн газрын 2021 оны "Тогтоолын хавсралтад	90%

		Боловсролын судалгааны хүрээлэн, Боловсролын чанарын үнэлгээний төв, Насанд туршийн боловсролын хөгжлийн төвийг шинэчлэн зохион байгуулна.			шинэчлэн тогтоосон байна.	өөрчлөлт оруулах тухай” 407 дугаар тогтоолоор батлагдаж, Боловсролын хүрээлэнг “Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн” болгон өөрчлөн зохион байгуулахаар болсон. - Боловсролын ерөнхий газар байгуулах тухай асуудал “ЗГ-ын агентлаг байгуулах тухай” 12 дугаар сарын 31-ний өдрийн 403 дугаар тогтоолоор батлагдсан. Тогтоол батлагдсанаар Боловсрол, шинжлэх ухааны сайдын эрхлэх асуудлын хүрээнд Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг “Боловсролын ерөнхий газар” байгуулагдах юм. Уг тогтоолын төслийн 5 дахь заалтад Боловсрол, шинжлэх ухааны яамны харьяа Боловсролын хүрээлэн, Боловсролын үнэлгээний төвийн зарим чиг үүрэг Боловсролын ерөнхий газарт шилжиж байгаатай холбогдуулан эдгээр байгууллагын бүтэц, дүрмийг шинэчлэхтэй холбоотой асуудал тусгагдсан.	
72	2.3.14. Төрийн өмчийн их, дээд сургуулиудын судалгааны болон бусад зардалд төрөөс зарим дэмжлэг үзүүлнэ.	1. Төрийн өмчийн их, дээд сургуулиудын судалгааны болон бусад зардалд төрөөс зарим дэмжлэг үзүүлнэ.	2020 - 2024	15,000.0	Төсөв санхүүгийн үйл ажиллагаанд шинжилгээ хийсэн байна.	УИХ-д өргөн мэдүүлээд байгаа Судалгааны их сургуулийн эрх зүйн байдлын тухай хуулийн төсөлд “Судалгааны их сургуулийн санхүүжилт” гэсэн 4 дүгээр бүлгийг Судалгааны их сургуулийн санхүүжилтийн эх үүсвэр, Судалгааны их сургуулийн санхүүгийн дэмжлэг, Хөрөнгийн удирдлага гэсэн 3 зүйлтэй байхаар боловсруулаад байна. Төр, орон нутгийн захиргааны санхүүгийн дэмжлэг болон Хөрөнгийн удирдлага гэсэн зүйл нь энэхүү хуулийн төслийн шинэлэг тал болсон. Ийнхүү төрөөс сургалт, судалгааны чанарыг сайжруулах зорилгоор төрийн өмчит сургуульд жил бүр тодорхой хувийн санхүүгийн дэмжлэг үзүүлэх, мөн Орон нутгийн захиргаа нь дунд, урт хугацааны сургалт, судалгааны хөгжил болон оюутны сургалтын тэтгэлэгт санхүүгийн дэмжлэг үзүүлэх асуудлыг шинээр тусгаснаас гадна тэдгээр санхүүжилтийг өмнөх жилийн төсөв, санхүүжилтийн үр дүнг харгалзан олгохоор тусгасан. Боловсрол, шинжлэх ухааны яамнаас шинжлэх ухаан, технологи, инновацын хүний нөөцийг үе шаттай бэлтгэх, сургалт, судалгааны ажлыг дэмжих зорилгоор “Эрдэнэс-Тавантолгой” хувьцаат компанитай хамтран ажиллах санамж бичиг байгуулан энэ онд байгалийн ухаан, инженер технологийн чиглэлээр суралцаж буй 8 докторантад 6.0 сая, 5 магистрантад 4.0 сая төгрөгийн тэтгэлэг олгохоор нийт 68.0 сая төгрөгийн санхүүжилт бүхий судалгааны төслийн сонгон шалгаруулалтыг зарлан зохион байгуулсан. Мөн их сургуулийн төгсөх ангийн судлаач оюутнуудын дунд 5.0 сая төгрөгийн шагналын сан бүхий төслийн уралдаан зарлан хэрэгжүүлсэн. Төрийн өмчийн их, дээд сургуулиудын судалгааны болон бусад зардалд төрөөс үзүүлж буй төсөв санхүүгийн үйл ажиллагаанд шинжилгээ хийсэн. Судалгаанд нийт 21 төрийн өмчийн их, дээд сургуулиуд хамрагдсан бөгөөд судалгааны үр дүнгээр их, дээд сургуулиудын судалгаанд улсын төсвөөс 1,2 тэрбум төгрөгийн санхүүгийн дэмжлэг авч, олон улсын төсөл, хөтөлбөрийн шугамаар 8.8 тэрбум төгрөгийн өртөг бүхий сургалт, лабораторийн тоног төхөөрөмжийг хүлээлгэн өгч, ахисан түвшний болон зэргийн бус хөтөлбөрт 130 багш, судлаачдыг хамруулсан байна.	100%
73	2.3.15. Орон нутаг	1. Орон нутаг дахь	2020 -		Бүсчилсэн	Орон нутагт ажиллаж байгаа их, дээд сургуулийн багш нарт дэмжлэг	90%

	дахь мэргэжил, сургалт, үйлдвэрлэлийн төв, политехник коллеж, их, дээд сургуулиудыг дэмжиж, багш нарт орон нутгийн нэмэгдэл олгож, оюутныг төлбөрийн хөнгөлөлттэй нөхцөлөөр суралцуулна.	их, дээд сургуулиудыг дэмжиж, багш нарт орон нутгийн нэмэгдэл олгож, оюутныг сургалтын төлбөрийн хөнгөлөлттэй нөхцөлөөр суралцуулна.	2024		хөгжлийн үзэл баримтлал, эрэлттэй мэргэжилд нийцүүлэн багш, суралцагчдад дэмжлэг үзүүлэх зохицуулалтыг хийсэн байна.	<p>үзүүлэх тухай зохицуулалтыг УИХ-д өргөн мэдүүлсэн Дээд боловсролын тухай төслийн 18.1.4 “Орон нутагт ажиллах дээд боловсролын сургалтын байгууллагын багш нарт орон сууцны дэмжлэг үзүүлэх” гэж тусгаад байна.</p> <p>Засгийн газрын “Их, дээд сургуулийг” сургалт-эрдэм шинжилгээ-үйлдвэрлэлийн цогцолбор” болгон орон нутагт хөгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” 2021 оны 321 дугаар тогтоолын 3 дугаар заалтад орон нутаг дахь төрийн өмчит их, дээд сургуульд ажиллаж байгаа багш, ажилтны нийгмийн баталгааг хангах, дэмжлэг үзүүлэх зорилгоор орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан бол зохих тэтгэмж олгох, хөнгөлөлттэй зээлд хамруулдаг байх зохицуулалт бий болгох асуудлыг судлан, эрх зүйн орчныг бүрдүүлэх, шаардагдах санхүүжилтийг жил бүрийн улс, орон нутгийн төсвийн төсөлд тусгах арга хэмжээ авахыг Сангийн сайд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Боловсрол, шинжлэх ухааны сайд, аймгийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосон.</p> <p>Боловсролын зээлийн сангаас Дорноговь аймаг, Дархан-Уул аймаг, Говь-Алтай аймаг дахь дээд боловсролын сургалтын байгууллагад сувилагч мэргэжлээр суралцаж байгаа 691 оюутанд 608 сая төгрөг, Дорнод аймаг, Архангай аймаг, Ховд аймаг, Баян-Өлгий аймаг дахь дээд боловсролын сургалтын байгууллагад багш мэргэжлээр суралцаж байгаа 81 оюутанд 60,5 сая төгрөгийн тэтгэлэг олгосон.</p>	
74	2.3.16. Олон улсад өрсөлдөх чадвартай боловсролын хөтөлбөрийг бий болгох эрх зүйн шинэтгэл хийж, үе шаттайгаар хэрэгжүүлнэ.	1. Олон улсын хөтөлбөрийн сургалттай ерөнхий боловсролын сургуулийн тоог үе шаттайгаар нэмэгдүүлнэ.	2020 - 2024	10,935.8	<p>Ерөнхий боловсролын 5 сургуулийн сургалтын хөтөлбөрийг олон улсын хөтөлбөрт шилжүүлсэн байна.</p> <p>- 2019-2020 оны хичээлийн жилд олон улсын хөтөлбөрөөр олон улсын /Кембрижийн/ ерөнхий боловсролын хөтөлбөрөөр хичээллэж байгаа 12 сургууль байсан. 2020-2021 оны жилийн эцсийн байдлаар Кембрижийн ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрөөр хичээллэдэг төрийн болон хувийн өмчийн 22 сургууль үйл ажиллагаа эрхэлж байна.</p> <p>- Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2021 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн А/189 дүгээр тушаалаар баталсан олон улсад өрсөлдөх чадвартай боловсролын хөтөлбөрийг бий болгох арга хэмжээг нэгдсэн удирдлагаар хангах ажлын хэсэг байгуулагдсан. Ажлын хэсэг олон улсын хөтөлбөртэй сургуулийн тоог нэмэгдүүлэх, багш бэлтгэх, олон улсын хөтөлбөрөөр хичээллэх сургуулийн бэлтгэл хангах чиглэлээр ажлын зураглал гаргаж хэлэлцүүлээд байна.</p> <p>- Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн сургалтын тогтолцоог Монгол Улсад нэвтрүүлэх асуудлаар Кембрижийн олон улсын төвтэй хамтран ажиллах (зөвлөх үйлчилгээ) гэрээний төслийг боловсруулж, талууд хэлэлцэж байна. Гэрээний төслийг хянуулахаар Гадаад хэргийн яаманд хүргүүлсэн.</p> <p>- УИХ-ын Тамгын газар, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооноос “Олон улсын стандартын хөтөлбөрийг Монгол Улсад нэвтрүүлэх нь: туршлага, сургамж” хэлэлцүүлгийг 2021 оны 10 дугаар сарын 20-ны өдөр Төрийн ордонд зохион байгууллаа. Хэлэлцүүлэгт Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан “Ерөнхий боловсролын сургуульд олон улсад өрсөлдөх чадвартай хөтөлбөр хэрэгжүүлэх нь” сэдвээр илтгэл хэлэлцүүлсэн.</p>	70%	

75	2.4.1.. Шинжлэх ухаан, технологи, инновацын салбарын судалгаа, шинжилгээний чиглэлийг оновчтой болгон, судлаачийн чадавхыг дээшлүүлж, эрдэм шинжилгээ, судалгаанд зарцуулах төсвийн зардлыг 4 дахин нэмэгдүүлнэ.	1. Салбарын төсвийн бодлого, төлөвлөлтийн тогтолцоог боловсронгуй болгож, үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоог бүрдүүлэх замаар салбарын өрсөлдөх чадвар, бүтээмжийг дээшлүүлнэ.	2020 - 2024	108,984.9	Эрдэм шинжилгээ, судалгаанд зарцуулах төсвийн зардлын ДНБ-д эзлэх хувийг 0.36 хувьд хүргэсэн байна.	БШУ-ны сайдын 2021 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн “Хөтөлбөр, арга хэмжээнээс санхүүжих үйл ажиллагааны төлөвлөгөө батлах тухай” А/80 дугаар тушаалаар 7,0 тэрбум төгрөг, 2021 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн А/111 дүгээр тушаалаар Шинжлэх ухаан, технологийн сангийн төсөл, арга хэмжээний 2021 оны төсвийн зардалд 5,0 тэрбум төгрөг батлуулсан. Санхүүжилтийн хүрээнд 2021 оны байдлаар суурь судалгааны үргэлжлэн хэрэгжиж буй 115 төслийн 1 тэрбум 870 сая төгрөг, шинээр хэрэгжиж буй 64 төслийн 811 сая, суурь хавсарга судалгааны 18 грант төсөлд 113 сая төгрөг, гадаадтай хамтарсан 32 төслийн 285.1 сая төгрөг, үргэлжлэн хэрэгжиж буй улсын захиалгат 54 төслийн 1 тэрбум 314 сая төгрөг, шинээр хэрэгжиж буй 28 төслийн 687 сая төгрөг, инновацийн 16 төслийн 331.2 сая төгрөг, технологийн туршилт зүгшрүүлэлтийн 14 төслийн 231.6 сая төгрөг, докторын дараах инновацийн 20 төслийн 145 сая төгрөгийн санхүүжилтийг тус тус олгох шийдвэрийг гаргаж, шинжлэх ухаан, технологийн төслийг санхүүжүүллээ. Үүний зэрэгцээ Шинжлэх ухаан, инновацийн нэгдсэн цогцолборын барилгын ажлыг 2020 оны 10 дугаар сард эхлүүлж, 2021 онд улсын төсдийн 4 тэрбум төгрөгийн санхүүжилтээр барилгын ажлыг үргэлжлүүлэн тасралтгүй явуулж байна. 2022 онд тус цогцолборын барилгын нийт төсөв 94 тэрбум төгрөгийг үндэслэл, тооцоо судалгааг хийж, 50 гаруй тэрбумар нэмэгдүүлж батлуулсан. Уг төсвийн хүрээнд барилгын ажлыг 2023 онд барьж дуусгахаар төлөвлөсөн. НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрөөс /UNDP/ хэрэгжүүлж буй “Rolling out an integrated approach to SDG financing in Mongolia” хамтарсан хөтөлбөрийн хүрээнд Public finance expert to conduct science sector expenditure review шинжлэх ухааны салбарт төсвийн шинжилгээ хийх зөвлөх үйлчилгээний ажлын 6-р сараас эхлүүлж, Боловсрол, шинжлэх ухааны яам Эрдэнэс таван толгой ХК-тай хамтран ажиллах санамж бичгийн дагуу шинжлэх ухаан, технологийн зардлын үндэсний хэмжээний судалгааг гүйцэтгэж Шинжлэх ухааны салбарын төсвийн санхүүжилтэд дүн шинжилгээ хийн, санал зөвлөмж боловсруулсан. 2021 оны төсөвт Инноваци, технологийг хөгжүүлэхэд чиглэсэн 30 арга хэмжээг хэрэгжүүлэхэд 2,0 тэрбум батлагдсан нь өмнөх жилүүдийг бодвол 2 дахин нэмэгдсэн хэдий ч Төрөөс инновацийн талаар баримтлах бодлого, үндэсний хөтөлбөрийн зорилтот түвшин болох 2025 он гэхэд инноваци, технологийн үйл ажиллагааны санхүүжилтийг ДНБ-ний 1,0 хувьд, 2030 он гэхэд 1,5 хувьд хүргэх зорилгоос даруй 5 дахин бага байна.	90%
76		2. Шинжлэх ухаан, технологи, инновацын хамтын ажиллагааг эдийн засгийн	2020 - 2024		Хувийн хэвшлийн шинжлэх ухаан, технологи, инновацийн тэргүүлэх	Гарааны компанийн олон нийтэд хувьцаа санал болгох эрх зүйн орчныг судлах хүрээнд 4 багц агуулга бүхий дата мэдээлэл цуглуулах судалгааны ажлыг БШУ-ны сайдын 2021 оны А/293 дугаар тушаалын хүрээнд гэрээгээр мэргэжлийн эрдэмтэн судлаачдын багаар гүйцэтгүүлж, судалгааны тайланг хүлээн авсан.	100%

		хөшүүргээр дэмжсэн эрх зүйн шинэчлэл, зохицуулалтыг хийж, татвар, хөрөнгө оруулалт, зээлийн бодлогоор дэмжинэ.			чиглэлийн судалгаа хөгжүүлэлтийг дэмжсэн эрх зүйн баримт бичгийг боловсруулсан байна.	<p>Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2021 оны 3 сарын 26-ны өдрийн А/119 дугаар тушаалаар "Технологи дамжуулах төв, эсхүл хамтын оффисд гишүүнчлэлээр бүртгүүлсэн гарааны компани болон программ хангамжийн үйлдвэрлэл, хөгжүүлэлтийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжид татварын дэмжлэг үзүүлэх журам"-ын төслийг боловсруулах ажлын хэсгийг Татварын ерөнхий газар, Гаалийн ерөнхий газар, Улсын бүртгэлийн ерөнхий газар, Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар, хувийн хэвшлийн болон мэргэжлийн холбоодын төлөөлөл бүхий бүрэлдэхүүнтэйгээр байгуулсан. Ажлын хэсгийн боловсруулсан журмын төсөлд холбогдох яамдад хүргүүлж, тэдний санал авч нэгтгэн, эцэслэн найруулж, Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэхэд бэлэн болгосон. "Шинжлэх ухаан, технологийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл"-ийг хэлэлцсэний дараа хэлэлцүүлэхээр хойшлогдсон.</p> <p>Инновацийн тухай хуулийн 121 дүгээр зүйлийн 121.2-т "Гарааны компани хувьцаагаа биржийн бус зах зээлд олон нийтэд санал болгох журмыг Санхүүгийн зохицуулах хороо /СЗХ/ батална" гэж заасантай холбогдуулан СЗХ-ны 2021 оны 348 дугаар тогтоолоор "Биржийн бус зах зээлийн үйл ажиллагааны журам"-ын 1.5, 1.6, 2.4.6, 2.5.10, 3.4, 3.5, 3.6, 3.7, 4.2, 4.5, 4.5.1, 4.5.2 гэсэн заалтуудыг шинээр тусган гарааны компани биржийн бус зах зээлд олон нийтэд хувьцаагаа санал болгох зохицуулалтын нэмэлт, өөрчлөлтийг баталсан. Ингэснээр гарааны компаниуд биржийн бус зах зээлээр дамжуулан төсөл хөтөлбөрөө хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгө оруулалтаа үе шаттайгаар мэргэжлийн хөрөнгө оруулагчид, өндөр орлоготой эрсдэл даах чадвартай иргэдээс татан төвлөрүүлэх эрх зүйн зохицуулалтын орчныг анх удаа амжилттай бүрдүүлсэн.</p>	
77		3. Шинэ мэдлэг, патентыг үйлдвэрлэлд нэвтрүүлэн эдийн засгийн эргэлтэд оруулах, бүтээгдэхүүн, үйлчилгээ болгон хэрэглээнд нэвтрүүлж, эдийн засгийн эргэлтэд оруулахад хөнгөлөлттэй зээл, грант олгоно.	2020 - 2024	12,700.0	Инновацийн тэргүүлэх чиглэлээр 5-8 инновацийн төсөл хэрэгжүүлсэн байна. 5-аас доошгүй инновацийн грант олгосон байна.	<p>Шинэ мэдлэг, патентыг үйлдвэрлэлд нэвтрүүлэн эдийн засгийн эргэлтэд оруулах зорилгоор БШУ-ны яамнаас жил бүр Инновацийн төсөлд грант олгох, технологийн туршилт зүгшрүүлэлтийн төслүүдийг сонгон шалгаруулж хэрэгжүүлдэг.</p> <p>2021 оны байдлаар судалгаа хөгжүүлэлтийн ажлын үр дүнд нийт 13325 байна. Үүнээс шинэ технологи/64/, шинэ биет бүтээгдэхүүн, бүтээгдэхүүний загвар /84/, зураг, каталог /191/, аргачлал заавар зөвлөмж /741/, жор үнэлгээ /46/, стандарт /193/, нийт хэвлүүлсэн бүтээл 11033, шинэ бүтээлийн патент /46/, ашигтай загварын гэрчилгээ /84/, зохиогчийн эрх, барааны тэмдэгт, газарзүйн заалт бүхий оюуны өмчийн гэрчилгээ /301/-г баталгаажуулсан байна. ШУА-ийн Биологийн хүрээлэн, ХӨСҮТ, МУИС-ийн эрдэмтдийн багийн хамтарсан Sars-Cov2 вирусын халдварын эсрэг бие үүсч, дархлаа тогтсон эсэхийг богино хугацаанд илрүүлэх оношлуурын цомгийг</p>	100%

						турших, үйлвэрлэлд нэвтрүүлэх ажлыг төрөөс 180 сая төгрөгийн санхүүжилтээр дэмжин ажилласан. АШУУИС-ийн эрдэмтдийн багийн бүтээсэн шүлсэнд SARS-CoV-2 илрүүлэх шинжилгээний ПГУ оношлуурыг бүтээж, 2 сарын 21-23-ны хугацаанд нийт 83, 4 дүгээр сарын 08-нд 65 хүний сорьцод туршиж нилээд өндөр үзүүлэлттэй гарсан төдийгүй үйлдвэрлэл, хэрэглээнд нэвтрүүлээд байна. Уг оношлуур нь 1 хүнд 3-5 минутын хугацаанд шинжилгээ авах, хариу 2-3 цагийн дотор гарах, сараас дээш хугацаанд сорьцыг тээвэрлэх, хямд өртөг зардлаар бүтээх зэрэг олон давуу талтай юм. 2021 оны 04 дүгээр сарын 12-ны А/145 дугаар тушаалаар технологийн туршилт зүгшрүүлэлтийн 15 төсөлд 247.8 сая төрөг, инновацийн 16 төсөлд 341.2 сая төгрөгийн санхүүжилтийн дэмжлэг үзүүлээ.	
78	4. Дотоод, гадаадын эрдэм шинжилгээний байгууллага, эрдэмтэн, судлаачдын хамтарсан төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх, судалгааны үр дүнг үйлдвэрлэл, үйлчилгээнд нэвтрүүлэх, дэвшилтэт технологийг нутагшуулахад чиглэсэн санаачилга, хөрөнгө оруулалт, бүтээлч үйл ажиллагааг дэмжих нөхцөлийг бүрдүүлнэ.	2020 - 2024	6,500.0	Төр-хувийн хэвшлийн түншлэлээр тусгай зориулалтын сан (Эндаумен сан, Венч сан)-г байгуулах боломжийг судалж, ажлыг үе шаттай эхлүүлсэн байна.	Инновацийн тэргүүлэх салбар чиглэлийн хүрээнд БШУ-ны сайдын А/269 дугаар тушаал ДТҮЭХ-ийн барилгын дулаан алдагдлыг бууруулах технологийн шийдэл бүхий "Хавсарга судалгааны төсөл"-д 199.3 сая төгрөг, ковидын нөхцөл байдлыг даван туулахад монгол эрдэмтдийн санаачилсан, хамтран нутагшуулсан технологийн туршилт зүгшрүүлэлтийн болон шинжлэх ухаан, технологийн судалгаа хөгжүүлэлтийн үр дүнг үйлдвэрлэлд нэвтрүүлэх зорилгоор БШУ-ны сайдын А/334 дүгээр тушаалаар "Эмнэлзүйн туршилт судалгаа"-д 154 сая төгрөгийн судалгааны дэмжлэг тус тус үзүүлсэн. Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийг үндэслэн Эрүүл мэндийн яамны захиалгаар Боловсрол, шинжлэх ухааны яамнаас Р.Оюунгэрэл удирдагчтай "Монгол Улсад бүртгэгдсэн шинэ коронавируст халдвар (COVID-19)-ын эмнэлзүйн судалгаа", Ч.Баттогтох удирдагчтай "Монгол Улсад SARS-CoV-2 шинэ вируст халдварын геномын судалгаа", П.Нямдаваа удирдагчтай "Монгол Улсад SARS-CoV-2 омгуудын геномын бүтцийг тодорхойлж, молекул эпидемиологийн онцлогийг тогтоон, манай орны нөхцөлд тохирсон тандалт, сэргийлэх аргачлал, зөвлөмж гаргах" судалгаа, Ц.Оюунсүрэн удирдагчтай "Хүний биед SARS-CoV-2 вирусын халдварыг эсрэг бие үүсгэж дархлаа тогтсон эсэхийг богино хугацаанд илрүүлэх оношлуурын цомгийг турших, үйлдвэрлэлд нэвтрүүлэх бэлтгэл ажил хангах" судалгаа, Г.Батбаатар удирдагчтай "SARS-CoV-2-ыг шүлсэнд илрүүлэх шинэ ПГУ оношлуур бүтээх, хэрэглээнд нэвтрүүлэх" эрдэм шинжилгээ, судалгааны 5 төсөлт ажилд нийт 821,521.0мян.төгрөгийн санхүүжилтийн дэмжлэг үзүүлсэн. Эдгээр судалгааны үр дүн үйлдвэрлэлд амжилттай нэвтэрсэн	100%	
79	5. Үндэсний инновацийн тогтолцоог	2020 - 2024	2,000.0	Үндэсний инновацийн тогтолцоог	Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль шинэчлэн батлагдсантай холбоотойгоор Засгийн газрын 2021 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн 314 дүгээр тогтоолын хавсралтын 47-д	100%	

		хөгжүүлэх хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж, инновацийн тэргүүлэх чиглэлийн бүтээгдэхүүн үйлчилгээ, технологи, судалгаа хөгжүүлэлтийн чанар, хүртээмжийг дээшлүүлнэ.			хөгжүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг батлуулж, бодлого, үйл ажиллагааны хэрэгжилтийг хангасан байна.	заасны дагуу "Үндэсний инновацийн тогтолцоог хөгжүүлэх хөтөлбөр"-ийг баталж, 2020 оны 33 дугаар тогтоолыг хүчингүй болгосон. Инновацийн тэргүүлэх чиглэлийн судалгаа хөгжүүлэлтийн хувьд 2021 оны байдлаар: "Ухаалаг засаг төсөл"-ийн хүрээнд инновацийн дэд төслийг зарлах, сонгон шалгаруулах, бойжуулах, инновацийн грант олгох, хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, үр дүнг тооцох арга хэмжээг зохицуулахад мөрдөх "Инновацийг дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлэх заавар"-ыг Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2021 оны 3 дугаар сарын 10-ны өдрийн А/76 дугаар тушаалаар баталж, инновацийн 16 дэд төсөлд 1.2 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосон. Үүний зэрэгцээ судалгаа хөгжүүлэлтийн чанар хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор инновацийн 16 төслийн 331.2 сая төгрөг, технологийн туршилт зүгшрүүлэлтийн 14 төслийн 231.6 сая төгрөг, докторын дараах инновацийн 20 төслийн 145 сая төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлэж, хэрэгжилтийг хангасан.	
80	2020 - 2024	6. Шинжлэх ухаан, технологи, инновацийн хүний нөөцийг үе шаттай бэлтгэх, чадавхжуулах нэгдсэн бодлогыг хэрэгжүүлж, эрдэм, шинжилгээний ажилтны тоог нэмэгдүүлнэ.	7,500.0	Шинжлэх ухаан, технологийн салбарын удирдлагын нэгдсэн системийн хүний нөөцийн мэдээллийн нэгдсэн модуль бүрэн ашиглалтад оруулж, мэдээллийн санг боловсронгуй болгосон байна.	Шинжлэх ухаан, технологи, инновацийн хүний нөөцийг хөгжүүлэх үндэсний хөтөлбөрийн томоохон ач холбогдол бүхий заалтуудын нэг болох ахлах ангийн сурагчдад ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох арга хэмжээг тогтмол зохион байгуулах замаар залгамж халаа бэлтгэх санал, санаачилгыг дэмжих ажлын хүрээнд Хэл, зохиолын хүрээлэнтэй хамтран мэргэжлээ сонгох боломжийг нэмэгдүүлэхэд туслах үүрэг бүхий мэргэжлийн байгууллагын хувьд тодорхой дунд сургуулийн төгсөх ангийн сурагч нарт сурталчлан таниулах, эх хэлээ ойлгох, мэдэх, хүндэтгэх явдлыг хөхиүлэн дэмжих зорилготой 20 сая төгрөгийн өртөг бүхий зорилтот төслийг нийслэлийн 3 дүүргийн 3 сургууль дээр эхлүүллээ. 2021 оны 3, 4 дүгээр сард Засгийн газрын хэрэг эрхлэх газар, Канадын Мерит төсөлтэй хамтран цахимаар зохион байгуулсан Төрийн албаны шинэтгэлтэй холбоотой 4 модуль сургалтад шинжлэх ухааны салбарын харьяа байгууллагуудыг хамруулсан. -Шинжлэх ухаан, залуу ажилтныг орчин үеийн судалгааны арга зүй эзэмшүүлэх, чадавхжуулах зорилгоор "Эрдэм шинжилгээний сэтгүүлд өгүүллээ хэвлүүлэх арга зүй" сургалтыг ШУТИС-тай хамтран цахимаар зохион байгуулж 200 гаруй залуу судлаач хамрагдсан. - Засгийн газрын 2021 оны 10-р сарын 13-ны өдрийн "Тогтоол хүчингүй болсонд тооцох тухай" 314 дүгээр тогтоолын хавсралтын 55 дахь заалтаар уг үндэсний хөтөлбөрийг хүчингүй болгосон. Холбогдох хуулиудад нийцүүлэн шинэ хөтөлбөр боловсруулах судалгааны ажил хийгдэж байна. Цаашид шинжлэх ухаан, технологийн салбарын удирдлагын нэгдсэн системийн ажлын даалгаврыг боловсруулахаар төлөвлөн, системийг хөгжүүлэх бэлтгэл ажлыг хангаж байна. Эхний ээлжинд ашиглалтад оруулахаар зорьсон хүний нөөцтэй холботой үзүүлэлтүүдтэй холбоотой индикаторуудыг гүйцэтгэгч байгууллагатай тохирч, туршилт хийхээр ажиллаж байна.	90%	

81		1. Шинжлэх ухааны паркийн эрх зүйн орчныг бүрдүүлж, парк байгуулах ажлыг үе шаттай зохион байгуулна.	2020 - 2024	42,450.0	Шинжлэх ухааны паркийн эрх зүйн байдлын тухай хууль, холбогдох дүрэм, журмыг батлуулж, Шинжлэх ухааны паркийн ТЭЗУС-г бүрэн хийж, парк байгуулах бэлтгэл ажлыг хангасан байна.	Хууль тогтоомжийн тухай хуулийн 8.1.1-8.1.4 дэх заалт, 16.3 дахь хэсгийг үндэслэн шинжлэх ухааны паркийн өнөөгийн нөхцөл байдлын судалгааг хийсэн. Хуулийн төслийн үзэл баримтлалыг Алсын хараа-2050, ЗГҮАХ 2020-2024-ийн зорилтод үндэслэн шинэчлэн боловсруулсан. Үр дүн: - Хуулийн төслийн нөхцөл байдлын болон холбогдох судалгааны тайлан; - Шинжлэх ухааны паркийн эрхзүйн байдлын тухай хуулийн төслийн үзэл баримтлал болон хуулийн төсөл боловсруулсан. - Шинжлэх ухааны паркийн техник эдийн засгийн үндэслэлийн тооцоо судалгааг ШУПЗ-тай хамтран хийж гүйцэтгэсэн.	90%
82	2.4.2. Шинжлэх ухаан, технологи, инновацийн чиглэлээр шинжлэх ухааны парк, хүрээлэнгийн цогцолбор, уламжлалт анагаах ухаан, технологийн хүрээлэнгийн барилгын ажлыг эхлүүлж, олон улсын стандартад нийцүүлнэ.	2. Шинжлэх ухааны хүрээлэнгүүдийн цогцолборыг олон улсын стандартад нийцүүлж, нээлттэй, салбарын дундын нэгдсэн, төрөлжсөн лабораториудыг байгуулах замаар эрдэм шинжилгээний байгууллага, их дээд сургуулийн судалгааны нэгдмэл байдлыг хангана.	2020 - 2024	94,000.0	“Шинжлэх ухаан, инновацийн төвийн кластер”-ын барилгын бүтээн байгуулалтын ажлыг үргэлжлүүлэх, олон улсын стандартад нийцсэн цогцолборын ажлыг үргэлжлүүлсэн байна.	Монгол Улсын Засгийн 2019 оны 379 дүгээр тогтоолын 1.3-т “Шинжлэх ухааны хүрээлэнгүүдийн цогцолбор” барих, түүний зураг төслийг боловсруулах ажлыг 2020 оноос эхлүүлэхээр тооцон төлөвлөх, хөрөнгийн эх үүсвэрийг улсын төсөвт тусгуулах” гэж заасан. “Шинжлэх ухааны хүрээлэнгүүдийн цогцолбор” төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэйгээр зарлан “Нутгийн буян” ХХК гүйцэтгэгчээр шалгарч, 2020 оноос төсөв хөрөнгийн эх үүсвэрийг тусган барилгын ажлыг эхлүүлсэн. 2020 оны улсын төсөвт 3,0 тэрбум төгрөг, 2021 оны төсөвт 24 тэрбум төгрөг, нийт төсөв 94 тэрбум төгрөгөөр төсөвлөгдсөн. “Шинжлэх ухааны хүрээлэнгүүдийн цогцолбор” нь Улаанбаатар хот, Баянзүрх дүүргийн 12 дугаар хорооны нутаг дэвсгэрт нийт 4,8 га талбайд баригдах ба 74,300 м2 ашиглалтын талбай бүхий үндсэн 7 хэсэг барилга, байгууламжаас бүрдэнэ. Цогцолборын бүтээн байгуулалтын үйл явцын талаарх мэдээллийг Засгийн газрын 2021 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн хуралдаанаар танилцуулсан. Барилга угсралтын ажил санхүүжилт, ажлын графикийн дагуу хэвийн үргэлжилж байна. Кластерын зураг, төсвийг Барилгын хөгжлийн төвөөр магадлуулан 147,5 тэрбум төгрөгөөр шинэчлэн тогтоосон.	100%
83		3. Уламжлалт анагаах ухаан, технологийн хүрээлэнгийн барилгыг барина.	2020 - 2024	40,600.0	Уламжлалт анагаах ухаан, технологийн хүрээлэнгийн барилгын зураг төсвийг батлуулж, барилгын ажлыг эхлүүлсэн байна.	Уламжлалт анагаах ухаан, технологийн хүрээлэнгийн эмнэлэг үйлчилгээ, судалгаа, сургалтын цогцолборын зураг, ТЭЗҮ боловсруулах ажлын хүрээнд: - Барилга хот байгуулалтын яамны 2021-03/109 тоот Тендер шалгаруулалтын кодтай барилгын зургийн тендер зарлагдаж, зураг төсвийн “ТГТ” ХХК шалгарч, 2021 оны 6 дугаар сарын 25-нд 2021/176 тоот тендерийн гэрээ хийгдсэн. Тендерийн өртөг 195 сая төгрөг. Мэдээлэл холбоо сүлжээ ХХК-ний 2021 оны ТН-В773/2021 дугаартай техникийн нөхцөл, Ус суваг ашиглалтын газрын 688/21 дугаартай техникийн нөхцөл, Улаанбаатар Дулааны сүлжээ ТӨХК-ны 325/2021 дугаартай техникийн нөхцөл тус тус гараад байна. Цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-д техникийн нөхцөл гарган авсан.	70%

						Уламжлалт анагаах ухаан, технологийн хүрээлэнгийн эмнэлэг үйлчилгээ, судалгаа, сургалтын цогцолборын зураг, ТЭЗҮ боловсруулагдаж Барилга хөгжлийн төвийн магадлангаар орсон. Нийт барилгын төсөв 25.4 тэрбум төгрөгийн санхүүжилтээр баригдахаар төлөвлөгдсөн.	
84		4. Эрдэм шинжилгээний байгууллага, их сургуулийн хамтарсан судалгааны үндэсний төвүүдийг байгуулж, хөрөнгө, нөөцийг төвлөрүүлнэ.	2020 - 2024	5,100.0	Хамтарсан судалгааны үндэсний төвүүдийг байгуулах боломж, нөхцлийг судалж, санхүүжилт, хөрөнгө оруулалтын тооцоо судалгааг хийсэн байна.	Монгол Улсын Засгийн 2019 оны 379 дүгээр тогтоолын 1.3-т “Шинжлэх ухааны хүрээлэнгүүдийн цогцолбор” барих, түүний зураг төслийг боловсруулах ажлыг 2020 оноос эхлүүлэхээр тооцон төлөвлөх, хөрөнгийн эх үүсвэрийг улсын төсөвт тусгуулах” гэж заасан. “Шинжлэх ухааны хүрээлэнгүүдийн цогцолбор” төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэйгээр зарлан “Нутгийн буян” ХХК гүйцэтгэгчээр шалгарч, 2020 оноос төсөв хөрөнгийн эх үүсвэрийг тусган барилгын ажлыг эхлүүлсэн. 2020 оны улсын төсөвт 3,0 тэрбум төгрөг, 2021 оны төсөвт 24 тэрбум төгрөг, нийт төсөв 94 тэрбум төгрөгөөр төсөвлөгдсөн. “Шинжлэх ухааны хүрээлэнгүүдийн цогцолбор” нь Улаанбаатар хот, Баянзүрх дүүргийн 12 дугаар хорооны нутаг дэвсгэрт нийт 4,8 га талбайд баригдах ба 74,300 м2 ашиглалтын талбай бүхий үндсэн 7 хэсэг барилга, байгууламжаас бүрдэнэ. Цогцолборын бүтээн байгуулалтын үйл явцын талаарх мэдээллийг Засгийн газрын 2021 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн хуралдаанаар танилцуулсан. Барилга угсралтын ажил санхүүжилт, ажлын графикийн дагуу хэвийн үргэлжилж байна. Кластерын зураг, төсвийг Барилгын хөгжлийн төвөөр магадлуулан 147,5 тэрбум төгрөгөөр шинэчлэн тогтоосон. 2022 оны улсын төсөвт барилга угсралттай холбоотой зардлыг тусган санал хүргүүлсэн. БСШУЯ, Нийслэл Өргөө ХХК-тай 2012 онд БУ-135/2012 тоот “Шинжлэх ухааны судалгааны лаборатори, спорт танхим бүхий цогцолборын барилга угсралтын ажил гүйцэтгэх гэрээ”-г байгуулан Баянзүрх дүүрэгт “Байгалийн ухааны нэгдсэн лаборатори”-ийн барилгын ажлыг гүйцэтгэж 2021 онд дуусгахаар ажиллаж байна. Тус барилгад “Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэн” байршуулахаар шийдвэрлэж, холбогдох арга хэмжээг авч ажиллаж байна.	100%
85	2.4.3. Эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг эдийн засаг, нийгмийн хөгжилд өгч байгаа үр өгөөжийг шалгуур болгон санхүүжүүлдэг өрсөлдөөнт тогтолцоонд	1. Их сургууль, эрдэм шинжилгээний байгууллагад технологийн инкубатор, технологи дамжуулах төв байгуулах ажлыг үргэлжлүүлнэ.	2020 - 2024	18,525.0	Шинжлэх ухааны паркийн эрх зүйн байдлын тухай хууль батлагдаж их дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллагын дэргэд технологийн инкубатор,	Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 19 дугаар тогтоолоор Монгол Улсад өндөр технологийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх, шинжлэх ухааны паркийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулах үндсэн чиг үүрэгтэйгээр “Шинжлэх ухааны паркийн захиргаа” шинжлэх ухаан, технологи, үйлдвэрлэлийн нэгдэл байгуулагдаж үйл ажиллагаа хэрэгжүүлж байна. Шинжлэх ухаан, технологи, инновацийн кластер нь олон улсын стандартад нийцсэн нээлттэй, салбар дундын нэгдсэн, төрөлжсөн лабораториудтай байх бөгөөд Шинжлэх ухааны академийн харьяа хүрээлэнгүүд болон бусад их, дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллагуудын 3300 орчим эрдэмтэн судлаач, албан хаагчид ажиллах	90%

	шилжүүлж, нэгдсэн, төрөлжсөн, нээлттэй лабораторийг байгуулан салбарын өрсөлдөх чадварыг дээшлүүлнэ.			технологи дамжуулах төвүүд байгуулагдах ажил эрчимжсэн байна.	хүчин чадалтай шинжлэх ухаан, технологи, инноваци, танин мэдэхүйн төв болох юм. БНХАУ-тай хамтран “Монгол Улсад инкубаторын үйл ажиллагааг хэрэгжүүлэх болон мэдээллийн серверийн бүтээн байгуулалт”, “Хятад-Монголын Технологи дамжуулах төвийн платформыг байгуулах” төслүүдийг хэрэгжүүлж байна. Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй инновацийн дэд бүтэц болох инкубатор төв, дундын оффис, технологи дамжуулах төвүүдийн нэгдсэн судалгааг гаргасан.	
86	2. Салбар дундын нэгдсэн, төрөлжсөн лабораториудыг байгуулах ажлыг үргэлжлүүлнэ.	2020 - 2024	15,200.0	Салбар дундын нэгдсэн, төрөлжсөн лабораториудыг байгуулах ажлыг санхүү, хөрөнгө оруулалтын бодлогоор дэмжиж дэд бүтцийг байгуулах ажлыг эхлүүлсэн байна.	Салбар дундын нээлттэй, сүлжээ лабораторийн үйл ажиллагаа зохицуулах эрх зүйн орчныг боловсронгуй болгох зорилгоор “Салбар дундын нээлттэй, сүлжээ лабораторийн итгэмжлэлийн техникийн шаардлага болон судалгааны нээлттэй, дундын болон сүлжээ лабораторийн стандарт, эрх зүйн зөвлөх үйлчилгээ” сэдэвт судалгааны ажил гүйцэтгэсэн. Монгол улсын эрдэм шинжилгээний байгууллага, их дээд сургууль, хувийн болон үндэсний хүрээлэн төвүүдийн дэргэд судалгааны чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй нийт 54 байгууллагын сургалт, судалгаа, шинжилгээ, хяналтын 311 лаборатори байна. Үүнээс олон улсад болон дотоодод магадлан итгэмжлэгдсэн 24 лаборатори байна. Монгол Улсын Засгийн 2019 оны 379 дүгээр тогтоолын 1.3-т “Шинжлэх ухааны хүрээлэнгүүдийн цогцолбор” барих, түүний зураг төслийг боловсруулах ажлыг 2020 оноос эхлүүлэхээр тооцон төлөвлөх, хөрөнгийн эх үүсвэрийг улсын төсөвт тусгуулах” гэж заасан. “Шинжлэх ухааны хүрээлэнгүүдийн цогцолбор” төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэйгээр зарлан “Нутгийн буян” ХХК гүйцэтгэгчээр шалгарч, 2020 оноос төсөв хөрөнгийн эх үүсвэрийг тусган барилгын ажлыг эхлүүлсэн. 2020 оны улсын төсөвт 3,0 тэрбум төгрөг, 2021 оны төсөвт 24 тэрбум төгрөг, нийт төсөв 94 тэрбум төгрөгөөр төсөвлөгдсөн. “Шинжлэх ухааны хүрээлэнгүүдийн цогцолбор” нь Улаанбаатар хот, Баянзүрх дүүргийн 12 дугаар хорооны нутаг дэвсгэрт нийт 4,8 га талбайд баригдах ба 74,300 м2 ашиглалтын талбай бүхий үндсэн 7 хэсэг барилга, байгууламжаас бүрдэнэ. Цогцолборын бүтээн байгуулалтын үйл явцын талаарх мэдээллийг Засгийн газрын 2021 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн хуралдаанаар танилцуулсан. Барилга угсралтын ажил санхүүжилт, ажлын графикийн дагуу хэвийн үргэлжилж байна. Кластерын зураг, төсвийг Барилгын хөгжлийн төвөөр магадлуулан 147,5 тэрбум төгрөгөөр шинэчлэн тогтоосон. 2022 оны улсын төсөвт барилга угсралттай холбоотой зардлыг тусган санал хүргүүлсэн. БСШУЯ, Нийслэл Өргөө ХХК-тай 2012 онд БУ-135/2012 тоот “Шинжлэх ухааны судалгааны лаборатори, спорт танхим бүхий цогцолборын барилга угсралтын ажил гүйцэтгэх гэрээ”-г байгуулан Баянзүрх дүүрэгт	100%

						“Байгалийн ухааны нэгдсэн лаборатори”-ийн барилгын ажлыг гүйцэтгэж 2021 онд дуусгахаар ажиллаж байна. Тус барилгад “Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэн” байршуулахаар шийдвэрлэсэн.	
87		3. Монгол судлалыг олон улсын болон бүс нутгийн хүрээнд өргөжүүлэх, түгээн дэлгэрүүлэх, бэхжүүлэх цогц арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.	2020 - 2024	1,384.0	Монгол судлалыг хөгжүүлэх Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж ажиллана. Олон улсын монголч эрдэмтдийн 12 дугаар их хурлыг Монгол Улсад зохион байгуулсан байна.	Монгол судлалын үндэсний зөвлөл 2021 оны 3 дугаар сарын 21-ний өдөр хуралдаж, 2020 оны Монгол судлалыг дэмжих үйл ажиллагааны ажлын тайланг дүгнэж, 2021 оны төлөвлөгөөг хэлэлцсэн. Хурлаас гаргасан шийдвэрийг үндэслэн Монгол судлалын үндэсний зөвлөлийн 2021 оны 3 дугаар сарын 23-ны өдрийн “Төлөвлөгөө батлах тухай” 01 тоот тогтоол батлагдсан. 1. Боловсрол, шинжлэх ухааны сайдын “Зардал батлах тухай” 2021 оны 3 дугаар сарын 25-ны өдрийн А/114 дүгээр тушаалыг үндэслэн “Сурагчийн монгол хэлний тайлбар толь”, “Монгол судлалын шилдэг өв” цуврал: Ч.Жүгдэрийн судалгааны бүтээлийн бүрэн ботийг эмхэтгэн хэвлүүлсэн. 2. Гадаадын Монгол судлалын төвүүдийг дэмжих хүрээнд, АНУ-ын Пэннсилванийн их сургууль, БНПУ-ын Варшавын их сургууль, Японы Монгол судлалын нийгэмлэгт ний 72 сая төгрөгийг дэмжлэг үзүүлсэн. 3. “Монгол судлаачид, монгол судлалын үйл ажиллагааг сурталчлах цуврал видео контент бэлтгэн гаргах” ажлыг Монгол хэл, монголын түүх, Монголын нийгэм, улс төр, Монгол соёл, урлаг, Монголын археологи ба хүн судлал сэдвийн хүрээнд цуврал нэвтрүүлгийг “Монсэ медиа” ХХК-тай хамтран нийтийн хүртээл болгосон. 4. Олон улсын Монгол судлалын холбооны хэрэгжүүлж буй “Монгол орон- Монголчууд” төслийн хүрээнд XX зууны эхэн үеийн Монгол орон, монголчуудын ахуй амьдрал, нүүдэл суудал, шашин шүтлэг, хувцас хэрэглэл зэргийг харуулсан түүхэн баримт, гэрэл зургуудаас бүтсэн “Монгол орон, Монголчууд” цувралын долоо дахь номын танилцуулга, номд зориулсан гэрэл зургийн үзэсгэлэн “Монгол арт галерей”-д 2021 оны 07 сарын 04-06-ний өдрүүдэд дэлгэгдэж, төслийн дөрөв дэх удаагийн үзэсгэлэнгээ гаргасан. 5. Шинжлэх ухааны байгууллагын 100 жил, “Алсын хараа-2050” хөгжлийн бодлогын хэрэгжилтийн хүрээнд “Монгол үндэстний нэгдмэл үнэт зүйл” сэдэвт үндэсний хэмжээний эрдэм шинжилгээний хурлыг зохион байгуулж, зөвлөмж гаргалаа. Олон Улсын монголч эрдэмтний их хурал нь Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор Дэлхийн монгол судлалын төв: Монгол улсын нийслэл Улаанбаатар хотод 5 жил тутамд 1 удаа зохион байгуулагддаг, 30 гаруй орны 400 гаруй эрдэмтэн судлаач оролцдог их хурал юм. Уг их хурлыг 1959 оноос эхлэн уламжлал болгон зохион байгуулж ирсэн. Их хурлыг 2022 оны 8 сард хийхээр төлөвлөж байна.	90%

88		4. Шинжлэх ухаан, технологи, инновацийн статистик мэдээлэл, хяналт-шинжилгээ, үнэлгээний тогтолцоог олон улсын нийтлэг шаардлагад нийцүүлэн боловсронгуй болгоно.	2020 - 2024	420.0	Шинжлэх ухаан, технологи, инновацийн чиглэлээр түүвэр судалгаа хийж, мэдээллийн эх үүсвэрийг нэмэгдүүлсэн байна.	Шинжлэх ухаан технологийн салбарын захиргааны болон албан ёсны статистикийн мэдээний маягт (захиргааны 10, албан ёсны 11 маягт), түүнийг нөхөх зааврыг шинэчлэн боловсруулан батлуулж, 2021 онд www.openscience.mn цахим порталаар дамжуулан статистикийн мэдээллийг цуглуулсан. Шинээр батлуулан мөрдөж буй маягтын үзүүлэлтүүдийг ялангуяа хүний нөөцтэй холбоотой индикаторууд буюу судлаачдын насны ангилал, ажлын цагийн мэдээллийг ЮНЕСКО-ийн Статистикийн хүрээлэнгээс улс орнуудын Судалгаа, хөгжүүлэлтийн статистикийн судалгааны маягтын индикатортой уялдуулан боловсруулсан. Ингэснээр манай улсын шинжлэх ухаан, технологийн салбарын статистикийн мэдээлэл олон улсад, нэгдсэн нэг шаардлагад тохирсон үзүүлэлтүүдээр нэгтгэгдэх боломж бүрдсэн.	100%
89		5. Шинжлэх ухааны мэдлэг, инновацийн соёлыг түгээн дэлгэрүүлэх хөтөлбөр хэрэгжүүлж, танин мэдэхүйн агуулга бүхий контент бүтээх ажлыг дэмжих замаар шинжлэх ухаанч соёлыг төлөвшүүлнэ.	2020 - 2024	6,600.0	Шинжлэх ухаан, танин мэдэхүйн цуврал лекц, телевиз, радиогийн нэвтрүүлэг, баримтат кино, аппликейшн бүтээх ажилд дэмжлэг үзүүлж, контентын тоог нэмэгдүүлсэн байна.	<p>Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2021 оны 5 дугаар сарын 12-ны өдрийн А/170 тоот тушаалаар “Монголын инновацийн 7 хоног” арга хэмжээг зохион байгуулах төлөвлөгөөг батлуулсан. Инновацийн үйл ажиллагааг олон нийтэд таниулах, шинэлэг санаа, шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг түгээн дэлгэрүүлэх, төр, хувийн хэвшлийн түншлэл, хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилгоор “Монголын инновацийн 7 хоног” арга хэмжээг 2021 оны 5 дугаар сарын 17-23-ны өдрүүдэд төрийн байгууллага, их сургууль, эрдэм шинжилгээний байгууллага, төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн 30 байгууллага хамтран зохион байгуулсан. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - “Үндэсний инновацийн хөгжил” форум; - “Инноваци ба тогтвортой хөгжлийн зорилтууд” олон улсын цахим үзэсгэлэн; - “International Conference on Innovation and Entrepreneurship Development – 2021” олон улсын эрдэм шинжилгээний хурал; - “Соёлын бүтээлч үйлдвэрлэл – 2021” эрдэм шинжилгээ, онол практикийн бага хурал; - “Best Paper Awards – 2021” залуу судлаачдын эрдэм шинжилгээний бага хурал - Залуу судлаачдын “Эрдэм Хакатон” уралдаан; - Оюутнуудын гарааны бизнесийг шалгаруулах Start-Up Weekend арга хэмжээ - “Инноватор-21” цуврал лекц; - “Инноваци ба хөрөнгө оруулалт” хүнс, хөдөө аж ахуйн салбарын хөрөнгө оруулагчдын уулзалт; - Шинэ технологи, инновацийн бүтээгдэхүүн, сайн туршлагыг орон нутагт түгээн дэлгэрүүлэх цахим сургалт; - Шүлсэнд SARS-CoV-2-ыг илрүүлэх “in-house RT-PCR” оношлуурыг үйлдвэрлэх АШУҮИС-ийн дэргэдэх дэргэдэх “С4А” гарааны компанийн нээлт 	70%

						- ЗГХЭГ-ийн захиалгаар Дэлхийн банкны санхүүжилтээр хэрэгжүүлж байгаа “Инновацийг дэмжих хөтөлбөр”-ийн танилцуулга, гарааны бизнесүүдэд хөрөнгө оруулалт татах DEMODAY арга хэмжээ. -Шинэ технологи, инновацийн бүтээгдэхүүн, үйлчилгээ, эрдэмтэн, судлаачдын сайн туршлага, шинжлэх ухааны мэдлэгийг орон нутагт түгээн дэлгэрүүлэх зорилгоор ХААИС-тай хамтран Аймаг, орон нутагт сургалтууд зохион байгуулагдсан. 2021 оны 7 дугаар сарын 03-06-ны өдрүүдэд “Хоршоолсон хэлбэрээр ногооны аж ахуйг хөгжүүлэх” сургалт, Борнуур, Ерөө, Орхон дахь орон нутгийн иргэдэд “Нөхөн сэргээлтийн таримал сонгох зөвлөх үйлчилгээ”, “Ургамал хамгааллын инноваци” сургалтыг зохион байгуулсан. Олон нийтэд инноваци, энтерпренершипийн боловсрол олгоход чиглэсэн танин мэдэхүйн цуврал лекцийг 2021 оны 7 дугаар сарын 25-27-ны өдөр Говь-Алтай аймгийн Тайшир сум, 8 дугаар сарны 19-20-ны өдөр Дорнод аймгийн Халх гол суманд, Говь-Алтай аймагт “Агро инновацийн төв байгуулах” талбайн сургалтыг 8 дугаар сарын 28-нд Говь-Алтай аймагт зохион байгуулсан.	
ГУРАВ. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО							
90	3.4.6. Баян-Өлгий, Увс, Ховд, Өвөрхангай, Архангай, Баянхонгор, Өмнөговь, Дорнод, Завхан аймгуудад аялал жуулчлалын дэд бүтцийг хөгжүүлж, отоглох цэг, авто зам дагуу үйлчилгээний цогцолборуудыг байгуулна. Говийн бүсийн аялал жуулчлалыг хөгжүүлнэ.	4. Монголын говьд шинжлэх ухаан, тусгай сонирхлын аялал жуулчлалыг хөгжүүлэх MARS-V төслийг хэрэгжүүлнэ. /Survival буюу даван туулж, тэсэж гарах чадвар олгох мэргэжлийнхэн болон сонирхогчдод зориулсан MARS-V академи байгуулах/	2020 - 2024	104,403.7	Сонгогдсон говийн 8 бүсэд нарийвчилсан судалгаа, рекреацийн үнэлгээ хийх гол хамтрагчдыг татан оролцуулна.	Байгаль орчин аялал жуулчлалын яаманд уг төсөл хэрэгжиж байгаа. БОАЖЯ-аас тайлан гаргадаг тул БШУЯ-ыг хасах.	Хяналтаас хасуулах
ДӨРӨВ. ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО							
91	4.2.5. Төрийн албан хаагчийн үйл ажиллагааг үнэлэхдээ ажлын гүйцэтгэл,	3. Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэмд	2021 - 2024		Дүрэмд өөрчлөлт оруулах саналыг холбогдох байгууллагад хүргүүлнэ.	Засгийн газрын 2020 оны 218 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам” болон ЗГХЭГ-ын даргын “Аргачлал, загвар батлах тухай” 2020 оны 100 дугаар тушаалаар батлагдсан аргачлалын дагуу 2021 оны хагас, бүтэн жилийн	90%

	үйлчлүүлэгчийн үнэлгээ, ёс зүй, сахилга хариуцлагыг шалгуур болгож, ёс зүйн зөрчил гаргасан төрийн алба хаагчид хүлээлгэх хариуцлагыг чангатгана.	өөрчлөлт оруулна. Төрийн албаны үнэт зүйл, зарчим, манлайллыг өдөр тутмын үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх талаар сургалт, сурталчилгааны хөтөлбөрийг батлуулж, хэрэгжилтийг хангаж ажиллана.			Төрийн албаны үнэт зүйл, зарчим, манлайллыг хангах талаарх сургалт, сурталчилгааны хөтөлбөрийг батлуулж, хэрэгжилтийг эхлүүлнэ.	гүйцэтгэлийг тайлагнах ажлыг зохион байгуулсан. БШУЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 12 сарын 06-ны өдрийн "Биелэлт дүгнэх, үнэлгээний баг байгуулах тухай" А/169 дүгээр тушаалаар үнэлгээний баг байгуулагдаж, албан хаагчдын гүйцэтгэлийн тайланг үнэлэх ажлыг зохион байгуулж Үнэлгээний баг тайланг үнэлэх ажлыг зохион байгуулж ТНБД-ын 2021 оны "Үр дүнгийн урамшуулал олгох тухай" Б/169 дүгээр тушаалаар яамны албан хаагчдад сүүлийн хагас жилийн урамшуулал олголоо. Үнэлгээг хийхдээ албан хаагчдын үйл ажиллагааны гүйцэтгэл, ёс зүйн манлайллыг тооцон үнэлгээ хийсэн. ЗГ-ын 2019 оны 33 дугаар тогтоолоор батлагдсан Төрийн захиргаан болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг хангах зорилгоор 2021 онд яамн албан хаагчдад ёс зүйн чиглэлээр "Төрийн албан хаагчийн ёс зүй", "Төрийн албаны дипломат ёслол", "Төрийн байгууллагад зан үйлийн менежментийг хэрэгжүүлэх нь" сургалтуудыг зохион байгуулсан.	
92	4.3.2. Дэвшилтэт технологи бүхий камержуулалтын нэгдсэн системийг нэвтрүүлж, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох цогц арга хэмжээг хэрэгжүүлснээр гэмт хэрэг, зөрчлийн гаралтыг бууруулж, нийтийн хэв журам, аюулгүй байдлыг хангана.	2. Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг криминологи дүн шинжилгээ судалгаанд суурилан явуулж гадаад дотоодын байгууллагуудтай хамтран ажиллана. Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдад гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт зохион байгуулах арга хэмжээ авна.	2021 - 2024	50.0	Тодорхой төрлийн гэмт хэргийн криминологи судалгаа хийгдсэн байна. Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдад гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт явуулна.	Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад гэмт хэрэг, зөрчил, гэм буруугийн ойлголт, мэдлэг эзэмшүүлэх талаар "НИЙГМИЙН УХААНЫ СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР"-т дараах хүрээнд эзэмшүүлэх чадварыг хүүхдийн нас сэтгэхүйн онцлогт нийцүүлэн тусган хэрэгжүүлж байна: Үүнд: -Хүмүүсийн харилцаа, хамтын амьдрал, эрх, үүрэг, хариуцлага -Хувь хүн ба нийгэм, Хувь хүн ба хууль -Шударга ёс, Үл ялгаварлан гадуурхах, Шударга ёс ба авлига -Эрх зүй, Иргэний эрх зүйн харилцаа, Иргэн ба төрийн харилцаа, Иргэний эрх зүйн харилцаа -Эрх зүйн зөрчил ба хариуцлага сургалтын хөтөлбөрт тусгасан агуулгын хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх чиглэлээр багшийг чадавхжуулах арга хэмжээг үе шаттай зохион байгуулж байна.	90%
Дундаж үнэлгээ			90,1%				